



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

БОСОО
ХӨНДЛӨН
УЯЛДАА
ХОЛБОО

УХААЛАГ,
ДИЖИТАЛ
ТЕХНОЛОГИ

НОГООН
ХӨГЖИЛ

ТОГТВОРТОЙ
БОДЛОГО,
УДИРДЛАГА

**ХҮНИЙ
ХӨГЖИЛ**

ЧАДВАРЛАГ
ХҮНИЙ
НӨӨЦ

ТЭГШ
ХАМРУУЛАЛТ

НАСАН
ТУРШДАА
СУРАЛЦАХУЙ

ХАМТЫН
ҮҮРЭГ
ХАРИУЦЛАГА

**БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН
ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021-2030



**БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ**

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021-2030

Улаанбаатар хот
2020 он

АХБ-ны Техникийн туслалцааны “МОН 51103-001: Боловсролын салбарын Мастер төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн санхүүжилтээр энэхүү төлөвлөгөөг боловсруулав. Боловсролын Төлөө Дэлхий Нийтийн Түншлэл байгууллагаас Боловсролын салбарын төлөвлөгөө боловсруулахад зориулсан буцалтгүй тусламжийг Дэлхийн Банкаар дамжуулан олгосон болно.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	7
ӨМНӨХ ҮГ	9
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС.....	10
САЙДЫН ТУШААЛ	11
ХУРААНГУЙ	12
НЭГ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАРИМТЛАХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА.....	15
1.1 Монгол Улсын хөгжлийн болон боловсролын бодлого.....	16
1.2 Боловсролын хөгжлийн дэлхий нийтийн чиг хандлага.....	17
1.3 Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн	19
ХОЁР. БОЛОВСРОЛЫН 2021-2030 ОНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ ОРЧИН, ТӨЛӨВ	21
2.1 Монгол Улсын хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, 2030 он хүртэлх төлөв	22
2.2 Боловсролын салбарын нөөц, боломж	26
2.3 Боловсролын салбарт тулгамдаж буй асуудлууд.....	34
2.3.1 Боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалт	34
2.3.2 Хүртээмж ба тэгш хамран сургалт	37
2.3.3 Чанар ба нийц.....	43
ГУРАВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛТУУД	49
3.1 БСХДХТ-ний зорилго	50
3.2 БСХДХТ-ний зарчим	50
3.3 БСХДХТ-ний үндсэн чиглэл	50
3.4 БСХДХТ-ний хамрах хүрээ, хугацаа.....	51
3.5 БСХДХТ-ний зорилтын хураангуй.....	51
ДӨРӨВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЗОРИЛТУУД	55
4.1 Салбарын түвшинд	56
4.1.1 Дэд салбар дамнасан зорилт, хөтөлбөр, үйл ажиллагаа	56
4.2 Дэд салбарын түвшинд.....	61
4.2.1 Сургуулийн өмнөх боловсрол	61
4.2.2 Бага, дунд боловсрол	65
4.2.3 Мэргэжлийн боловсрол, сургалт	71
4.2.4 Дээд боловсрол.....	75
ТАВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	81

ЗУРГАА. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ЗАРДЛЫН ХҮРЭЭ	97
6.1 Боловсролын хэрэгцээний тооцоо	100
6.1.1 Сургуулийн өмнөх боловсрол	100
6.1.2 Бага, дунд боловсрол	102
6.1.3 Мэргэжлийн боловсрол, сургалт	105
6.1.4 Дээд боловсрол.....	107
6.1.5 Насан туршийн суралцахуй.....	109
6.2 Шаардагдах санхүүжилтийн тооцоо	110
6.3 Улсын төсөв ба боловсролын зардал, дутагдах нөөцийн тооцоо.....	115
6.4 Санхүүжилтийн стратеги	116
ДОЛОО. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ	121
7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зохион байгуулалт	122
7.1.1. Хяналт шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчин	122
7.1.2. ХШҮ-ний үйл ажиллагаа	124
7.2. Тулгарч болох эрсдэл, түүнийг бууруулах арга зам.....	126
7.3 Хэрэгжилтийн хяналт, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин.....	128
ХАВСРАЛТУУД	133
Хавсралт 1 Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн уулзалт, хэлэлцүүлэгт оролцогчдын жагсаалт	134
Хавсралт 2 БСХДХТ-ний Үр дүнгийн матриц.....	142
Хавсралт 3 Шаардлагатай санхүүжилтийн тооцоолол (тэрбум төгрөгөөр)	179
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	
Хүснэгт 1. Шаардагдах зардлын санхүүжилтийн тооцоо (тэрбум төгрөг)	13
Хүснэгт 2.1 Сонгосон орнуудын хүн амын тоо, ҮНО, ДНБ, 2018 он, (Дэлхийн банкны орлогын болон бүс нутгийн ангиллаар).....	24
Хүснэгт 2.2 Монгол Улсын ДНБ-ий өсөлт, төсөөлөл.....	25
Хүснэгт 2.3 Хувьсах зардлын бүрэлдэхүүн	26
Хүснэгт 2.4 Хувьсах зардлын норматив, төг, 2018 он	27
Хүснэгт 2.5 Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ сая төг, БСШУС-ын сайдын төсвийн багцад хөрөнгө эзлэх хувь, 2015-2019 он	28
Хүснэгт 2.6 ЕБС-ийн барилга ашиглалтын коэффициент, өмчийн хэлбэр, ангиллаар.....	29
Хүснэгт 2.7 ЕБС-д шаардлагатай бага ангийн болон мэргэжлийн багш нарын тоо	32
Хүснэгт 2.8 Суралцагчийн тооны өсөлтийн таамаглал.....	33
Хүснэгт 2.9 Хүн амын өсөлт, 2018-2030 он.....	33
Хүснэгт 2.10 Хүн амын өсөлт, 2018-2030 он.....	39
Хүснэгт 2.11 Монгол Улсын цэцэрлэгийг ЕСЕMI аргачлалаар үнэлсэн чанарын дэд хэмжүүрийн дундаж оноо (2015)	43

Хүснэгт 6.1	Хувьсах зардлын бүрэлдэхүүн	99
Хүснэгт 6.2	Хувьсах зардлын норматив, төг, 2019 он	99
Хүснэгт 6.3	СӨБ-д хамрагдах хүн амын тоо, 2021-2030.....	100
Хүснэгт 6.4	СӨБ-ын хамран сургалтын хувь.....	100
Хүснэгт 6.5	СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо	100
Хүснэгт 6.6	СӨБ-д хамрагдах хүүхдийн эзлэх хувь, өмчийн хэлбэрээр	101
Хүснэгт 6.7	Төрийн өмчийн СӨБ-д хамрагдах хүүхдийн эзлэх хувь, үйлчилгээний төрлөөр.....	101
Хүснэгт 6.8	СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо	101
Хүснэгт 6.9	Төрийн өмчийн СӨБ-ын байгууллагад ажиллагчдын тооцоо	102
Хүснэгт 6.10	БДБ-д хамрагдах хүн амын тоо, 2021-2030	102
Хүснэгт 6.11	БДБ-ын хамран сургалтын хувь.....	103
Хүснэгт 6.12	БДБ-д хамрагдах хүүхдийн тоо	103
Хүснэгт 6.13	ЕБС-д суралцагчдын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр	104
Хүснэгт 6.14	ЕБС-д суралцах хүүхдийн тоо	104
Хүснэгт 6.15	Төрийн өмчийн ЕБС-д ажиллагчдын тооцоо.....	105
Хүснэгт 6.16	МБС-д хамрагдах насны хүн амын тоо, 2021-2030 он.....	105
Хүснэгт 6.17	МБС-ын хамран сургалтын хувь	106
Хүснэгт 6.18	МБС-д хамрагдах хүүхдийн тоо.....	106
Хүснэгт 6.19	МБС-ын байгууллагад суралцагчдын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр	106
Хүснэгт 6.20	МБС-ын байгууллагад суралцах хүүхдийн тоо	107
Хүснэгт 6.21	Дээд боловсролд хамрагдах хүн амын тоо, 2021-2030	107
Хүснэгт 6.22	Дээд боловсролд хамран сургалтын хувь.....	108
Хүснэгт 6.23	Дээд боловсролд хамрагдах суралцагчдын тоо	108
Хүснэгт 6.24	Дээд боловсролын байгууллагад суралцагчдын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр.....	108
Хүснэгт 6.25	Дээд боловсролын байгууллагад суралцах хүний тоо	108
Хүснэгт 6.26	Бичиг үсгийн сургалтад хамрагдах иргэдийн тоо, 15-24 нас	109
Хүснэгт 6.27	Дүйцүүлэх хөтөлбөрт хамрагдах иргэдийн тоо.....	109
Хүснэгт 6.28	СӨБ-д шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг	110
Хүснэгт 6.29	БДБ-д шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг.....	111
Хүснэгт 6.30	МБС-д шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг	112
Хүснэгт 6.31	Дээд боловсролд шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг	113
Хүснэгт 6.32	Насан туршийн боловсролд шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг....	114
Хүснэгт 6.33	Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагад шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг	114
Хүснэгт 6.34	Боловсролын салбарт шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг	115
Хүснэгт 6.35	ДНБ, улсын төсвийн ДНБ-д эзлэх хувь болон боловсролын салбарын төсвийн улсын төсөвт эзлэх хувийн таамаглал	115
Хүснэгт 6.36	Боловсролын салбарт дутагдах нөөц, эзлэх хувь ба тэрбум төгрөгөөр	116
Хүснэгт 6.37	Хөгжлийн түншүүдийн хөрөнгө оруулалт	117
Хүснэгт 6.38	БСХДХТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, сая төгрөг.....	118
Хүснэгт 6.39	Монгол Улсын боловсролын салбарт шаардагдах санхүүжилт, тэрбум төгрөг.	119

Хүснэгт 6.40	Боловсролын салбарын урсгал болон хөрөнгийн зардал, эзлэх хувь ба тэрбум төгрөгөөр	119
Хүснэгт 7.1	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын бүтэц, орон тоо	122
Хүснэгт 7.2	БШУЯ болон яамны харьяа байгууллагуудын ХШҮ-ний чадавх	123
Хүснэгт 7.3	МБС-ын байгууллагуудын ХШҮ-ний чадавх	124
Хүснэгт 7.4	Түүвэр судалгаа ба үнэлгээ, СӨБ	125
Хүснэгт 7.5	Түүвэр судалгаа ба үнэлгээ, БДБ.....	125
Хүснэгт 7.6	Түүвэр судалгаа ба үнэлгээ, МБС, ДБ.....	125
Хүснэгт 7.7.	ХШҮ-ний үйл ажиллагаа.....	125
Хүснэгт 7.8	Хэрэгжилтийн явцад тулгарч болох эрсдэл, түүнийг бууруулах арга зам.....	127
Хүснэгт 7.9	Салбар дамнасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	128
Хүснэгт 7.10	СӨБ-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	129
Хүснэгт 7.11.	МБС-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	131
Хүснэгт 7.12	ДБ-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	1322

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 2.1.	2030 он хүртэлх сургуулийн насны хүн амын өсөлтийн төлөв, ангиар, мян.хүн...	23
Зураг 2.2	Монгол Улсын хүн амын хотжилтын төлөв, 2050 он хүртэл	24
Зураг 2.3	Нэг хүнд ногдох ДНБ, сая төг, 2010-2018	25
Зураг 2.4	Боловсролын салбарын төсвийн зарлагын динамик	26
Зураг 2.5	Боловсролын салбарын төсвийн бүтэц.....	27
Зураг 2.6.	Нэг хүнд ногдох боловсролын зардал, нэрлэсэн болон бодит үнээр, мян төг, 2008-2018.	28
Зураг 2.7	Хүүхдийн цэцэрлэгийн тоо	30
Зураг 2.8	Төрийн болон хувийн өмчийн сургуульд суралцагчдын тоо	32
Зураг 2.9	Ерөнхий боловсролын сургууль байршил, ангиллаар.....	35
Зураг 2.10	ЕБС-ийн захирлын албан тушаалд шинээр томилогдсон байдал 2007-2019 он	36
Зураг 2.11	Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо	38
Зураг 2.12	Таван настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт	38
Зураг 2.13	Сургуулийн ээлжийн коэффициент ба тархалт 2018-2019 он	39
Зураг 2.14	2030 он гэхэд ЕБС-д шаардлагатай багшийн тоо, хичээл бүрээр.....	40
Зураг 2.15	Бага боловсролын эрэлт, нийлүүлэлтийн хамаарал 2018-2019 он.....	40
Зураг 2.16	Цэцэрлэгт ажиллаж байгаа багш, мэргэжилтнүүдийн ажлын байр 2018 он	44
Зураг 2.17	Мэргэжлийн багшийн хомсдол 2006-2016 он.....	46

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АББ	Албан бус боловсрол
АББЗСҮТ	Албан бус боловсрол, зайн сургалтын үндэсний төв
АМЗҮ	Ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээ
АХБ	Азийн хөгжлийн банк
БАЗТ	Бүсийн арга зүйн төв
БДБ	Бага, дунд боловсрол
БТДНТ	Боловсролын төлөөх дэлхийн нийтийн түншлэл
БДШДТ	Боловсролын дүн шинжилгээний дэлхийн тайлан
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БОУА	Боловсролын олон улсын ангилал
БСГ	Боловсрол, соёлын газар
БСУГ	Боловсрол соёл, урлагийн газар
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БТББ	Боловсролын талаар баримтлах бодлого
БУМС	Боловсролын удирдлага мэдээллийн систем
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БХ	Боловсролын хүрээлэн
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БХИС	Британийн хүүхдийг ивээх сан
ДБанк	Дэлхийн банк
ДБ	Дээд боловсрол
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДБУМС	Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕБГ	Ерөнхий боловсролын газар
ЕХ	Европын холбоо
ЗГ	Засгийн газар
ИДС	Их, дээд сургууль
ИДСК	Их, дээд сургуулиудын консорциум
МБ	Мэргэжлийн боловсрол
МБС	Мэргэжлийн боловсрол сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСБХЗГ	Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын үндэсний зөвлөл
МБСҮТ	Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний төв
МСБ	Мэргэжлийн сургалтын байгууллага
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МХТ	Мэдээлэл харилцааны технологи
ННОС	Нийтийн нээлттэй онлайн сургалт
НТБ	Насан туршийн боловсрол

НТБҮТ	Насан туршийн боловсролын үндэсний төв
НТС	Насан туршдаа суралцахуй
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НҮБХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБХҮС	НҮБ-ын Хүүхдийн сан
НХБ	Насанд хүрэгчдийн боловсрол
НХНҮО	Нэг хүнд ногдох үндэсний орлого
ОУБ	Олон улсын байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
ОУХАН	Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ӨНЭЗС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
ПТК	Политехникийн коллеж
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СӨБГ	Сургуулийн өмнөх боловсролын газар
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
СЯ	Сангийн яам
ТХБ	Тогтвортой хөгжлийн боловсрол
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилт
ТХЭС	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа
ТХХТ	Төр, хувийн хэвшлийн түншлэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАМАТ	Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮМХ	Үндэсний мэргэшлийн хүрээ
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХАА	Хөдөө, аж ахуй
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ХНХСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ЧБ	Чанарын баталгаажуулалт
ЧСС	Чадамжид суурилсан сургалт
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан

ӨМНӨХ ҮГ

Энэхүү бодлогын баримт бичгийг уншин суугаа Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-г баталж Та бүхэнд өргөн барьж байгаадаа таатай байна.

Монгол Улсын боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг боловсролын салбарын төрийн болон төрийн бус өмчийн байгууллага, мэргэжлийн байгууллага, салбарын эрдэмтэн судлаач, багш нарын өргөн бүрэлдэхүүн бүхий баг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, холбогдох хууль, бодлогын бусад баримт бичигтэй нийцүүлэн боловсруулсан. Боловсролын салбарын сүүлийн 10 жилийн үйл ажиллагааны ололт амжилт, бэрхшээл, дутагдлыг судалгаагаар бодитоор гарган дүгнэлт хийж, ирээдүйн хөгжлийн стратеги зорилтуудыг оролцогч талуудтай хамтран дэвшүүллээ.

Төлөвлөгөөг боловсруулахад онцгой дэмжлэг үзүүлэн ажилласан олон улсын байгууллага бол Азийн Хөгжлийн банк юм. 1992 оноос эдүгээ хүртэл манай орны боловсролын салбарын хөгжилд тасралтгүй оюуны болон төсөв, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлж буй Азийн Хөгжлийн банкинд талархал илэрхийлье.

Мөн энэхүү төлөвлөгөөг боловсруулах судалгааны ажил болон боловсруулалтад Боловсролын Төлөө Дэлхийн Нийтийн Түншлэл Байгууллага, Дэлхийн банк, Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, НҮБ-ын ЮНЕСКО, ЮНИСЕФ зэрэг олон улсын байгууллагууд мэргэжлийн болон санхүүгийн туслалцаа үзүүлж ихээхэн идэвх санаачилгатай хамтран ажилласныг энд онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-ний зорилго нь “Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор нь хөгжүүлэх” юм.

Боловсрол, шинжлэх ухааны яам, салбарын байгууллага, албан хаагч, ажилтнууд энэхүү төлөвлөгөөг чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд сэтгэл нэгдэн идэвхи зүтгэлтэй ажиллана.

Та бүхэнд ажлын амжилт, ирээдүйн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
ЛХАГВЫН ЦЭДЭВСҮРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлд:

“XII.5. “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)”-ний талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)”-г дэмжин, уг баримт бичгийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, зохих журмын дагуу батлуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)” баримт бичгийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)” баримт бичгийг хавсралтаар баталсугай.

2. “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-г “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг удирдлагаар хангахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Бодлого төлөвлөлтийн газар /Ж.Ганбаатар/, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Дээд боловсролын газар /Г.Батнэмэх/, Шинжлэх ухааны газар /С.Мөнхбат/ нарт тус тус даалгасугай.

3. Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-г хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нарийвчлан тооцон Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсөвт тусгах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Гадаад хамтын ажиллагааны газар /Д.Гарди/, Санхүү, эдийн засгийн газар /С.Нансалмаа/, Хөрөнгө оруулалтын газар /Ч.Энх-Амгалан/ нарт тус тус даалгасугай.

4. Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-ний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг жил бүрийн 2 дугаар сарын эхний хагаст багтаан танилцуулж байхыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд /Г.Ганбаяр/-д даалгасугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

142010385

ХУРААНГУЙ

Монгол Улсын боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг 1995-2000, 2000-2005, 2006-2015 онуудад тус тус боловсруулан хэрэгжүүлж ирсэн.

“Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-г хэрэгжүүлснээр сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд сургалтын агуулгыг сайжруулах, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, сургалтын таатай орчныг бүрдүүлж, хөгжүүлэхэд ахиц дэвшил гарч бодит үр дүнд хүрсэн. Салбарын хүний нөөцийн чадавхад эерэг өөрчлөлт гарч, мэргэжлийн багшийн хангалт, цэцэрлэг, сургуулийн барилга, байгууламжийн хүчин чадал нэмэгдсэн.

Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлснээр тодорхой үр дүнгүүд гарсан хэдий ч дараах тулгамдсан асуудал хэвээр байна.

- Боловсролын үйлчилгээний чанар
- Хот, хөдөөгийн ялгаатай байдал
- Хүүхдэд ээлтэй тэгш, хүртээмжтэй орчин
- Салбар хоорондын бодлогын уялдаа, бүх талын түншлэл
- Засаглал, удирдлагын тогтолцоо

НҮБ-аас баталсан “Тогтвортой хөгжил 2030” хөтөлбөр, Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө”-г боловсрууллаа.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн “Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчим” болон иргэн бүрд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг олгох, боловсролын бодлогын босоо болон хөндлөн уялдааг хангах, ухаалаг, дижитал

технологийг бүх түвшний боловсрол, сургалтад ашиглах, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн болон үйл ажиллагаанд ногоон хөгжлийг дэмжих зэрэг зарчмуудыг баримтлан төлөвлөгөөг боловсруулсан.

Мөн дараах судалгаа, зөвлөмж, хэлэлцүүлгийн үр дүнд төлөвлөгөөг сайжруулсан.

- Мэргэжлийн багуудын боловсруулсан дэд болон салбар хоорондын уялдаа хамаарлын “Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан”¹, 2019
- “Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ”² олон улсын зөвлөх багийн зөвлөмж, 2020
- Мэргэжлийн багуудын хийсэн “Боловсролын дэд салбаруудын дүн шинжилгээ”-ний тайлан, 2019-2020
- “Боловсролын салбарын хэрэглэгчийн түүвэр судалгаа”-ны тайлан, 2019
- Боловсролын салбарын донор байгууллагуудын хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмж, 2019-2020
- Мэргэжлийн байгууллага, судлаач, багш, эцэг эхийн оролцоо бүхий хэлэлцүүлгүүдээс гарсан санал, зөвлөмж, 2018-2020
- “Боловсролын төлөө дэлхийн нийтийн түншлэл” олон улсын байгууллагын хөндлөнгийн үнэлгээ, зөвлөмж, дүгнэлт, 2020.

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө нь **“Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан мэдлэгт суурилсан нийгэм болон дижитал технологийн эринд ажиллаж амьдрах нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай иргэнийг цогцоор нь хөгжүүлэх”** зорилгыг дэвшүүлж байна.

¹ <https://www.mier.mn/archives/3716>

² Монгол Улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ., ЮНЕСКО.,2020.

Төлөвлөгөөнд боловсролын дэд салбар тус бүрээр бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

- Боловсролын салбарын тогтолцоо, үйлчилгээний чанар, нийцийг сайжруулах;
- Боловсролын үйлчилгээний тэгш хүртээмж, хамран сургалтыг нэмэгдүүлэх;

- Засаглал, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

Тэргүүлэх чиглэлийн хүрээнд 15 зорилт, 47 хөтөлбөр, 254 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Боловсролын салбарт 2021-2025 онд нийт 16,405.8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна.

Хүснэгт 1. Шаардагдах зардлын санхүүжилтийн тооцоо (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2021-2025	2021	2022	2023	2024	2025
ДНБ		42,660.9	46,851.9	51,931.3	56,472.0	61,647.1
Боловсролын салбарт шаардагдах нийт зардал Үүнээс:	16,405.80	2,997.9	2,940.9	3,218.3	3,469.0	3,779.7
ДНБ-д боловсролын салбарт улсын төсвөөс зарцуулах зардлын эзлэх хувь		4.7%	4.9%	5.1%	5.3%	5.4%
Улсын нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь		15.4%	15.9%	16.4%	16.8%	17.3%
Боловсролын салбарт шаардагдах нийт санхүүжилт	16,051.90	2,943.3	2,881.5	3,147.1	3,390.9	3,689.1
БСХДХТ-ний хэрэгжилтийг хангахад нэн шаардлагатай зардал	353.9	54.6	59.4	71.2	78.1	90.6
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр Үүнээс:						
Улсын төсвийн санхүүжилт	13,274.50	2,015.3	2,300.2	2,641.0	2,965.2	3,352.8
Нийт зардалд улсын төсвийн санхүүжилтийн эзлэх хувь	80.80%	67.2%	78.2%	82.1%	85.5%	88.7%
Нийт шаардлагатай	3,131.30	982.6	640.7	577.3	503.8	426.9
БСХДХТ-ний хэрэгжилтийг хангахад нэн шаардлагатай санхүүжилт	353.9	54.6	59.4	71.2	78.1	90.6
Нэмэх шаардлагатай санхүүжилт	2,261.40	928.0	581.3	506.1	425.7	336.3

Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжсэнээр 2030 онд дараах үр дүнд хүрэх юм. Үүнд:

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын I үе шат (2021-2030)-ны “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог шинэчлэх” зорилтын хэрэгжилт хангагдсан байна.
2. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх” зорилтыг хэрэгжүүлсэн байна.
3. Боловсролын салбарын тогтолцоо, үйлчилгээний чанар, нийцийг сайжруулсан байна.
 - Бүх түвшний сургалтын хөтөлбөрийн агуулгыг эх оронч сэтгэлгээ, монгол уламжлал соёлыг дээдэлсэн, хүмүүжил, төлөвшил, хувь хүний болон шинжлэх ухааны эрэл хайгуул хийх ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр залгамж холбоотойгоор шинэчилж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлсэн байна.
 - Бүх түвшний багш, удирдах ажилтны мэргэжлийн ур чадвар, тасралтгүй хөгжих боломжийг бий болгох уян хатан сургалтын хэлбэрүүдийг нэмэгдүүлж, мерит зарчимд тулгуурласан хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлж, цалин хөлс, нийгмийн баталгаа сайжирсан байна.
4. Боловсролын үйлчилгээний тэгш хүртээмж, хамран сургалтыг нэмэгдүүлсэн байна.
 - Хүн амын өсөлт, боловсролын үйлчилгээний тэгш хүртээмжтэй уялдуулан сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлж, нээлттэй боловсролын үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сургалтын тохируулгат орчныг бий болгосон байна.
 - Технологи, инновацийн шинэчлэлтэй уялдуулан боловсролын цахим шилжилт хийж, бүх насны иргэдийн насан туршдаа тасралтгүй суралцахуйн уян хатан тогтолцоо бэхэжсэн байна.
 - Боловсролын үйлчилгээг иргэний хөгжлийн онцлог, газарзүйн байршил, амьдралын хэв маягаас үл хамааран тэгш чанартай хүртэх боломжийг бүрдүүлсэн байна.
5. Боловсролын засаглал, удирдлага зохион байгуулалтыг оновчтой болгосон байна.
 - Мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагын засаглал, удирдлагын хараат бус, бие даасан үндэсний түвшний тогтолцоо бүрдсэн байна.
 - ЕБС-ийн төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, бодлогын хэрэгжилтийн үр дүнг сайжруулах чиглэлээр сургуулийн бүтэц, хэв шинжийн зураглалыг орон нутгийн хүн амын өсөлт, эдийн засаг хөгжлийн тэргүүлэх чиглэл, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, төрөлжсөн ахлах сургуулийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн байна.
 - Боловсролын бүх түвшинд чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын тогтолцоог өргөжүүлсэн байна.

---оОо---



НЭГ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАРИМТЛАХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА

- Монгол Улсын хөгжлийн болон боловсролын бодлого
- Боловсролын хөгжлийн дэлхий нийтийн чиг хандлага
- Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн

НЭГ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД БАРИМТЛАХ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА

1.1 МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОЛОН БОЛОВСРОЛЫН БОДЛОГО

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын³ “Хүний хөгжил” зорилгыг “Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ” гэж тодорхойлж боловсролын зорилтыг үе шаттай хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн байна.

1-р үе шат (2021-2030) буюу Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе шат-д:

Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг 1-3, 4-6 настай хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын хэмжээг үндэслэн жил бүр шинэчлэн тогтоох, малчин, шилжин суурьшигч, орлого багатай өрхийн, ялгаатай болон тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол тэгш олгох боломж, орчин нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн эцэг эх, асран халамжлагчдыг чадавхжуулах замаар тэдний оролцоонд түшиглэсэн хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг төлөвлөсөн.

БДБ-ын түвшинд боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулах, бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр,

агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлэх, суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг тогтмол хийж үр дүнд үндэслэн бодлого, төлөвлөлт хийж хэвших зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэж, 2030 онд үндэсний ажиллах хүчний хэрэгцээг мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнээр бүрэн хангах зорилт дэвшүүлсэн.

Мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагуудыг олон улсын шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийн болон ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн хамтын ажиллагааг бэхжүүлж, хичээлийн 20-оос доошгүй багц цагийг дадлагын хөтөлбөрт шилжүүлэн, сургалтын хөтөлбөрийг сайжруулна.

Шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжилд дээд боловсролын сургалтын байгууллагуудын оруулах хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлж, орон нутаг дахь бүс нутгийн онцлог, эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан өрсөлдөх чадвартай үндэсний судалгааны их сургууль байгуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн.

Нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

³ Монгол Улсын Их хурлын 2020 оны 52-р тогтоол

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)-ын хэрэгжилтийг хангана. Уг бодлогын баримт бичигт “Иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах” гэсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

Боловсролыг хөгжүүлэх бодлого, стратеги, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, судлаач, иргэний оролцоог хангах;

Боловсролын талаар шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, ил тод, судалгаа, нотолгоонд суурилсан, сайн засаглалын зарчимд нийцсэн байх;

Боловсролын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг бүтэц, байршил, онцлог хэв шинжид уялдуулан уян хатан тогтоож байх;

Боловсролын удирдлагын бүх түвшинд төрийн болон орон нутгийн, мэргэжлийн, олон нийтийн төлөөллийн байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны зааг ялгаа, уялдаа холбоог тогтоож, эрх зүйн хувьд баталгаажуулах;

Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг өргөтгөх.

Дээрх зорилтуудын хүрээнд СӨБ-д олон хувилбартай үйлчилгээний хэлбэрт түшиглэн

хүүхэд бүрийг СӨБ-д хамруулах, тэдэнд хувь хүний онцлогтоо тулгуурлан бүтээлч үйлээр хөгжих боломж олгоход чиглэсэн цөм хөтөлбөр хэрэгжүүлэх, үндсэн зардлыг төрөөс, хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагчтай хуваалцах бодлогыг дэвшүүлж, зарим бодлогыг⁴ амжилттай хэрэгжүүлж байна.

БДБ-ын хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шатлал, бүтцийг баримтлах, уян хатан хөтөлбөрөөр суралцах, цөм хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой бодлогыг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

МБС-ын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, технологийн дэвшилтэй уялдуулан боловсруулж, сургалтад нэвтрүүлэн, чанарын баталгаажилт, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэлийг амжилттай хэрэгжүүлсэн. Мөн МБСБ-ыг төрөлжүүлэн кампус хэлбэрээр хөгжүүлэх, мэргэшлийн түвшний тогтолцоог бүрдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлж байна.

Дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд баримжаалах, судалгааг хөгжүүлэх, олон улсын нийтлэг жишгийн дагуу сургалтын төрөл бүрийн арга хэлбэрийг хөгжүүлэх, чанарын баталгаажилт, олон улсын хамтарсан сургалтын хөтөлбөр, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөхийг дэмжин хэрэгжүүлж байна.

БСХДХТ 2021-2030 нь Алсын хараа 2050 болон Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын дэд зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, 2025 болон 2030 онд товлосон үр дүнд хүрэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2 БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ДЭЛХИЙ НИЙТИЙН ЧИГ ХАНДЛАГА

Боловсролын хөгжлийн дэлхий нийтийн чиг хандлагыг НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын төрөлжсөн байгууллага ЮНЕСКО, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын боловсролын

талаар баримталж буй чиглэл, олон улсын санаачилгуудад үндэслэн тодорхойллоо. ЮНЕСКО-ийн 2030 он хүртэл боловсролыг хөгжүүлэх гол стратегийн нэг бол Инчеоны тунхаглал 2030 юм.

⁴ Цөм хөтөлбөр, орчны стандарт, олон хувилбарт СӨБ-ын үйлчилгээ гэх мэт

Инчеоны тунхаглал 2030

Энэхүү тунхаглалд насан туршдаа суралцахуйн чанартай боломжуудыг бүх иргэдэд, бүх орчин нөхцөлд, боловсролын бүх түвшинд бүрдүүлэхийг хөхиүлэн дэмжсэн. Үүнд чанарын баталгаажуулалтад зохистой анхаарал хандуулах замаар мэргэжлийн болон дээд боловсрол ба судалгааны тэгш хүртээмж, чанарыг дээшлүүлэх асуудлыг тусгасан. Суралцахуйг уян хатан болгож, албан бус боловсролоор эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамжийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулан, гэрчилгээтэй болгох нь ач холбогдолтой. Тус тунхаг бичигт чанартай боловсрол, суралцахуйн үр дүнг сайжруулахыг онцлон тэмдэглэсэн ба ахиц дэвшлийг үнэлэхийн тулд орц нөөц, үйл явц, үр дүнгийн үнэлгээ, холбогдох механизмуудыг бэхжүүлэх шаардлагатай талаар онцолсон байдаг. Тунхаглалын хүрээнд багш, сурган хүмүүжүүлэгчдийг чадавхжуулах, сонгон шалгаруулах, сургалт, мэргэжлийн ур чадвар, сэдэлжүүлэх үйл явцыг зохистой хөрөнгө нөөц, үр ашигтай, үр дүнтэй удирдлагатай системийн хүрээнд бүрдүүлэхийг зөвлөсөн байна. Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд сургуульд бэлтгэх нэг жилийг үнэ төлбөргүй, чанартай үйлчилгээг заавал бүрдүүлэх талаар боловсролын бодлогод тусгахын зэрэгцээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зэрэг эмзэг бүлгүүдэд түлхүү анхаарахыг зөвлөсөн байна.

ЮНЕСКО-гийн Насан туршийн боловсролын хүрээлэн⁵ “Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын дэлхийн тайлан”⁶ болон “Боловсролын дүн шинжилгээний дэлхийн тайлан-2016”⁷-д “*насан туршдаа суралцахуй нь хувь хүн, иргэн, нийгэм хийгээд ажил эрхлэлтийн хүрээнд мэдлэг, ур чадвар, чадамжаа дээшлүүлэх зорилгоор амьдралынхаа туршид суралцах бүхий л үйл ажиллагааг багтаасан ойлголт юм*” хэмээн тодорхойлжээ⁸. Эхний баримт бичигт

“насан туршийн боловсрол”, “насан туршдаа суралцахуй” гэсэн хоёр нэр томъёог хослуулан хэрэглэж байсан бол Боловсролын дүн шинжилгээний дэлхийн тайлан-2016-д “насан туршдаа суралцахуй” гэсэн нэр томъёог түлхүү ашигласан байна. Учир нь “суралцахуй” нь хувь хүн өөрөө боловсрол эзэмших, ямар арга хэлбэрээр суралцах гэсэн хандлагын үүднээс ЮНЕСКО-гийн боловсролын бодлого, баримт бичгүүдэд “насан туршдаа суралцахуй” гэх нэр томъёог хэрэглэж байна. ЮНЕСКО-гийн Насан туршийн боловсролын хүрээлэн “насан туршдаа суралцахуйд түшиглэсэн боловсролын тогтолцоо (lifelong learning-oriented education systems)” гэсэн хандлагыг баримталж байна⁹.

Боловсролын ирээдүйн хөгжлийг тодорхойлох дэлхий нийтийн өөр нэг хандлага нь Ирээдүйн боловсрол санаачилга юм. Энэ санаачилга нь боловсролыг шинэ өнцгөөс харж, ирээдүйн дүр төрхийг тодорхойлох зорилго бүхий хүн төрөлхтний нэгдмэл оюун ухааныг хөгжлийн хөдөлгөгч хүч болгох үүднээс хүн болохуй, сурч мэдэхүйн олон арга замыг хөгжүүлж, бэхжүүлэх юм.

Боловсролын ирээдүйн энэ санаачилга нь хүн төрөлхтний нэгдмэл оюун ухааны хөдөлгөгч хүч болох хүн болохуй, сурч мэдэхүйн олон янзын, олон талт арга замыг хөдөлгөөнд оруулах, идэвхжүүлэх зорилготой юм. Хүн болохуйн төлөө суралцах үзэл баримтлал нь суралцахуйг тасралтгүй үргэлжлэх насан туршийн үйл явц болохыг илтгэдэг боловсролын зарчим, сурган заах аргачлалыг илэрхийлж буй юм. “Хүн болохуй” (becoming) гэх нэр томъёо нь хүмүүний хөгжлийн потенциалыг онцлон анхаарч, хуучинсаг үзлийг халж, шинэ зүйлсэд уян хатан, нээлттэй байх сэтгэлгээг хөхиүлэн дэмжих зорилготой. Хүний хүчин зүйлсээс үүдэн эх дэлхий өөрчлөгдөж, улмаар нийгмийн суурь бүтэц, хүмүүсийн ухамсар

⁵ UNESCO Institute for Lifelong Learning [UIL] 1950 онд ЮНЕСКО-ийн Боловсролын Хүрээлэн нэрээр байгуулагдсан, 2006 онд Насан туршийн боловсролын хүрээлэн болж өөрчлөгдсөн

⁶ GRALE-Global Report on Adult Learning and Education

⁷ Global Education Monitoring Report- GEM Report

⁸ ЮНЕСКО. (2016). Боловсролын дүн шинжилгээний дэлхийн тайлан

⁹ АХБ, БШУЯ. (2019). Насан туршийн боловсролын шинжилгээний тайлан

болон онцлог хэв шинжүүд эрс өөрчлөгдөх хандлагыг бид хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрч байгаа тул, хүн төрөлхтөн бид ямар болохыг хүсэж байгаа вэ? гэсэн асуултад анхаарал хандуулах шаардлага гарч байна.

ЭЗХАХБ-ын **Ирээдүйн боловсрол ба ур чадвар – 2030** баримт бичиг нь орчин үед шинэ тутам хэдий ч ирээдүйн боловсролын тогтолцоонд “хэвшиж тогтох” хандлагатай байгаа шинэлэг хэв шинжүүдийг онцолсон байдаг. Сургуулиуд дор бүрнээ тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг хаалттай нэгж бус бүхэл бүтэн экосистемийн нэг хэсэг болж байна. Сургуулиуд хамтран бүлэг нөхөрлөл, сүлжээ байгуулж, түншлэлийн зарчмаар ажилладаг болж байгаа ба шинжлэх ухааны байгууллага, театр, музей, их, дээд сургууль, нийгмийн үйлчилгээний байгууллага, технологийн болон бизнесийн компанитай хамтран ажиллах нь нэмэгдэж байна. Ингэснээр багш, суралцагчдын хөдөлмөрийн болон боловсролын зах зээлд шаардлагатай ур чадвар, чадамжийн талаарх мэдлэг, хандлага өөрчлөгдөж байна. Эцэг эхчүүд, ажил олгогчид, иргэд, суралцагчид зэрэг боловсролын оролцогч талууд бодлогын шийдвэр гаргахад оролцож, тухайн шийдвэрийн хэрэгжилтэд хамтын хариуцлага хүлээх байдал нэмэгдэж байна. Сургуулийн

үйл ажиллагааны үр дүн, чанарыг үнэлэх аргачлал нь зөвхөн “үр дүн”-ээс гадна “үйл явц”-ыг чухалчилж, суралцагчдын гүйцэтгэл ба сурлагын амжилт, суралцахуйн ач холбогдлыг авч үзэж буй хандлагыг тэмдэглэсээр байна.

Суралцагчдын академик гүйцэтгэлээс гадна тэдний өв тэгш хөгжил, төлөвшилд анхаарал хандуулах боллоо. Хөтөлбөрийн бүтэц ба суралцахуйн арга нь шугаман бус шинж чанартай болж, ахиц дэвшилд түлхүү анхаарч байна. Суралцагч бүр өөрийн гэсэн суралцах арга барилтай, сургуульд элсэх үед өмнөх мэдлэг, чадвар, хандлага нь харилцан адилгүй байдгийг хүлээн зөвшөөрдөг болжээ. Сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг авч үзэхдээ “хөтөлбөрийг шинэчлэх, дахин боловсруулах” гэхээс илүүтэй “хөтөлбөрийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх менежмент”-д түлхүү анхаарч байгааг тусгажээ. ЭЗХАХБ-ын гишүүн улс орнууд сургалтын хөтөлбөрт өөрчлөлт хийхдээ өөрчлөлтийн менежментийн томоохон системийн нэг бүрэлдэхүүн болгон авч үзэх, хөтөлбөрийн өөрчлөлтийг заах арга зүй ба үнэлгээтэй уялдуулах, багш бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх сургалттай уялдуулах, ингэхдээ удирдах ажилтнуудыг хамруулах хэрэгтэй гэдэгтэй бүрэн санал нэгдэж байна.

1.3 БОЛОВСРОЛЫГ 2006-2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Боловсролын бодлогын залгамж холбоо, тогтвортой хөгжлийг хангах үүднээс дээр дурдсан томоохон бодлого, чиг хандлагуудаас гадна БСХДХТ-д зайлшгүй авч үзэх шаардлагатай баримт бичгийн нэг нь “Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” юм. Уг төлөвлөгөөнд бага насны хүүхдийн боловсрол, ерөнхий боловсрол, албан бус буюу насанд хүрэгчдийн боловсрол, мэргэжлийн сургалт, техникийн боловсрол, дээд боловсрол, дэд салбар дундын хүрээний зорилтуудыг төлөвлөн хэрэгжүүлсэн. Үүнд:

СӨБ-ын түвшинд дэвшүүлсэн зорилтуудын

52 хувь нь бүрэн хэрэгжсэн, 36 хувь нь тоон зорилтдоо хүрч хэрэгжээгүй, 11 хувь нь хэсэгчлэн хэрэгжсэн гэсэн үзүүлэлттэй байна¹⁰. СӨБ-ын хүртээмж, бүлэг дүүргэлт, цэцэрлэгийг 100 хувь мэргэжлийн багшаар хангах, нийт багшийн 50 хувийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахтай холбоотой зорилтууд төдийлөн сайн хэрэгжээгүй байна.

Бага, дунд боловсролын чанартай холбоотой 18 зорилтын 38.9 хувь нь бүрэн биелсэн, 16.7 хувь нь хэрэгжилт хангалтгүй, менежменттэй холбоотой зорилтын 50.0 хувь нь хэрэгжээгүй байна.

¹⁰ АХБ, БШУЯ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

Тухайлбал ерөнхий боловсролын сургууль завсардсан сурагчдын 40 хувийг албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгох¹¹, ЕБС-ийн байршил, бүтэц, хэв шинжийг тогтоох стратегийн бодлого, төлөвлөлт бий болгох гэсэн зорилтууд хэрэгжээгүй байна¹².

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын 18 зорилтоос 70.6 хувь нь бүрэн биелсэн, 23.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 5.9 хувь нь хэрэгжээгүй байна.

Дээд боловсролын хувьд инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр суралцагчдын эзлэх хувийн жинг 29.1 хувиас 45.0 хувь болгож өсгөх, бусад мэргэжлийн чиглэлээр суралцагчдын эзлэх хувийн жинг 38.9 хувиас 34.0 хувьд хүргэх гэсэн зорилтуудыг тусгасан ч бүрэн хэрэгжээгүй байна.

Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд албан бус ба насанд хүрэгчдийн боловсролын асуудлыг бие даасан бүлэг болгон дараах зорилтыг дэвшүүлжээ. Үүнд:

- Албан бус боловсролын үйлчилгээг хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэх;
- Албан бус боловсролын бүх түвшинд сургалтын орчин, чанарыг сайжруулж, нөөцийн чадавхыг дээшлүүлэх;
- Албан бус боловсролын салбарын бодлого, стратегийг боловсронгуй болгож, мэдээлэл, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;
- Бичиг үсэгт тайлагдалтын түвшнийг 2008 он гэхэд 97.7-99.0 хувьд хүргэх;
- ЕБС-аас завсардсан сурагчдын 40.0 хувьд албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгох;
- Албан бус боловсрол, зайн сургалтын үндэсний төв, сум, дүүргийн албан бус боловсролын төвийн санхүүжилтийг жил тутам 8.0 хувиар өсгөх;

- Багшийн мэргэжлийг дээшлүүлэх зардлыг мэргэжил дээшлүүлэх нэгдсэн зардалд тусган, жил бүр санхүүжүүлэх;
- Мэдээлэл, хяналт-шинжилгээний үндэсний систем бий болсон байх;

2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар насан туршийн боловсролын үйлчилгээний үндсэн 6 чиглэл нэмэгдээгүй, багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдээгүй, зориулалтын барилга байгууламжгүй, бие даасан санхүүжилтгүй, мэдээллийн сан бүрдээгүй¹³, хяналт, шинжилгээний системгүй байгаа нь дэвшүүлсэн зорилт бүрэн хэрэгжээгүйг илтгэж байна.

Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөний зорилтууд бүрэн хэрэгжээгүй ч СӨБ, БДБ, МБС болон дээд боловсролын түвшинд сургалтын агуулгыг оновчтой болгох, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, сургалтын таатай орчин бүрдүүлэх, удирдах болон багшлах боловсон хүчний хангамж, чадавхыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гарсан.

Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг яамны бодлого, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байсан ч эцсийн үр дүн, хэрэгжилтийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийгээгүй байна.


Иймд “Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”-г амжилттай хэрэгжүүлэхэд салбарын бүх түвшний байгууллагын бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий зөвлөл /ажлын хэсэг/ ажиллуулах нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.

Төлөвлөгөөг боловсруулах үндсэн судалгаанууд 2018, 2019 онуудад хийгдэж, 2018-2019 оны хичээлийн жилийн үзүүлэлтүүдийг суурь болгосон болно.

¹¹ 2015-2016 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр ЕБС-иас завсардсан сурагчдын 8.9%-ийг дүйцсэн хөтөлбөрийн болон орой, эчнээ сургалтаар боловсрол нөхөн олгосон байна.

¹² 2015-2016 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр ЕБС-иас завсардсан сурагчдын 8.9%-ийг дүйцсэн хөтөлбөрийн болон орой, эчнээ сургалтаар боловсрол нөхөн олгосон байна.

¹³ АХБ, БШУЯ. (2019). Насан туршийн боловсролын шинжилгээний тайлан



ХОЁР. БОЛОВСРОЛЫН 2021–2030 ОНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ ОРЧИН, ТӨЛӨВ

- Монгол Улсын хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, 2030 он хүртэлх төлөв
- Боловсролын салбарын нөөц болон боломж
- Боловсролын салбарт тулгамдаж буй асуудлууд

ХОЁР. БОЛОВСРОЛЫН 2021-2030 ОНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ ОРЧИН, ТӨЛӨВ

2.1 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, 2030 ОН ХҮРТЭЛХ ТӨЛӨВ

Хүн ам зүй

2018 оны байдлаар Монголын Улсын хүн амын тоо 3,238,479-д хүрсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад нийт хүн ам 1.9 хувь буюу 61.6 мянгаар өссөн дүнтэй байна. Хүн амын 49.6 хувийг эрэгтэйчүүд, 50.4 хувийг эмэгтэйчүүд, 32.6 хувийг 15 хүртэлх насны хүүхдүүд, 63.9 хувийг 15-64 насны хүн ам, 3.5 хувийг 65 ба, түүнээс дээш насны хүн ам эзэлж байгаа ба нийт хүн амын 63.7 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байна. 2018 оны байдлаар нийт хүн амын 3.3 хувь буюу 105,730 иргэн хөгжлийн бэрхшээлтэй бөгөөд тэдний 33.7 хувь нь Улаанбаатар, үлдсэн нь хөдөө орон нутагт амьдарч байна¹⁴. Хүн амын төвлөрөл нийслэл хотод их, нийт хүн амын 53.4 хувь нь хот суурин газар, 46.6 хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна¹⁵. Хөдөө, орон нутагт нийт 1,588.9 мянган хүн амьдарч байгаагийн 483.0 мянга нь сумын төвд, 667.1 мянга нь алслагдмал нутагт амьдарч байна¹⁶. Тодруулбал, сумдын 51.7 хувь нь харьцангуй жижиг буюу 3,000-аас доош хүнтэй, 30.1 хувь нь 3,000-5,000 хүнтэй, 8.5 хувь нь 5,001-7,000 хүнтэй бол 9.7 хувь нь 7,001-ээс дээш тооны хүн амтай байна.

1990 оноос хойш нялхсын болон хүүхдийн эсэн мэнд амьдрах чадвар сайжирсны үр дүнд дундаж наслалт 60.3 хувь байснаас 2018 онд 69.5 хувь болж өссөн эерэг үзүүлэлттэй байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох дундаж наслалтын ялгаа жил ирэх тутам нэмэгдэж, 9 жилийн зөрүүтэй

болсон (эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66, эмэгтэйчүүдийнх 75) нь дундаж наслалтын индексийн өсөлт бага байгаад нөлөөлж байна¹⁷.

2010 оны хүн амын тооллогын мэдээгээр арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшнийг насны бүлгээр авч үзвэл, 20-40 насныхан дотор бүрэн дунд боловсролтой хүн амын эзлэх хувь өндөр боловч дээд боловсролтой хүн амын эзлэх хувь 35 наснаас хойш буурсан байна. Энэ төлөв хэвээр хадгалагдвал насанд хүрэгчид, тэр тусмаа идэр насныхны боловсролын хэрэгцээ цаашид өсөх хандлагатай болно¹⁸.

Хүн амын өсөлтийн хэтийн шинэчилсэн тооцооллоор¹⁹ 2018 онтой харьцуулахад 2025 онд хүн амын тоо 13.1 хувиар нэмэгдэж 3,662,221, 2030 онд 18.01 хувиар өсөж 3,950,052 болохоор²⁰ байна. Энэ өсөлт нь Улаанбаатар хотод илүү өндөр байх төлөвтэй байна. Насны бүлгээр авч үзвэл 2019 оноос 2030 онд 2-5 насны хүүхдийн өсөлт 0.4 хувь, 6-14 насны хүүхдийн өсөлт 26 хувь, 15-17 насны хүүхдийн өсөлт 84.8 хувь, 18-22 насны хүн амын өсөлт 46.6 хувьтай өсөх төлөвтэй байна²¹. Гэхдээ 2030 оноос эхлэн энэ өсөлт, тухайлбал 5-14 насны хүн амын тоо буурах хандлагатай байна²².

¹⁴ ҮСХ-ны 1212.mn вэбсайт

¹⁵ ҮСХ-ны 1212.mn вэбсайт

¹⁶ АХБ, БШУЯ. (2019). Насан туршийн боловсролын шинжилгээний тайлан

¹⁷ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан


¹⁸ АХБ, БШУЯ. (2019). Насан туршийн боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

¹⁹ ҮСХ-ны 1212.mn вэбсайт

²⁰ Хүн амын насаар нь ангилсан өсөлтийн 2030 он хүртэлх таамаглалыг ҮСХ-ны 2018 он хүртэлх түүхэн өгөгдөл дээр тулгуурлан загварчилж, тооцоолж гаргасан.

²¹ БШУЯ-ны БУМС-ийн мэдээллийг ашиглан ЮНЕСКО-ийн EPSSim 2.9b-д тооцоолов.

²² ҮСХ-ны хүн амын хэтийн шинэчилсэн тооцоо, 1212.mn



Зураг 2.1. 2030 он хүртэлх сургуулийн насны хүн амын өсөлтийн төлөв, ангиар, мян.хүн

2018 оны байдлаар Монгол Улсын хүний хөгжлийн индекс 0.740, боловсролын түвшний индекс 0.721, дундаж наслалтын индекс 0.722, нэг хүнд ногдох үндэсний нийт орлогын индекс 0.727 байгаа нь хөгжлийн дээд түвшний ангилалд²³ багтаж буйг илэрхийлнэ.

Харин жендэрийн тэгш бус байдлын индекс 0.289 байгаа²⁴ нь Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрх мэдэл болон хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоонд тэгш бус байдал байгааг харуулж байна.

Нийгмийн нөхцөл байдал

Үндэсний Статистикийн хорооны 2018 оны мэдээгээр ядуурлын хамрах хүрээ 28.4 хувь ба үүнээс хотод 27.2 хувь, хөдөөд 30.8 хувьтай байна. Ядуурлын гүнзгийрэл хот, хөдөөд ижилхэн 7.2 хувьтай байна.

ҮСХ-ны 2019 оны 3 дугаар сарын байдлаар нийт хүн амын 35.7 хувь нь ажиллагчид ба ажиллах хүчний оролцооны түвшин 60.1 хувь байна. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.2 хувь, ажилгүйдлийн түвшин 9.9 хувьтай байна. Ерөнхийдөө ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.6 пункт, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 1.3 пунктээр тус тус өсөж, ажилгүйдлийн түвшин 1.2 пунктээр буурсан үзүүлэлттэй

байна²⁵. Нийт ажилгүй хүн амын тоо 88,907 бөгөөд тэдгээрийн 62.1 хувийг эрэгтэйчүүд, 37.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна²⁶. Эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбарт ажиллагчдын дотор бүрэн дунд боловсролтой хүн амын тоо өндөр (17.2 - 49.3 хувь), ялангуяа хөдөө аж ахуй, ойн аж ахуйд ажиллагчдын дотор суурь (бүрэн бус дунд) болон бага боловсролтой хүн ам 26.4-33.4 хувь, боловсролгүй хүн ам 11.2 хувийг эзэлж байгаа нь нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн дийлэнх нь мэргэжилгүй хүмүүс болохыг илэрхийлж байна²⁷. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн 2018 оны тайлангаас²⁸ үзэхэд боловсрол, сургалтын

²³ UNDP. (2018). Human Development Indices and Indicators Report

²⁴ ҮСХ-ны 1212.mn вэбсайт

²⁵ ХНХСИ. (2018). Хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа


²⁶ ҮСХ-ны 2019 оны статистик мэдээллийн тайлан

²⁷ АХБ, БШУЯ. (2019). Насан туршийн боловсролын шинжилгээний тайлан

²⁸ ХНХСИ. (2018). Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

байгууллагын төгсөгчийн²⁹ 70.2 хувь нь хөдөлмөр эрхэлж, 12.1 хувь нь ажилгүй, 17.7 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт байгаагаас дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгчдийн 75.2 хувь нь, МБСБ төгсөгчдийн 62.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хувьд хотжилт томоохон асуудал болж байна. Зураг 2.2-т хүн амын хотжилтын 2050 он хүртэлх төлөвийг³⁰ харуулсан бөгөөд диаграммаас харахад 2030 он гэхэд нийт хүн амын 78.61 хувь төвлөрсөн хот, суурин газар амьдрах төлөвтэй байна. 2049 он гэхэд хот суурин газрын хүн амын тоо 77.39 хувьд хүрэхээр байгаа нь эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хүндрэл үүсэх төлөвтэй байна.



Зураг 2.2 Монгол Улсын хүн амын хотжилтын төлөв, 2050 он хүртэл

Эдийн засгийн нөхцөл байдал ба төлөв

Монгол Улсын хувьд сүүлийн жилүүдэд нэг хүнд ногдох үндэсний орлого (НХНҮО) 3,800 орчим доллар болж дунджаас дээгүүр орлоготой орнуудын тоонд багтсан байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) оны үнээр 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 32.2 их наяд төгрөг болж, өмнөх оноос 4.3 (15.3 хувь) их наяд төгрөгөөр өсжээ.

Хүснэгт 2.1. Сонгосон орнуудын хүн амын тоо, ҮНО, ДНБ, 2018 он, (Дэлхийн банкны орлогын болон бүс нутгийн ангиллаар)


	ХХИ	ХХИ эрэмбэ	Дундаж наслалт / жил/	Сургуульд суралцах хугацаа /жил/	Сургуульд суралцсан жил	Нэг хүнд ногдох ҮНО (2011 PPP\$)
Монгол	0.741	92	69.5	15.5	10.1	10103
Киргиз	0.672	122	71.1	13.4	10.9	3255
Туркмен	0.706	108	68	10.8	9.8	15594
Зүүн Ази, Номхон далайн орнууд	0.733		74.7	13.3	7.9	13688
ХХИ өндөр түвшин	0.757		76	14.1	8.2	14999

Эх сурвалж: Дэлхийн банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд, 2018

Монгол Улсыг хөгжлийн түвшин, хүн амын тоогоор ойролцоо орнуудтай харьцуулж үзэхэд нийгмийн үндсэн үзүүлэлтүүд дундаж түвшинд байна.

²⁹ 2015-2016 оны хичээлийн жилд их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш бакалаврын боловсрол эзэмшин, төгсөгчид

³⁰ <https://ourworldindata.org/urbanization>



Зураг 2.3. Нэг хүнд ногдох ДНБ, сая төг, 2010-2018

Монгол Улсын ДНБ-ний хэмжээ сүүлийн 10 жилд дараах байдлаар өссөн бөгөөд энэ өсөлттэй холбоотойгоор оны үнээр тооцсон нэг хүнд ногдох ДНБ 2018 онд 9.9 сая төгрөг (3,740 орчим ам.доллар) болжээ. (Зураг 2.3.)

Олон улсын байгууллагуудын хийсэн таамаглалаар цаашдаа Монгол Улсын ДНБ-ийн өсөлт дунд хугацаанд 5 орчим хувь, Сангийн яам болон ОУВС-ийн тооцоолсноор дараах төлөвтэй байхаар харагдаж байна³¹.

Хүснэгт 2.2. Монгол Улсын ДНБ-ий өсөлт, төсөөлөл

	2016	2017	2018	2019	2020	2021
Бодит салбар						
ДНБ, оны үнээр (тэрбум төгрөг)	23886.4	27438.0	31992.2	36190.0	40529.5	44873.8
Уул, уурхайн салбарын ДНБ (тэрбум төгрөг)	4768.4	6069.0	7408.9	7483.4	7697.3	7988.7
Уул, уурхайн бус салбарын ДНБ (тэрбум төгрөг)	19118.0	21369.0	24583.4	28706.6	32832.1	36885.1
ДНБ-ий бодит өсөлт (хувь)	1.0	3.3	4.2	8.0	6.0	6.0
Уул, уурхайн салбарын бодит өсөлт	0.7	(7.4)	3.9	3.1	0.2	11.5
Уул, уурхайн бус салбарын бодит өсөлт	1.1	6.8	4.3	9.4	7.7	4.6
Экспортын хэмжээ (нийт)	6063.0	6210.0	7674.0			
Импортын хэмжээ (нийт)	4208.7	4371.4	6184.8			
Гадаад худалдааны тэнцэл (сая ам.доллар)	1854.3	1838.6	1489.2			
Хэрэглээний үнийн өсөлт (оны эцэст)	0.5	7.7	8.6	8.0	8.0	8.0
Ам.долларын ханш, жилийн эцэст	2165.0	2469.9	2501.8	2468.0	2470.0	2470.0

Эх үүсвэр: СЯ, ОУВС


³¹ <https://mof.gov.mn/article/entry/mongol-uls>

2.2 БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН НӨӨЦ, БОЛОМЖ

Санхүүжилт, хөрөнгө оруулалт

Монгол Улсын хувьд ДНБ-д боловсролын салбарын төсвийн эзлэх хувь сүүлийн 10 жилийн дунджаар 4.3-6.5 хувьтай байгаа бөгөөд боловсролын салбарт зарцуулж буй төсвийн зарцуулалтаараа дэлхийн улс орнуудын дундаж жишигт хүрчээ. 2010-2018

оны төсвийн зарлагыг тухайн оны болон 2010 оны зэрэгцүүлэх үнээр, улсын төсвийн зарлагад эзлэх хувиар харахад боловсролын салбарын төсөв хэмжээний хувьд оны үнээр өссөн дүнтэй байна³².



Зураг 2.4. Боловсролын салбарын төсвийн зарлагын динамик

Боловсролын тухай хуулийн³³ холбогдох заалтын дагуу төрийн болон төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлж байна. Засгийн газраас 2016 онд “хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” 242 дугаар³⁴ тогтоолыг батлан төрийн болон төрийн бус өмчийн хүүхдийн цэцэрлэг, ЕБС, МСҮТ-ийн нормативт зардлыг олгож байна. Тухайн тогтоолоор нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар

санхүүжих аргачлал, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн, төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг тусад нь баталж, хувьсах зардлын санхүүжилтийг нарийвчлан хуваарилах боломжийг нэмэгдүүлсэн байна. Хувьсах зардлын бүрэлдэхүүнд дараах эдийн засгийн ангилалд хамаарах зардал багтжээ.

Хүснэгт 2.3. Хувьсах зардлын бүрэлдэхүүн

№	ҮЗҮҮЛЭЛТ
1	Багшийн албан тушаалын цалин болон нэмэгдэл цалин, хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны багш, ажилтны албан тушаалын цалин болон зарим нэмэгдэл /Зарим нэмэгдэл гэдэгт: цалин, хөдөө орон нутагт ажилласан, ур чадварын, анги кабинет болон заах аргын нэгдэл хариуцсан нэмэгдлийг ойлгоно/
2	Багшийн үндсэн болон нэмэгдэл цалинд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл

³² АХБ, БШУЯ. (2019). Боловсролын санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээний тайлан

³³ Боловсролын тухай хуулийн 40, 41 дүгээр заалт

³⁴ <https://www.legalinfo.mn/law/details/11937?lawid=11937>

3	Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал	1. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх
		2. Бичиг хэрэг
		3. Ном хэвлэл
		4. Шуудан холбоо, интернэтийн төлбөр
		5. Дотоод албан томилолт
		6. Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс
		7. Нормын хувцас, зөөлөн эдлэл
		8. Эм, бэлдмэл
		9. Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал
		10. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
		11. Бараа үйлчилгээний бусад зардал


Эх сурвалж: БШУЯ

Боловсролын тухай хуулийн хүрээнд сургуулийн өмнөх, бага, дунд болон МБС-ын дэд салбар норматив зардлаар санхүүжүүлж байгаа бөгөөд 2019 оны төсвийн жилийн байдлаар дараах нормативаар орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардал болон бусад зардлыг санхүүжүүлжээ.

Хүснэгт 2.4. Хувьсах зардлын норматив, төг, 2018 он

Зардлын зүйл	Цэцэрлэг	ЕБС	Шийдвэр
Хувьсах зардал/нэг хүүхдэд жилд дунджаар мян.төг/			Засгийн газрын 2016 оны 242 тоот тогтоол
Сум, аймгийн төв	905.3	437.9	
Нийслэл	807.8	374.0	
Дотуур байр		387.5	
Хоол (өдөрт)	2.475		Засгийн газрын 2019 оны 450 тоот тогтоол
Дотуур байрны хүүхдийн хоол (өдөрт)		3,475	
Үдийн цай (өдөрт) 1-5 анги		0.900	
Тусгай сургуулийн үдийн хоол (өдөрт)		2.400	Засгийн газрын 2017 оны 162 тоот тогтоол

Эх сурвалж: БШУЯ, 2019



Зураг 2.5 Боловсролын салбарын төсвийн бүтэц

2018 оны байдлаар боловсролын салбарын төсвийн бүтцийг дэд салбараар авч үзвэл, 23 хувийг СӨБ, 46 хувийг БДБ, 9 хувийг ДБ, 4 хувийг МБС болон 18 хувийг боловсролын салбарын удирдлагын зардал эзэлж байна³⁵. МБС-ын салбар нь 2012 оноос хойш хөдөлмөрийн салбарт харьяалагдаж, Хөдөлмөрийн сайдын төсвийн багцаас 31.5% (2012-2016 онд), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас 6.3% (2016-2020 онд)-ийг эзэлж байна.

Сүүлийн 10 жилийн дунджаар боловсролын салбарын төсвийн зардлын

85 орчим хувь нь урсгал зардал буюу өдөр тутмын хэрэглээний зардлаа нөхөхөд, 15 орчим хувь нь хөрөнгө оруулалт буюу урт хугацааны санхүүжилтэд тус тус зарцуулагдаж байна. 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар боловсролын салбарын хөрөнгө оруулалтын гол бодлого нь сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжийг 1-2 ээлжтэй болгоход чиглэж барилга, их засвар, тоног төхөөрөмжийн төсвийг батлан хэрэгжүүлж байна³⁶.


Хүснэгт 2.5. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын хэмжээ сая төг, БСШУС-ын сайдын төсвийн багцад хөрөнгө эзлэх хувь, 2015-2019 он

Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Нийт хөрөнгө оруулалт /зээл багтсан/	127,905.5	179,305.9	178,475.0	371,082.7	616,453.7
Боловсролын хөрөнгө оруулалт	96,701.6	115,107.1	77,197.5	211,642.6	488,997.2
Эзлэх хувь	75.6%	64.2%	43.3%	57.0%	79.3%

Эх сурвалж БШУЯ

Салбарын хөрөнгө оруулалт 2019 онд 488.9 тэрбум төгрөгөөр батлагдаж, 2015 онтой харьцуулахад 5 дахин нэмэгдсэн байна. 2018 оны байдлаар 1,000 хүнд ногдох

суралцагчийн тоо 32.4 бөгөөд нэг хүнд ногдох боловсролын төсвийн зардал сүүлийн 10 жил өссөн дүнтэй байна³⁷.



Зураг 2.6. Нэг хүнд ногдох боловсролын зардал³⁸, нэрлэсэн болон бодит үнээр, мян төг, 2008-2018.

³⁵ АХБ, БШУЯ. (2019). Боловсролын санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээний тайлан

³⁶ АХБ, БШУЯ. (2019). Боловсролын санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээний тайлан

³⁷ АХБ, БШУЯ. (2019). Боловсролын санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээний тайлан

³⁸ БШУЯ-ны мэдээлэл

Улсын нэгдсэн төсвөөс 2008-2017 онуудад боловсролын салбарт 2,586.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж, бодит гүйцэтгэлээр 880.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Санхүүгийн жил бүрээр бодит гүйцэтгэл харилцан адилгүй байгаа ч дунджаар 34 орчим хувьтай байна. Бага, дунд боловсролын салбарт 2010-2018 оны хугацаанд нийт олон улсын болон хандивлагч байгууллагаас

санхүүжсэн 536 төсөл арга хэмжээ хэрэгжиж дууссан ба барилга, байгууламжийн хүчин чадлыг 103,453 суудлаар нэмэгдүүлэн 657.5 тэрбум төгрөг зарцуулсан байна. Хэдийгээр хөрөнгө оруулалтын ихэнх нь сургуулийн барилга, байгууламжийн хүчин чадлыг нэмэхэд чиглэсэн сайн талтай ч ЕБС-ийн барилга ашиглалтын байдлаас харахад³⁹ хөрөнгө оруулалтын үр ашгийг нягтлах хэрэгцээ байна.

Хүснэгт 2.6. ЕБС-ийн барилга ашиглалтын коэффициент, өмчийн хэлбэр, ангиллаар

Ээлжийн коэффициент	Сургуулийн өмчийн хэлбэр	Нийт	Бага	Дунд	Ахлах	Цогцолбор
0-0.1 хүртэлх	Төрийн өмчийн	24	3	5	15	1
	Хувийн	11	3	-	8	
0.1-0.5 хүртэлх	Төрийн өмчийн	59	18	23	18	
	Хувийн	53	11	-	40	2
0.5-1 хүртэлх	Төрийн өмчийн	181	18	56	101	6
	Хувийн	64	8	-	54	2
1-1.5 хүртэлх	Төрийн өмчийн	187	8	23	144	12
	Хувийн	15	2	-	13	
1.5-2 хүртэлх	Төрийн хувийн хамтарсан	1			1	
	Төрийн өмчийн	117	3	6	95	13
	Хувийн	2			1	1
2 -с дээш	Төрийн өмчийн	87	5	2	72	8
	Хувийн	1			1	
Бүгд	802	79	115	563	45	

Эх сурвалж: БУМС-ийн багийн EPSSim программ ашиглан хийсэн тооцоолол

2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээлэлд⁴⁰ үндэслэн хийсэн тооцооллоор Улаанбаатар хотод төрийн өмчийн сургуулиуд 3 ээлжээр хичээллэж, орон нутгийн сургуулиудад анги дүүргэлт

бүрдэхгүй, хувийн өмчийн ЕБС-ийн анги дүүргэлт төрийн өмчийн сургуулиудтай харьцуулахад харьцангуй бага байна (Хүснэгт 2.6).

Мэргэжлийн байгууллага, хүний нөөц

Монгол Улсын боловсролын салбарын хууль, эрх зүй, бодлого нь БШУЯ-ны чиг үүргийн хүрээнд мэргэжлийн болон сургалтын байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд хэрэгждэг. Боловсролын салбарын үндсэн байгууллага нь үндэсний түвшинд (i) БШУЯ, (ii) Боловсролын хүрээлэн, (iii) Боловсролын зээлийн сан, (iv) БМИҮЗ, (v) БМДИ, (vi)

НТБҮТ, (vii) БҮТ, орон нутгийн түвшинд (viii) БСУГ болон НТБТ байдаг.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын үндсэн байгууллага нь үндэсний түвшинд (i) ХНХЯ, (ii) МБС-ын Үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв⁴¹ байдаг.

³⁹ АХБ, БШУЯ. (2019). Боловсролын санхүү, хөрөнгө оруулалтын шинжилгээний тайлан

⁴⁰ БШУЯ-ны БУМС-ийн мэдээлэл болон тооцоолол

⁴¹ Хуучин МБС-ын Үнэлгээ, мэдээллийн төв байсан бөгөөд 2019 онд Бүсийн арга зүйн төвийг нэгтгэж МБС-ын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв болсон.

Мэргэжлийн байгууллагуудын хүний нөөц болон чадавхад хийсэн үнэлгээнээс харахад дараах нийтлэг бэрхшээлтэй асуудлууд байна⁴². Үүнд:


- Яамд болон мэргэжлийн байгууллага хоорондын зохицуулалт дутагдалтай;
- Мэргэжилтэн болон удирдлагууд ойр ойрхон өөрчлөгдөж байгаа нь бодлогын залгамж холбоо, тогтвортой байдалд нөлөөлдөг;
- Мэдээлэлд суурилсан төлөвлөлт болон менежментийн тогтолцоо дутагдалтай;
- Мэргэжлийн байгууллагын улсын төсөв хязгаарлагдмал байгаагаас байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь хууль эрхзүйн хүрээнд хүлээсэн ажил үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжгүй;
- Судалгааны материал, боловсролын судалгааны талаарх өндөр зэрэглэлийн сэтгүүл, ном, лавлах материалаас судалгааны тайлан, дүгнэлт авах онлайн /офлайн номын сангийн хүртээмж хангалтгүй;
- Мэргэжлийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийг тасралтгүй дээшлүүлэх боломж, нөхцөл бүрдээгүй;
- Хараат бус, бие даасан байдал сул байгаа нь санхүүжилт болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөөнд сөрөг нөлөөтэй (БХ, БМИҮЗ, НТБҮТ);
- Мэргэжил арга зүй, судалгааны байгууллагын судлаач, арга зүйчид

сургалтын байгууллагад очиж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх цаг хугацаа хийгээд санхүүгийн боломжгүй

- МБС-ын удирдлага мэдээллийн нэгдсэн систем байхгүй байгаа нь бодлогын хэрэгжилт, чанарт сөргөөр нөлөөлдөг.

Боловсролын тухай болон холбогдох бусад хуульд боловсролын бүх шатны удирдах ажилтны эрх үүргийг захиргааны төвлөрсөн удирдлагын үүднээс томъёолсон нь сургууль, орон нутгийн боловсролын үйлчилгээний удирдлагын төвлөрлийг сааруулахтай холбоотой заалтууд хэрэгжих боломжийг хязгаарлаж байна. Үүний зэрэгцээ боловсролын бүх шатны удирдах ажилтан, ялангуяа дунд түвшний мэргэжлийн албан хаагч (БШУЯ-ны мэргэжилтэн, БСУГ-ын мэргэжилтэн, арга зүйчид, Боловсролын хүрээлэнгийн ЭША-ууд, БМДИ-ийн арга зүйч, БҮТ-ийн мэргэжилтэн, Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежерүүд), (ХНХЯ-ны мэргэжилтэн, МБС-ын Үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн арга зүйчид, МСҮТ, ПТК-ийн захирал, сургалтын менежерүүд)-ийг бэлтгэх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэргэжил, арга зүйн тусгай чадваруудыг хөгжүүлэх тогтолцоо бий болгох төдийгүй мэргэжлийн менежментийн үйлчилгээ үзүүлэх явдал чухал юм.

Сургалтын байгууллага, хүний нөөц



Зураг 2.7. Хүүхдийн цэцэрлэгийн тоо

Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т СӨБ-ын сургалтын байгууллага нь цэцэрлэг байна гэж заасан байдаг. СӨБ-ыг үндсэн болон хувилбарт сургалтаар олгох⁴³ ба цэцэрлэг нь ердийн, тусгай, сувиллын, асрамжийн, халамжийн гэсэн хэв шинжтэй⁴⁴ байна. СӨБ-ын хувилбарт сургалт гэдэг нь үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх “ээлжийн бүлгийн”, “явуулын багшийн”, “нүүдлийн бүлгийн” сургалтын үйл ажиллагаа юм.

⁴² Мэргэжлийн байгууллагын удирдах албан тушаалтантай 2019 оны 9 сард хийсэн ярилцлагын үр дүн

⁴³ Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 7 дугаар зүйл

⁴⁴ Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 заалт

2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар төрийн өмчийн 889, төрийн бус өмчийн 546 цэцэрлэг, нийтдээ 1,435 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Нийт төрийн өмчийн цэцэрлэгүүдийн 27.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 27.8 хувь нь аймгийн төвд, 40.4 хувь нь сумын төвд, 4.4 хувь нь багийн төвд байршиж байгаа бол төрийн бус өмчийн цэцэрлэгийн 80 хувь нь Улаанбаатар хотод байна. 2018-2019 оны хичээлийн жилд СӨБ-д 261,354 хүүхэд хамрагдаж байгаагаас 239,764 буюу 91.7 хувь нь үндсэн сургалтад, 21,590 буюу 8.3 хувь нь хувилбарт сургалтад хамрагдаж байна.

2018-2019 оны хичээлийн жилд 7,903 бүлэг хичээллэж байгаа ба төрийн өмчийн цэцэрлэгт үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 36.9, хувийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 22.6 байна. СӨБ-ын байгууллагад нийт 27,172 багш, ажилтан ажиллаж байгаагаас 5 хувь нь цэцэрлэгийн эрхлэгч, 2 хувь нь арга зүйч, 28 хувь нь багш, 26 хувь нь туслах багш, 39 хувь нь бусад ажилтнууд тус тус эзэлж байна. Нийт багш нарын 88 хувь нь бүлгийн багш, 9 хувь нь хөгжмийн багш, 1 хувь нь хувилбарт сургалтын багш байна⁴⁵.

2030 он хүртэлх цэцэрлэгийн насны хүүхдийн тоо 2018 оны суурь түвшинтэй харьцуулахад 2024-2026 онд 1-2 хувь өсөж, бусад онд бага зэрэг буурах төлөвтэй байна⁴⁶.

Хүүхдийн тооны өсөлттэй уялдан 2021-2023 онд багш нарын тоо 2.0 мянгаар нэмэгдэхээр, нийт ажиллагчдын тоо буурах хандлагатай байна.

Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын нийт 803 сургууль, үүнээс төрийн өмчийн 656, хувийн өмчийн 147 сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас хөдөө орон нутагт 558, нийслэлд 245 сургууль байна. Нийт 20,574 бүлэгт 593,150 суралцагч суралцаж, 49,441 багш болон багш бус ажилтан ажиллаж байгаагийн 30,411 нь үндсэн багш байна⁴⁷.

Улсын хэмжээнд 3 ээлжтэй 28 сургуулийн 212 бүлэгт 8,451 сурагч хичээллэж байгаагаас нийслэл хотын 25 сургуулийн 188 бүлэгт 7,743 сурагч суралцаж байгаа нь сургуулийн байршил, сурагчдын ачаалал хот, хөдөөд харилцан адилгүй байгааг илтгэж байна⁴⁸.


Улсын хэмжээнд бүлэг дүүргэлт дунджаар бага ангид 30.3, дунд ангид 26.9, ахлах ангид 30.3 суралцагчтай байна. Бүлэг дүүргэлтийн улсын дунджийг сургуулийн байршлаар авч үзвэл, хотод 31.5, хөдөөд 26.1 байна. 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар нийт суралцагчдын 6.1 хувь буюу 35,012 суралцагч хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байна. Сүүлийн 12 жилийн байдлаар хувийн өмчийн сургуульд суралцагчдын хувь жилд дунджаар 1.1 пунктээр өссөн байна (зураг 2.8). 2006 онд хувийн өмчийн сургуульд суралцагчдын хувь 5.3 байсан бол 2015 оны байдлаар 5.8 (бага боловсролд 5.6, дунд ангид 5.0, ахлах ангид 7.2) байна.

⁴⁵ АХБ, БШУЯ. (2019). СӨБ-ын дэд салбарын шинжилгээний тайлан

⁴⁶ БШУЯ-ны БУМС-ийн багийн хийсэн тооцоолол, 2019

⁴⁷ БШУЯ-ны 2018-2019 оны хичээлийн жилийн статистик

⁴⁸ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан



Зураг 2.8. Төрийн болон хувийн өмчийн сургуульд суралцагчдын тоо

Хүн амын өсөлтөд үндэслэн ЕБС-д шаардлагатай багшийг тооцоолоход 2025 он гэхэд 23,576 багшийг нэмж ажилд авах хэрэгцээ үүсэж байна.

Хүснэгт 2.7. ЕБС-д шаардлагатай бага ангийн болон мэргэжлийн багш нарын тоо

№	Хичээл	2018			2020		2025		2030	
		Одоо	Нийт	Нэмэлт	Нийт	Нэмэлт	Нийт	Нэмэлт	Нийт	Нэмэлт
1	Бага анги	10397	10759	362	11727	1590	12265	3428	12696	5158
2	Монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг	2654	3370	716	3808	1220	5257	3001	5762	3838
3	Математик	2363	2425	62	2740	436	3783	1774	4147	2433
4	Мэдээллийн технологи	705	703	-2	795	107	1097	498	1203	691
5	Физик	998	1137	139	1285	312	1774	925	1944	1221
6	Биологи	844	1137	293	1285	462	1774	1056	1944	1332
7	Хими	739	1137	398	1285	564	1774	1145	1944	1408
8	Газарзүй	602	758	156	856	269	1182	671	1296	860
9	Түүх	634	954	320	1078	460	1488	949	1631	1171
10	Нийгэм судлал, Иргэний боловсрол	1106	1716	610	1939	861	2677	1737	2934	2133
11	Дүрслэх урлаг, Зураг зүй, Технологи	1943	2684	741	3033	1139	4187	2536	4590	3181
12	Дуу хөгжим	1080	1413	333	1597	544	2204	1286	2416	1633
13	Биеийн тамир	2042	2308	266	2608	617	3601	1865	3947	2467
14	Эрүүл мэнд	345	813	468	919	583	1269	976	1391	1141
15	Англи хэл	2766	2341	-425	2646	-51	3653	1301	4004	1998
16	Орос хэл	720	667	-53	754	52	1041	429	1141	619
	Нийт	29940	34323	4383	38355	9163	49025	23576	53082	31284

2030 он гэхэд ЕБС-д 53,082 багш шаардлагатай бөгөөд тэдний 31,284-ийг нь шинээр бэлтгэх шаардлагатай байна.

2018-2019 оны хичээлийн жилд нийт 86 МСҮТ, ПТК, 560 гаруй мэргэжлийн сургалтын төв үйл ажиллагаа эрхэлж байна. МСҮТ, ПТК-д нийт 38,526 суралцагч сурч, 4,624

ажиллагчид ажиллаж байгаагаас 2,469 үндсэн багш, 103 захирал, дэд захирал, 80 сургалтын албаны дарга, 339 удирдах ажилтан, 1,633 туслах ажилтан ажиллаж байна⁴⁹.

2030 он хүртэл МБС-ын насны хүн амын өсөлтийн таамаглалаас харахад МБС-ын байгууллагад 2025 онд шинээр 1,082, 2030 онд шинээр 2,352 хүртэл тооны багш, ажиллагчид шаардлагатай байх төлөвтэй байна⁵⁰.

2018-2019 хичээлийн жилийн байдлаар 94 их, дээд сургууль, коллеж сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчийн 18, төрийн бус өмчийн 73, гадаадын их, дээд сургуулийн салбар сургууль 3 байна. Эдгээр сургалтын байгууллагад нийтдээ 157,625 суралцагч сурч байгаагийн 87,992 нь төрийн өмчийн, 69,370 нь төрийн бус өмчийн, 263 нь гадаадын их, дээд сургуулийн салбар

сургуульд суралцаж байна. Дээд боловсролын сургалтын байгууллагад 12,634 багш, ажилтан ажиллаж байгаагаас 6,669 нь үндсэн багш байна. Үндсэн багш нарын 62.7 хувь нь төрийн өмчийн сургалтын байгууллагад багшилдаг. Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элссэн оюутны 71.6 хувь нь тухайн жилд ЕБС-ийн 12 дугаар анги төгсөгчид байна. Нийт суралцагчдын 27.5 хувь нь бизнес, удирдлага, эрх зүй, 14.8 хувь нь боловсрол, 14.5 хувь нь инженерчлэл, зохион бүтээлт, үйлдвэрлэл, 14.2 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал чиглэлээр суралцаж байна⁵¹.

Сургалтын байгууллагад суралцагчийн тооны өсөлтийг ҮСГ-ын 2030 он хүртэлх хүн амын өсөлтийн таамаглалд үндэслэн 2018 оны суурь түвшинтэй харьцуулан таамаглахад дараах төлөвтэй байна⁵².

Хүснэгт 2.8 Суралцагчийн тооны өсөлтийн таамаглал

Түвшин	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
СӨБ	318422	312447	308213	312052	315128	322460	326240	324655	322659	319721	317055	314949	313729
ЕБС	662795	697205	734991	770085	805629	835460	865749	891865	910630	923468	939660	949353	954476
Дээд	190539	189219	185184	179695	174471	173074	176312	189079	208872	233129	250939	265730	277345
МСҮТ, ПТК-д	38526	38257	38497	39235	40382	41798	43352	45438	47113	48885	50829	49895	54527

2018 оны статистик мэдээнд үндэслэн харууллаа.
хүн амын өсөлтийн тоо, хувийг тоймлон

Хүснэгт 2.9 Хүн амын өсөлт, 2018-2030 он

Сургалтын түвшин		2018	2019	2020	2025	2030	
1	СӨБ	318422	312447	308213	324655	313729	
		Өсөлтийн хувь	-2	-3	2	-1	
2	Бага, дунд	Бага	341257	358321	371142	389702	403922
			Өсөлтийн хувь	5	9	14	18
	Дунд, ахлах	321538	338884	363849	502163	550554	
		Өсөлтийн хувь	5	13	56	71	
3	Дээд	190539	189219	185184	189079	277345	
		Өсөлтийн хувь	-1	-3	-1	46	
4	МСҮТ, ПТК-д	38526	38257	38497	45438	54527	
		Өсөлтийн хувь	-1	0	18	42	

⁴⁹ АХБ, БШУЯ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинжилгээний тайлан

⁵⁰ БШУЯ-ны БУМС-ийн багийн 2019 оны 5 сард хийсэн тооцоолол

⁵¹ БШУЯ-ны дээд боловсролын 2018-2019 оны хичээлийн жилийн статистик

⁵² АХБ, БШУЯ. (2019). Боловсролын салбарын өгөгдөл мэдээллийн тайлан

Дээрх төсөөллөөс харвал 2025 он гэхэд дунд, ахлах сургуулийн насны сурагчдын тоо өнөөгийн түвшнээс 56 хувь, 2030 он гэхэд 71 хувиар өсөх төлөвтэй байна.

Цэцэрлэгийн насны хүүхдийн тоо харьцангуй тогтвортой байхаар байна.

Дээд боловсрол эзэмших 18-22 насны залуучуудын тоо 2030 он гэхэд 46 хувиар өсөх төлөвтэй, МСҮТ, ПТК-д хамрагдах суралцагчдын тоо 2030 он гэхэд мөн 42 хувиар өсөх төлөв харагдаж байна.

2.3 БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

2.3.1 Боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалт

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах ажилтныг сонгон шалгаруулах, дэвшүүлэн ажиллуулахтай холбогдсон дүрэм, журам, заавруудыг шинэчлэн мөрдөж байгаа ч эдгээр нь багш нар салбартаа карьераа өсгөхөд төдийлөн дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Тухайлбал, удирдах ажилтны нөөцийг бэлтгэх асуудал орхигдсоноос боловсролын удирдах ажилтны сонгон шалгаруулалт, томилгоо оновчгүй, ажлын арга туршлагагүй, салбарын чиглэлээр мэргэшээгүй хүмүүсийг хариуцлагатай, албан тушаалд томилох явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай болсон байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад боловсролын салбар дахь төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтныг бэлтгэх, сонгон шалгаруулах, томилох, дэмжих чиглэлээр баримтлах нэгдсэн бодлого, тогтолцоо хараахан бүрдээгүй байна. Багш нарын албан тушаал ахиж, удирдах албан тушаалд томилогдох үйл явц нь үндсэндээ тодорхой төлөвлөлтгүй, тохиолдлын шинжтэй, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаагүй, туршлагагүй шинэ залуус удирдах ажилтнаар томилогддог болох нь дараах статистикийн тоо баримтаар нотлогдож байна. Тухайлбал, цэцэрлэгийн эрхлэгчийн 25.8 хувь, ЕБС-ийн захирлын 17.4 хувь, МСҮТ-ийн захирлын 8 хувь, их, дээд сургуулийн захирлын 5.3 хувь нь боловсролын

салбарт 5 хүртэлх жил ажилласан туршлагатай шинэ, залуу удирдах ажилтан байна. Үүний нэг шалтгаан нь өргөн уудам газар нутаг, тархай суурьшсан хүн амтай, дэд бүтцийн хөгжлөөс хамаарч хөдөө, орон нутагт ажиллах удирдах албан тушаалтны ажлын байрны сонгон шалгаруулалтад орж буй иргэд ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байх боломж, хомс байгаатай холбоотой байж болох юм⁵³. Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх үйл ажиллагаа нь боловсролын удирдлага, менежментийн чиглэлээр боловсролын зэрэг ахиулах магистр, докторын зэрэг горилсон сургалтуудаар үндсэндээ хязгаарлагдаж, энэ хэрэгцээг хангах төрийн нэгдсэн үйлчилгээ дутагдалтай байна.

“Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого” (2005)-ыг БСШУЯ, ЭМЯ болон НХХЯ хамтран баталж эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, нийгмийн халамж ба хамгаалал, боловсролын асуудлыг хариуцаж байгаа төрийн захиргааны бүхий л шатны байгууллагууд болон түншлэгчдийн үйл ажиллагааг зохицуулж байгаа⁵⁴ хэдий ч хэрэгжилтийн түвшинд хангалттай бус байна. Хамтарсан тушаал байдаг ч хэрэгжилтийг хангах зохицуулалт бүрдээгүйн улмаас хэрэгжилт, үр дүн хангалттай бус байна.

Бага, дунд боловсролын бүтцэд 2 удаа өөрчлөлт орж, сургуульд элсэх насыг 6 болгосон⁵⁵. Сургуулийн байршил нь хүн ам сийрэг, цөөн байдаг хөдөө орон нутгийн хувьд онцгойлон авч үзвэл зохих сургуулийн

⁵³ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын салбарын суурь мэдээллийн тайлан

⁵⁴ ЮНЕСКО, 2008


⁵⁵ 2006 онд 6+3+3, 2012 онд 5+4+3

насны хүүхэд боловсролын үйлчилгээ хүртэх нь зөвхөн биечлэн сургуульд хамрагдах боломжоос гадна эдийн засаг, нийгэм-соёлын бусад хүчин зүйлтэй холбоотой. 2009 ба 2018 онд ерөнхий боловсролын сургуулийн байршлыг баг, сум, аймгаар харьцуулан авч үзвэл:

- Багт бага, дунд, ахлах сургууль нэмэгдсэн,
- Суманд ахлах сургуулийн тоо нэмэгдсэн, харин дунд ба бага сургууль цөөрсөн,

- Аймгийн төвд ахлах, бага сургуулийн тоо нэмэгдсэн, дунд сургуулийн тоо буурсан (Зураг 2.9.) байна.

ЕБС-ийн бүтэц, байршил, хэв шинжийг шинжлэх ухааны үндэслэл, судалгаа, нотолгоонд тулгуурлан, улс орны байгаль, цаг уур, дэд бүтцийн онцлог, сургуулийн насны хүүхдийн нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан тогтоох шаардлагатай байна⁵⁶.




Зураг 2.9. Ерөнхий боловсролын сургууль байршил, ангиллаар

ЕБС-ийн удирдлагын сонгон шалгаруулалт, томилгоо нь анхаарвал зохих асуудал хэвээр байна⁵⁷. 2007-2019 оны хооронд 2012-2013 оны хичээлийн жилд 77 захирал ЕБС-д шинээр томилогдож байсан бол 2013-2014 оны хичээлийн жилд 209 захирал шинээр томилогджээ. 2012 оноос хойш сүүлийн 7 жилд нийт 783 захирал шинээр томилогдсоныг дунджилж үзвэл 112 болж байна. 2012-2016 онд нийт 507, 2016-2019 онд нийт 276 захирал шинээр томилогджээ.

⁵⁶ “ЕБС-ийн бүтэц, байршил, хэв шинж” төслийн судалгааны тайлан

⁵⁷ ЮНИСЕФ, БХ. (2019). Боловсролын салбарын хэрэглэгчийн түүвэр судалгааны тайлан



Зураг 2.10. ЕБС-ийн захирлын албан тушаалд шинээр томилогдсон байдал 2007-2019 он

ЕБС-ийн захирлын албан тушаалд шинээр томилогдсон багш нарын 50-75 хувь нь тухайн сургуульдаа ажиллаж байгаад дэвшин ажилласан эсвэл тухайн аймаг, хотынхоо ЕБС-аас шилжиж очсон байна. Захирлын албан тушаалд дөнгөж сургууль төгссөн шинэ багш томилогдсон тохиолдол 2015 оноос хойш нэмэгдэх хандлагатай байна. ЕБС-ийн захирлын албан тушаалаас чөлөөлөгдсөн багш нарын 25-аас доош хувь нь л тэтгэвэрт гарсан бол 75-аас дээш хувь нь сургууль дотроо албан тушаал өөрчлөгдөх, өөр сургууль болон бусад байгууллагад шилжсэн байна. Захирлуудын 32 хувь нь багш бус⁵⁸ мэргэжилтэй бол 5 хүрэхгүй жилийн ажлын туршлагатай захирал 17 хувийг эзэлж байна. Эндээс харахад ЕБС-ийн удирдах ажилтныг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулдаг тогтолцоо алдагдсан байгааг анхаарах шаардлагатай байна⁵⁹.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь 2012 оноос МБС-ын салбарын талаарх төрийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт,

зохицуулалтыг ханган ажиллаж байна. МБС-ын дээд удирдлага нь Үндэсний зөвлөл (МБСҮЗ) байх бөгөөд энэхүү зөвлөл нь салбар дундын зохицуулалт бүхий, төр хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангасан, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн байгууллага юм.

ЮНЕСКО-ийн Боловсролын суурь мэдээллийн тайланд дурдсанаар⁶⁰ МБС-ын удирдлагын тогтолцоо оновчгүй, салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал, МБСБ-ын үйл ажиллагаа, агуулга шаталсан бус, давхардал ихтэй байна. Энэ нь ПТК-ууд зөвхөн техникийн боловсрол олгох бус мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтаар бэлтгэж байгаа нь тухайн бүс нутагт мэргэжлийн давхардал болон мэргэжлийн боловсрол олгож буй сургалтын байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдалд нөлөөлж байна⁶¹.

Хөдөө орон нутгийн иргэдийг тасралтгүй хөгжүүлэх, сургах, тэдэнд боловсрол,

⁵⁸ Удирдах болон нийгмийн ажилтны мэргэжлийг багш бус гэж тооцов

⁵⁹ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁶⁰ Хуудас 18

⁶¹ АХБ, БСШУСЯ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинжилгээний тайлан

мэргэжлийн ур чадвар, чадамж эзэмшүүлэхэд чиглэсэн бодлогын зохицуулалт хийх, хөдөө орон нутгийн иргэдийг дэмжих, насанд хүрэгчдийн тасралтгүй сурч боловсрох боломжийг бүрдүүлэх чиглэлээр бодлого, үйл ажиллагаа дутмаг байна⁶².

Боловсролын тухай хуульд заасны дагуу дээд боловсролын салбар нь түүний удирдлагыг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллага болон ДБСБ-ууд, мөн салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагуудаас бүрддэг. Гэвч бүс нутгийн, орон нутгийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг захиргааны болон олон нийтийн байгууллага байхгүй учраас хөдөө орон нутгийн ДБСБ-ууд нь шууд БШУЯ-ны удирдлагад харьяалагддаг⁶³.

Дээд боловсролын сургалтын байгууллагыг сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд үндэслэн “олон нийтийн” гэсэн ангиллыг хуульд оруулснаар улс төрөөс хараат бус, хамтын засаглал бүрдэх бөгөөд эрдмийн хамт олны академик эрх чөлөө хамгаалагдах, ДБСБ бие даан шийдвэр гаргах, хариуцлага хүлээх асуудлууд нь эрх зүйн хувьд баталгаажна.

Түүнчлэн их сургуулийн суурь болон хэрэглээний судалгааны санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг бий болгох, олон улсын нийтлэг жишиг, туршлагын дагуу судалгааны ажил, судлаач профессор

санхүүгийн дэмжлэг үзүүлэх эндаументийн санхүүжилтийн механизм бий болгоход дэмжлэг үзүүлэх, өрсөлдөөнд суурилсан, хөндлөнгийн хяналт бүхий судалгааны буцалтгүй тусламж, тэтгэлэг шалгаруулах бодлогыг хэрэгжүүлэх, судалгааны тэтгэлгийн оновчтой механизмыг олон улсын нийтлэг жишгийн дагуу бий болгох; шинжлэх ухааны олон салбарын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа оролцоотой (cluster groups) судалгааны багийн судалгааг төрөөс санхүүжүүлж, дэмжлэг үзүүлэх зэргээр “Судалгаанд суурилсан их сургуулийн үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нь тулгамдаж байна⁶⁴.

Үндэсний мэргэшлийн хүрээг өргөжүүлж, цахим, нээлттэй боловсролоор эзэмшүүлэх хувилбарт, нэмэлт хөтөлбөрүүд, танхимын сургалтаар үргэлжлүүлэн олгогдох мэргэшсэн нарийн хөтөлбөрүүдийг оруулснаар дээд боловсрол эзэмшүүлэх арга хэлбэр улам чанартай, уян хатан болж өргөжинө⁶⁵.

Монгол Улсад насан туршийн боловсролын тогтолцоо нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэд үндэсний зөвлөл болон салбар дундын зөвлөл байх ёстой боловч одоо хүртэл үйл ажиллагаа нь тодорхойгүй байна. Үндэсний хэмжээнд үйл ажиллагааны зохицуулалтыг НТБҮТ ханган ажиллаж байгаа боловч эрх зүйн хувьд шууд удирдах боломжгүй байна.

2.3.2 Хүртээмж ба тэгш хамран сургалт

Сургуулийн өмнөх боловсрол

СӨБ-ын хамран сургалт 82.8 хувь байна⁶⁶. Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 77.6 хувь нь 3-5, 0.2 хувийг 6 настай хүүхэд бүрдүүлж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 5 нас буюу бэлтгэл бүлгийн хүүхэд 29 хувь, ахлах бүлэг буюу 4 настай хүүхэд 26 хувь,

дунд бүлэг буюу 3 настай хүүхэд 25 хувь, 2 настай хүүхэд буюу бага бүлэг 18 хувь, холимог бүлэгт 2.1 хувь тус тус эзэлж (Зураг 2.11.) байна. Сургуульд элсэхийн өмнөх насны (5 нас) хүүхдийн


⁶² АХБ, БСШУСЯ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинжилгээний тайлан

⁶³ АХБ, БШУЯ. (2019). Дээд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁶⁴ АХБ, БШУЯ. (2019). Дээд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁶⁵ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын бодлогын тойм шинжилгээ

⁶⁶ Дэлхийн банк, БТДНТ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан



Зураг 2.11. Цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо



Зураг 2.12. Таван настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт

СӨБ-ын хамран сургалт 92.1 хувьтай байна (Зураг 2.12.).

Суурьшлын бүсээр нь авч үзвэл, хот суурин газарт 3-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт 81.4 хувь байсан бол хөдөө орон нутагт 58.2 хувь нь цэцэрлэгт хамрагдаж байна. Сүүлийн жилүүдэд цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо тогтмол өсөж байгаатай холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтад хувилбарт сургалтын хамрагдсан хүүхдийн эзлэх хувь буурч 9.2 хувьд хүрсэн байна.

Нийслэлийн хэмжээнд төрийн өмчийн 3 тусгай цэцэрлэг, аймгийн төв дээр хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан хувийн хэвшлийн цэцэрлэгүүд, мөн төрийн өмчийн ердийн цэцэрлэг дээр тусгай бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна⁶⁷.

Хүүхдийн цэцэрлэгийн удирдлага, багш нар ачаалал их, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаагүй, орчин бүрдээгүй зэрэг шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлэхээс цааргалдаг байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт зөөх тээврийн асуудал, өвөл цаг агаарын хүнд нөхцөлд хүүхдээ зөөж хүргэж чадахгүйн улмаас эцэг, эхчүүд цэцэрлэгээс хүүхдээ

гаргах явдал цөөнгүй байна.

Өрхийн амьжиргааны индексээр хүүхдүүдийг 5 бүлэгт хуваан авч үзэхэд чинээлэг амьдралтай айлын хүүхдийн 90 орчим хувь нь цэцэрлэгт явдаг гэж хариулсан бол энэ тоо буурсаар (4 дүгээр бүлэгт - 86.5 хувь, 2 дугаар бүлэгт - 79.9 хувь, 3 дугаар бүлэгт - 77.2 хувь) орлого багатай өрхийн хувьд 3 дахин бага буюу 34 хувь нь л СӨБ эзэмшиж байгаа⁶⁸ нь зүй ёсоор анхаарал татсан асуудал юм. Хамгийн орлого багатай хүн амын бүлгийн сургуульд элсэхээс өмнө нэг жилийн зохион байгуулалттай сургалтад хамрагдалт хамгийн чинээлэг хэсгийнхнээс даруй 34 пунктээр доогуур байна. Гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр эцэг эхэд нь дэмжлэг шаардлагатай гэж судалгаа харуулсан байна⁶⁹. Эцэг эхчүүдийн дунд СӨБ-ын ач холбогдол, сургуульд бэлтгэгдэх байдал, бага насны хүүхдийн хөгжлийн талаарх ойлголт дутмаг байна⁷⁰.

2018-2019 оны хичээлийн жилд СӨБ-д хамрагдсан нийт хүүхдийн 11.5 хувийг малчдын хүүхэд эзэлж байна. Аймгийн төвийн хүүхдүүдийн дийлэнх нь буюу 90.2 хувь нь цэцэрлэгт хамрагдаж байхад багийн төвд хөдөөгийн болон малчин өрхийн хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдалт үүнээс 2

⁶⁷ Дэлхийн банк, БТДНТ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан

⁶⁸ ҮСХ, НҮБХАС, НҮБ Хүүхдийн сан. (2018). Монгол улсын нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа

⁶⁹ Дэлхийн банк, БТДНТ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан

⁷⁰ Дэлхийн банк, БТДНТ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан

дахин бага буюу дөнгөж 45.2 хувь байгаа нь анхаарал татаж байна⁷¹.


Малчдын хүүхдийн СӨБ-д хамрагдалтыг оноор авч үзвэл 2006-2015 он хүртэлх хугацаанд 44 хувиар өссөн бол 2018 он хүртэлх хугацаанд 9 орчим хувиар буурчээ.

Бага, дунд боловсрол

2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар, бага боловсролын хамран сургалт

90.44, суурь боловсролын хамран сургалт 91.58 харин бүрэн дунд боловсролын хамран сургалт 79.58 байна.

Хүртээмж, хамран сургалтад нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг нь сургууль болон суудлын тоо юм. Энэ тоо Улаанбаатар хотод нэлээд ачаалалтай, харин орон нутаг, тэр дундаа сумдад сургуулийн хүчин чадлын ашиглалт сул байгаа нь ачаалал ихтэй байна⁷².



Зураг 2.13. Сургуулийн ээлжийн коэффициент ба тархалт 2018-2019 он

2030 он хүртэл ЕБС-ийн насны хүн амын тоон өсөлт хүртээмж, тэгш хамран сургалтад хамгийн гол бэрхшээл байна. 2018 оны

мэдээтэй харьцуулсан хүн амын өсөлтийн тоо, хувийг тоймлон харууллаа.

Хүснэгт 2.10 Хүн амын өсөлт, 2018-2030 он


Боловсролын түвшин	Анги	2018	2019	2020	2025	2030
2 Бага, дунд	Бага	341257	358321	371142	389702	403922
		Өсөлтийн хувь	5	9	14	18
	Дунд, ахлах	321538	338884	363849	502163	550554
		Өсөлтийн хувь	5	13	56	71

Дээрх таамаглалаас харахад 2025 он гэхэд дунд, ахлах сургуулийн насны сурагчдын тоо өнөөгийн түвшнээс 56 хувь, 2030 он гэхэд 71 хувиар өсөх төлөвтэй байна.

2030 он гэхэд ЕБС-д шаардлагатай багшийн тоо 53,000-д хүрч, 31,284 шинэ ажлын байр бий болох төлөвтэй байна. Шинээр ажилд авах багш нарын тоог мэргэжил нэг бүрээр нарийвчлан гаргаж дараах графикт харууллаа.

⁷¹ ҮСХ, НҮБХАС, НҮБХС. (2018). Монгол улсын нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа


⁷² АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан



Зураг 2.14. 2030 он гэхэд ЕБС-д шаардлагатай багшийн тоо, хичээл бүрээр

2018-2019 оны хичээлийн жилд бага, дунд боловсролын эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээг бага боловсролоор жишээ болгон сургуулийн байршил, хамрагдалт, багшийн хангамжаас хамааруулан авч үзэхэд тухайн түвшинд нэг багшид ногдох сурагч дунджаар 30 байгаа бөгөөд түүнээс дээш үзүүлэлттэй, ачаалал ихтэй Улаанбаатар хот, Өмнөговь, Дорноговь зэрэг аймагт багшийн

нийлүүлэлттэй холбоотой асуудлууд тулгарч байна. Харин Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Хэнтий, Баянхонгор, Ховд, Завхан, Хөвсгөл аймгуудад хамрагдалтын бохир жин нь дунджаас дээгүүр, сурагч багшийн харьцаа дунджаас доогуур (буюу багшлах нөөц хүрэлцээтэй) байгаа тул боловсролын эрэлттэй байна⁷³.



Зураг 2.15. Бага боловсролын эрэлт, нийлүүлэлтийн хамаарал 2018-2019 он

⁷³ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

ЕБС-ийн багшийн ажлын ачааллын судалгаа (С.Ичинхорлоо, 2019)-аар 2 багш тутмын 1 нь 300-аас дээш тооны сурагчтай ажиллаж, дунд ангийн 3 багш тутмын 1 нь 2-4 төрлийн хичээл зааж байгаа нь зөвхөн хичээлтэй холбогдох буюу албан ёсны ажлын цагийн ачааллыг илэрхийлж байна. Үүнээс 2030 он хүртэлх суурь болон бүрэн дунд боловсролд суралцагчдын тооны огцом өсөлтийн төсөөлөлд⁷⁴ үндэслэн багшийн нийлүүлэлт, ажлын ачааллыг сургуулийн бүтэц, байршлыг оновчтой зохион байгуулах замаар шийдэх хэрэгтэй. Эдгээр нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд суурилсан сургуулийн байршил, бүтэц, хэв шинжийн зураглалыг шинэчлэн хийх шаардлагатайг харуулж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалт

2018-2019 оны хичээлийн жилд нийт 38,526 суралцагч мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцаж байгаагаас 15,097 нь эмэгтэй суралцагч байна. Нийт суралцагчийг байршлаар нь авч үзвэл хотод 19,085, хөдөөд 17,954 суралцагч суралцаж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтад нийт суралцагчдын 74 хувь, техникийн боловсролд 18 хувь, мэргэжлийн сургалтад 8 хувь нь суралцаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд МБСБ-д суралцахад тэдний хөгжлийн бэрхшээлийн хэрэгцээнд суурилсан, тохируулсан хөтөлбөр дутмаг, хүртээмжтэй орчин бүрэлдээгүй байна⁷⁵. МБСБ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг элсүүлэх, сургах, хөгжүүлэх нэгдсэн бодлого дутагдалтай байна.

Салбарт хэрэгжсэн томоохон төслийн нэг болох Мянганы сорилтын сангийн “Мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд сургалтын орчныг сайжруулахад 30 гаруй сая ам.доллар зарцуулагдсан ба нийт төрийн өмчийн 49 МБСБ-ын зөвхөн 28 нь төсөлд хамрагдан тодорхой хэмжээгээр тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

Үүнийг мэргэжлээр нь авч үзвэл нийт МБС-ын салбарт бэлтгэгддэг 193 мэргэжлийн 10 хүрэхгүй хувийг эзэлж байна.

Дээд боловсрол

Дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэгчдийн дотор тухайн жилд ЕБС-ийн 12 дугаар ангийг төгсөж, бүрэн дунд боловсрол эзэмшигчид 2006-2009 онд 74 хувь, 2010-2013 онд 70 орчим хувь байсан бол 2014-2018 онд дунджаар 81 хувьтай (75.6-90.3 хэлбэлзэлтэй) байна. Энэ хугацаанд нийт элсэгчдийн 3-4 хувь нь бусад хэлбэрийн сургуулиас, 15-20 хувь нь ажиллагчдаас, 2-3 хувь нь ажил эрхлээгүй иргэд элссэн байна.

Элсэгчдийн чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор ДБСБ-д элсэн суралцах босго оноо⁷⁶ өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 480, хөдөө орон нутгийн сургуульд хамрагдалтыг өсгөх үүднээс 420 оноотой элсэгчийг элсүүлэн сургах болжээ. Ингэснээр хөдөө орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагад элсэгчийн тоо нийт дүнгээр нэмэгдсэн боловч, суралцаж буй мэргэжлийн чиглэлийг тухайн орон нутгийн хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах, оюутны сурлагын амжилт, чанарыг хотын сургуулиудтай ижил түвшинд хүргэж, төгсөөд ажил хөдөлмөр эрхлэх чадвараараа бусад төгсөгчидтэй өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь хөдөө орон нутгийн сургалтын байгууллагын тулгамдсан асуудал хэвээр байна. Дээд боловсролын сургалт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдахгүй байгааг судалгаа харуулж байна⁷⁷.

2017-2018 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 40.6 хувийг эрэгтэйчүүд, 59.4 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж, хүйсийн ялгааны индекс 1.46 байна. Өөрөөр хэлбэл, 100 эрэгтэй төгсөгчид 146 эмэгтэй төгсөгч ногдож байна.

⁷⁴ Эхний бүлгийн хүн ам зүйн мэдээлэлд байгаа төсөөллийг үзнэ үү

⁷⁵ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын бодлогын тойм шинжилгээ

⁷⁶ БСШУС-ын Сайдын 2018 оны А/195 тоот тушаал

⁷⁷ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

Дээд боловсролын сургалтын байгууллагын байршлаас үл хамааран хөдөө, орон нутагт чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулж, бүс нутаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах, хот хөдөөгийн ялгааг багасгах асуудал тулгарч байна.

Дээд боловсрол эзэмших сургалтын уян хатан хэлбэрийг дэмжин, сургалтын нээлттэй эх үүсвэр, онлайн сургалтын хүрээг өргөтгөн суралцагч, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэхэд шаардагдах ур чадвар, хөрвөх чадвар, түүнчлэн насан туршдаа суралцах боломжийг нэмэгдүүлэх зэргээр дээд боловсролын сургалтын чанар, үр ашгийг нэмэгдүүлэх хэрэгцээ байна⁷⁸.

Насан туршийн боловсрол

НТБ-ын үйлчилгээний хүртээмжийг 1) бичиг үсгийн хөтөлбөр, 2) дүйцсэн хөтөлбөрийн сургалт, 3) амьдрах ухаан ба бусад чиглэл (гэр бүлийн боловсролын, иргэний боловсролын, ёс суртахуун-төлөвшилийн боловсролын, гоо зүй-мэдрэмжийн боловсрол) гэсэн төрлүүдээр авч үздэг⁷⁹.

НТБ-ын төвүүдэд зохион байгуулсан бичиг үсгийн сургалтад 2007-2018 онд нийт 78,499 иргэн хамрагдсан бөгөөд бичиг үсгийн сургалтад хамрагдсан хүмүүсийн дотор 15-аас дээш насныхан 80.0-аас дээш хувийг эзэлж байна. 15-аас доош насныхан дотор хөгжлийн бэрхшээлтэй иргэд олонх байна. Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал хэвээр, тухайлбал, ерөнхий боловсролын сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн ердөө 66.2 хувь нь л сургуульд суралцаж байна. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тал орчим хувь нь бичиг үсэг тайлагдаагүй эсвэл тодорхой шатны боловсролын үйлчилгээнд хамрагдаагүй байна (НҮБХХ, 2016).

НТБ-ын суралцагчид, үйлчилгээ хүртэх бүлэг нь сургууль завсардсан болон сургуулийн гадна буй хүүхэд, залуус, насанд хүрэгчид, хүүхдээ асарч буй эмэгтэйчүүд, тэтгэврийн насны иргэд, ажилгүйчүүд, шилжин суурьшсан иргэд, сургуулийн өмнөх насныхан, тэдний эцэг эх, эмзэг бүлгийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй сурах боломжоор хомс иргэд байх ёстой боловч бодит байдал дээр бичиг үсэг үл мэдэгчид болон сургууль завсардагчид, түүн дотроо 15-аас доош насны хүүхдүүд суралцагчдын ихэнх хувийг эзэлж байна. Энэ нь нэг талаас НТБ-ын үйлчилгээ нь гол төлөв хот суурин газрын оршин суугчдад чиглэж, алслагдсан газар амьдардаг хөдөөгийн хүн амд хүрч чадахгүй байгаатай холбоотой.

Харин дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 1997-2018 онд нийт 193,589 хүн хамрагдсанаас 2007-2018 онд 65.1 хувь (126,105) байна.

Дүйцсэн хөтөлбөрт хамрагдагчид насны хувьд янз бүр боловч ихэнх нь 18-аас дээш настай иргэд байна. Тухайлбал, 2014-2015 оны хичээлийн жилд суралцсан 10,156 хүнээс 66 хувь, 2017-2018 оны хичээлийн жилд суралцсан 8609 хүнээс 67 хувь нь 18-аас дээш насны иргэд байна.

2017 оны УИХ-ын 46 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “Хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн, бага, суурь боловсрол олгох үйл ажиллагааг Насан туршийн боловсролын үндэсний төвөөр дамжуулан зохион байгуулна” хэмээн заасан боловч санхүүгийн зохицуулалт байхгүйгээс зорилтот бүлэгт хүрч ажиллаж чадахгүй байна.

⁷⁸ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

⁷⁹ АХБ, БШУЯ. (2019). Насан туршийн боловсролын шинжилгээний тайлан

2.3.3 Чанар ба нийц

Сургуулийн өмнөх боловсрол

СӨБ-ын агуулгыг тодорхойлсон сургалтын цөм хөтөлбөрийг 2014 онд батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хөтөлбөрийн үзэл санаа нь хууль, бодлогын зорилго, агуулгатай уялдаж, хүүхэд бүрийн хувийн онцлогт тулгуурлан чанартай боловсрол эзэмшүүлэх, үнэлэх, хянах дотоод үйл ажиллагааг иж бүрнээр агуулсан байна.

Бага насны хүүхдүүдийн чадварын ялгаа ихээхэн зөрүүтэй байгаа ба хөдөө, орон нутгийн эсвэл амьжиргааны түвшин багатай өрх, үндэсний цөөнхийн хүүхдүүд танин мэдэхүй, хэл яриа, нийгэм сэтгэл зүйн чадвараар хоцрогдож байна.⁸⁰ Дэлхийн банкнаас 2015 онд СӨБ-ын үйлчилгээний

чанарт олон улсын аргачлалаар хийсэн судалгааны дүнгээс харахад төрийн өмчийн цэцэрлэгүүд чанарын индексийн хувьд нэлээд сайн (4.1) гүйцэтгэлтэй гарсан бол харилцааны дэд хэмжүүрээр хамгийн өндөр (4.5) оноо, орон зай ба тавилга/тоноглол (4.3), сургалтын зохион байгуулалтаар (4.2) оноотой, сургалтын үйл ажиллагаагаар 4.17 оноотой, хэл яриа, бичиг үсгийн орчин 4.16 оноотой байжээ. Математикийн орчны хэмжигдэхүүн дээр хамгийн бага буюу 3.63 оноотой байна. Нөгөө талаар сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжил хот, хөдөөгөөр ялгаатай, математикийн мэдлэг, чадварын түвшин хамгийн доогуур үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2.11 Монгол Улсын цэцэрлэгийг ECEMI аргачлалаар үнэлсэн чанарын дэд хэмжүүрийн дундаж оноо (2015)

		Гэр		Улсын ердийн		Хувийн	
		Дундаж	Стандарт хазайлт	Дундаж	Стандарт хазайлт	Дундаж	Стандарт хазайлт
Бүтцийн чанар	Орон зай ба тавилга	3.75	1.199	4.259	0.871	4.127	0.938
Явцын чанар	Харилцаа	4.74	0.63	4.548	0.778	4.642	0.669
	Сургалтын зохион байгуулалт	3.71	1.201	4.201	0.959	4.188	0.931
Бүтэц ба явцын чанар	Үйл ажиллагаа	2.798	0.988	4.171	0.871	3.918	0.929
	Бичиг үсэг	3.815	1.057	4.164	0.755	4.052	0.823
	Математик	3.118	1.126	3.633	0.99	3.506	1.008

2010 онд Боловсролын хүрээлэнгээс хийсэн 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээгээр алслагдсан нутгийн буюу малчин өрхийн хүүхдийн үнэлгээ хамгийн бага байсан байна⁸¹.



Сүүлийн жилүүдэд хот суурин газрын хүн ам, түүний дотор сургуулийн өмнөх насны хүүхдийн тоо нэмэгдсэн, цэцэрлэгийн хүчин чадал, хамран сургалт өссөнөөр цэцэрлэгийн багшийн ажлын байрны хэрэгцээ нэмэгдэж

байна. Хот, аймгийн төвийн цэцэрлэгийн багш нар өдөрт 10-12 цаг буюу 7 хоногт 50 гаруй цаг ажиллаж байна. Хүүхдийн өдрийн унтлагын 2 цагт сургалт хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, хөтөлбөр боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн болон дараагийн хичээлийн бэлтгэл зэргийг хийдэг ч ажлын бус цагаар дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд багагүй цаг зарцуулж байна⁸².

⁸⁰ Дэлхийн банк. (2018). Монгол улсын цогц дүн шинжилгээ

⁸¹ Дэлхийн банк. (2015). Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол

⁸² Дэлхийн банк, БТДНТ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан



Зураг 2.16. Цэцэрлэгт ажиллаж байгаа багш, мэргэжилтнүүдийн ажлын байр 2018 он

2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар төрийн өмчийн 5, төрийн бус өмчийн 19 их, дээд сургуулиуд СӨБ-ын багш бэлтгэж байгаа бөгөөд тэдгээрийн сургалтын багц цаг болон хичээлүүд ялгаатай байгаагаас төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, чадвар жигд чанартай байж чадахгүй байна. Багш бэлтгэх их, дээд сургуулиудын хөтөлбөр харилцан адилгүй, сургалтын чанар, арга зүйгээс төгсөгчдийн мэдлэг, чадварын ялгаа их, эчнээ сургалтын хугацаа богино, чанар муу, дадлагын чанар харилцан адилгүй, ихэнх төгсөгчдийн баримт бичиг боловсруулах чадвар сул байна⁸³.

2018 онд 835 багш улс, бүс, орон нутгийн сургалтуудад мэргэжлээ дээшлүүлснээс нийт багш нарын 10 хувь нь ямар нэг хэлбэрээр сургалтад хамрагдаж байна. Иймд мэргэжил дээшлүүлэх сургалтыг уян хатан болгох, ажлын байрандаа хөгжих боломжоор хангах, нээлттэй, цахим, зайн боловсрол, сургалтын нөөцийг ашиглах замаар нэмэгдүүлэх шаардлагатай байна⁸⁴.

Цаашид туслах багш нарыг бага насны хүүхдийн хөгжлийн мэргэжилтний “нөөц”-д тооцон сургалтад тогтмол хамруулж, мэргэжил шатлан эзэмших бололцоогоор хангах хэрэгтэй байна⁸⁵.

Туслах багшийг бэлтгэх тогтолцоо өнөөгийн багш бэлтгэх тогтолцоотой уялдаагүй, мэргэжлийн боловсрол, сургалтын хүрээнд зохион байгуулагдаж байгаа нь туслах багшийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

2018-2019 оны хичээлийн жилд 7,903 бүлэг хичээллэж байгаагаас төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 36.9 байгаа бол хувийн цэцэрлэгийн үндсэн сургалтын бүлэг дүүргэлт 22.6 байна. Аймгийн төв, нийслэл хотод 60-д хүрэх ч нөхцөл байдал үүсээд байна.

Сургуулийн өмнөх боловсролын салбарт хийж буй хөрөнгө оруулалт одоогоор сургалтын орчныг сайжруулж сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомыг нэмэгдүүлэхэд төдийлөн чиглэж чадахгүй байна. Төрийн өмчийн ихэнх цэцэрлэгүүд хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих сургалтын хэрэглэгдэхүүн болон тоглоомын үндсэн багцаар хангагдсан боловч материалын төрөл цөөн, чанар хангалтгүй байна⁸⁶.

Бага, дунд боловсрол

2012-2018 онд сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулж, үе шаттайгаар үндэсний түвшинд хэрэгжүүлж байна. Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт

⁸³ Дэлхийн банк, БТДНТ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын тайлан

⁸⁴ АХБ, БШУЯ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁸⁵ Дээрх шинжилгээ

⁸⁶ Дэлхийн банк. (2015). Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол

шинжлэх ухааны мэдлэг, чадвараас гадна бусадтай хамтрах, мэдлэгийг эрж хайх, олж судлах арга барилтай болох, байнга тасралтгүй хөгжих, хүрээлэн буй орчныг зөв ухаарч тэнд өөрийгөө зөв авч явах, зорилго чиглэлтэй амьдарч хөдөлмөрлөх зэрэг хувь хүний хөгжилд хандсан чадвар, агуулгыг тодорхой тусгасан байна.

Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийн хүрээнд ахлах ангид нэмэлт үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд тэдгээрт харгалзах шинэ менежмент шаардагдаж, сургуулийн захирал, сургалтын менежер, анги удирдсан болон хичээл заадаг багш нар, нийгмийн ажилтан, сурагчид, эцэг эхийн үүрэг хариуцлага нэмэгдсэн. Гэвч ЕБС-ийн бүтэц, байршил, хэв шинжийн онцлогийг тооцоогүй, зохих бэлтгэлийг бүрэн хангаагүйн улмаас хөдөөгийн цөөн сурагчтай сургуулийн сурагчид хичээл сонгон судлах боломж хязгаарлагдмал байна. Ингэснээр ахлах ангийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл учирч, батлагдсан сургалтын төлөвлөгөө өөрчлөгдөхөд хүрсэн. Энэ нь сурагч дараагийн шатны сургуульд суралцах залгамж холбоог хангах, бүрэн дунд боловсролын агуулгыг кредитийн тогтолцоонд шилжүүлэх, суралцагчдад сонгох боломжийг өргөжүүлэх, ахлах сургуулийг хөгжүүлэх бодлого бүрэн утгаараа хэрэгжиж чадахгүй байгаагаас цөм хөтөлбөрийн хэрэгжилт сул, жигд бус байна⁸⁷.

Хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлийн нэг нь хөтөлбөрийн ойр ойрхон өөрчлөлт юм. 2008-2018 оны хооронд нийт 252 сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдсөн бол сүүлийн жилүүдэд тэдгээрийн 70 гаруй хувь нь хүчингүй болжээ. Цаашид сургалтын хөтөлбөрийг дахин боловсруулна гэхээс илүүтэй хэрэгжилтийн менежментийг тогтвортой байлгах шаардлагатай байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа болон боловсролын чанарын

судалгаагаар суралцагчийн суралцахуйн зорилтын хүрээнд эзэмших мэдлэг, чадвар сул байгааг илрүүлсэн. Үндэсний чанарын үнэлгээ болон Дэлхийн банкны “Бага боловсролын чанарын шинэчлэл” төслөөс зохион байгуулсан 1, 2 дугаар ангийн хүүхдийн бичиг үсэг, тоо тооллын үнэлгээ⁸⁸ -ний үр дүн ч тухайн ангид суралцагчдын боловсролын чанар сул байгааг баталсан байдаг. Тухайлбал, Дэлхийн банкны төслийн үнэлгээгээр 1, 2 дугаар ангийн сурагчид уншиж суралцах суурь чадварыг эзэмших шатандаа байгаа ба үнэлгээнд оролцогчдын 59 хувь нь үсэг таних, 28 хувь нь үгийн эхний авиаг зөв дуудах, 26 хувь нь үсгийн авиаг дуудах даалгаврыг гүйцэтгэжээ. Танил үгийн гуравны хоёрыг нь зөв дуудаж, утгагүй үгийн тал хувийг нь уншиж чадаж байна. Унших даалгаврын биелэлт 50 хувьтай, ойлгож унших түвшин 27 хувь байна. Тодорхой хугацаатай өгсөн даалгаврын биелэлт нь минутад дунджаар 59 үсэг таньж, 28 үгийн эхний авиаг зөв дуудаж байна. Математикийн хувьд сурагчид сургалтын хөтөлбөр дэх чадварыг эзэмшиж хараахан чадаагүй байна. Тоо таних даалгавар дээр 85 хувийн гүйцэтгэлтэй, нэмэх үйлдлийн гүйцэтгэл 50 хувьтай байна. Ухагдахууны ойлголтыг шалгах даалгавар дээр 68 хувийн гүйцэтгэлтэй, II түвшний нэмэх хасах үйлдэл ба тоонуудын хувьд 50 хувийн гүйцэтгэлтэй байлаа. Өгүүлбэртэй бодлогын гүйцэтгэл мөн 50 хувьтай байна.

Боловсролын чанарын судалгаагаар⁸⁹ суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд суралцагчид танин мэдэхүйн энгийн түвшний даалгаврыг гүйцэтгэж дадсан боловч дээд түвшний буюу шаардлагатай мэдээлэл олж авах, боловсруулах, үр дүнг өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэглэх, өгсөн загвар ашиглан зохиомж бичих зэрэг чадвар сул, хэл зүйн дүрэм, үгийн сангийн мэдлэг, эхийн бүтцийг тодорхойлох чадвар сул байсан.

Казах, тува зэрэг үндэсний цөөнхийн хүүхдэд хос хэлний боловсрол олгох

⁸⁷ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁸⁸ World Bank. (2017). Early grade reading and mathematics ability assessment report

⁸⁹ Цөм хөтөлбөр дэх суралцахуйн зорилтын мэдлэг, чадварыг үнэлдэг.


бодлого баримталж буй хэдий ч хэл, соёлын ялгаатай байдлаас үүдэн дараагийн шатны сургуульд элсэн орох шалгалтын үр дүн хангалтгүй, хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдийн эх хэлний боловсрол зэрэг бэрхшээл байсаар байна⁹⁰.

Дээрх үнэлгээний үр дүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээгээр цэцэрлэгт хамрагдсан байдал, сургуулийн орчны хүүхдэд ээлтэй байдал, сурах бичгийн хангамж, сургуулийн байршил⁹¹, багшийн мэргэжлийн чадамж зэрэг нь эерэг хамааралтай байлаа.

Багшийн мэргэжлийн бэлтгэл, мэргэжил дээшлүүлэх сургалт Засгийн газрын дэмжлэгтэйгээр системтэй зохион байгуулагдаж байгаа хэдий ч үр дүн, чанар сул байна⁹². Багш бэлтгэх их, дээд сургуулиудын хөтөлбөр харилцан адилгүй,

мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгатай уялдаагүй, багш өөрийн мэргэжлийн түвшнээ баримжаалах стандарт байхгүй, аль ч сургалтын агуулга тэдний хэрэгцээнд нийцэж чадаагүй байгаа зэрэг бэрхшээлүүд байсаар байна.

Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн багш нарыг мэргэжлийн, мэргэжлийн бусаар авч үзэхэд дараах дүр зураг ажиглагдаж байна. Мэргэжлийн багшийн хомсдолоос шалтгаалан мэргэжлийн бус багш зарим хичээлийг заах тохиолдол байна. 2014-2015 оны хичээлийн жилээс багш дутагдах хандлагатай байна. 2014-2015 оны хичээлийн жилд багшийн хомсдол 1.9 хувь байснаас 2016-2017 хичээлийн жилд 4.1 хувьд хүрч нэмэгдсэн байна. Зурагт 2.17⁹³.



Зураг 2.17. Мэргэжлийн багшийн хомсдол 2006-2016 он

Хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн хүүхдүүд, бусад ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хувьд бодлого, зохицуулалт хангалтгүй, цаг үеийн шинжтэй үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Боловсролын хүрээлэнгийн судалгаагаар, казах, тува хүүхдийн эх хэл болон монгол хэлний сургалтын үр дүнд дорвитой ахиц гарахгүй байгаа бөгөөд бүрэн дунд боловсрол төгсөгчид монгол хэл, түүх, нийгмийн ухаан, газар зүйн хичээлийн ЭЕШ-аар жил дараалан

доогуур үнэлгээтэй шалгагдаж байна. Энэ нь тухайн хүүхдүүдийн дараагийн шатны боловсрол эзэмших, хөдөлмөрийн зах зээл дээр бусадтай тэгш өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна⁹⁴.

Мэргэжлийн боловсрол, сургалт

МБС-ын чанарыг тодорхойлох үндсэн үзүүлэлт нь төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн хувь, ажлын байранд тавигдах шаардлагыг хангах ур чадвар, хандлага төлөвшил

⁹⁰ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁹¹ Статистикийн хувьд ач холбогдолтой эерэг хамаарлууд

⁹² АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁹³ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

⁹⁴ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

юм. МБС-ын салбарын шинжилгээгээр⁹⁵, сургалт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцдэггүйгээс гадна, сургалтын орчин бүрдүүлэх, чадамжийн нэгжээ тодорхойлох, материал түүхий эдээ сонгох, суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлэхдээ ажил мэргэжлийн лавлах ашигладаггүй байна.

Суралцагчдад техникийн ур чадвараас илүү хандлага, төлөвшил, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, харилцах, бие даан бизнес эрхлэх гэх мэт мэргэжилтэй ажилтанд зайлшгүй эзэмшсэн байх ур чадвар, хандлагыг хөгжүүлэхийг чухалчлахгүй байна. Хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байранд тавигдах мэргэжлийн ур чадвараас гадна хувь хүнд тавигдах ерөнхий ур чадварууд төгсөгчдөд хангалттай бус байна⁹⁶.

Дээд боловсрол

Дээд боловсролын сургалтын зарим байгууллагууд хэт олон мэргэжлээр сургалт эрхлэх болсон нь чанарт сөргөөр нөлөөлж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, үндэсний онцлогт тохирсон эсэхэд үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх шаардлагатай байна.

Санхүүгийн хомсдолоос үүдэлтэйгээр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, элсэгчийг татах зорилгоор олон хөтөлбөрөөр цөөн суралцагч элсүүлэх зэрэг нь сургалтын чанар, байгууллагын тогтвортой үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Статистик үзүүлэлтүүдээс харахад дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоо зах зээлийн эрэлтээс давсан байна. Үндэсний болон орон нутгийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, эрэлтэд нийцсэн хөтөлбөрөөр сургалт эрхлэх, мэргэжлийн чиглэлийг шинэчлэх шаардлагатай⁹⁷.

Дээд боловсролын чанарыг хангах чухал хэрэгсэл болох хөтөлбөрийн шинэчлэлийн явц, үр дүнг судалж, түүнд тулгуурлан ололт амжилтыг баталгаажуулах, алдаа дутагдлыг засах замаар шинэчлэлийг эрчимжүүлэх асуудал тулгамдаж байна. Их, дээд сургуулийн судалгаа болон хөгжүүлэлт (Research & Development/ R&D), судалгаанд суурилсан сургалтын уламжлал байхгүй бөгөөд багшлах, зааж сургах чиг үүрэг хадгалагдаж, шинжлэх ухааны чиглэлийн боловсролын зэрэг олгох хөтөлбөрүүд нь орчин үетэйгээ нийцэхгүй байна⁹⁸.

Дээд боловсролын чанарын чухал хүчин зүйлсийн нэг нь хүний нөөц, тэр дундаа чадварлаг багш юм. Их, дээд сургуулиудын багш нарын судалгаанд суурилсан багшлахуйг хөхиүлэн дэмжих, андрогоги, конструктив хандлагаас гейтерлоги (heutagogical), коннективист (connectivist) хандлага руу шилжихийг дэмжих хэрэгтэй байна⁹⁹.

⁹⁵ АХБ, БШУЯ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинжилгээний тайлан

⁹⁶ ХНХСИ. (2018). Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

⁹⁷ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

⁹⁸ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

⁹⁹ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ

ГУРАВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛТУУД

- БСХДХТ-ний зорилго
- БСХДХТ-ний зарчим
- БСХДХТ-ний үндсэн чиглэл
- БСХДХТ-ний хамрах хүрээ, хугацаа
- БСХДХТ-ний зорилтуудын хураангуй

ГУРАВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021–2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛТУУД

3.1 БСХДХТ-НИЙ ЗОРИЛГО

2021-2030 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө нь Монгол Улсын иргэний хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай, нээлттэй, тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын үйлчилгээнд тулгуурлан, бие

хүний төлөвлөөс мэдлэгт суурилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх, дижитал технологийн эринд ажиллаж амьдрах, нийгмийн идэвхтэй оролцоо бүхий, тасралтгүй хөгжих чадамжтай, эрүүл иргэнийг цогцоор¹⁰⁰ хөгжүүлэхийг зорих юм.

3.2 БСХДХТ-НИЙ ЗАРЧИМ

Хүний цогц хөгжлийг төв болгон энэхүү төлөвлөгөөг дараах зарчмуудыг баримтлан боловсрууллаа.Үүнд:

- Иргэн бүрд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломж олгох;
- Боловсролын үйлчилгээнд оролцогч талуудын хамтын оролцоо, үүрэг, хариуцлагыг бэхжүүлэх, дэмжих;
- Боловсролын салбарын тогтвортой

бодлого, мэргэжлийн удирдлагыг бэхжүүлэх;

- Боловсролын бодлогын босоо болон хөндлөн уялдааг хангах;
- Ухаалаг, дижитал технологийг бүх түвшний боловсрол, сургалтад ашиглах;
- Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн болон үйл ажиллагаанд ногоон хөгжлийг дэмжих.

3.3 БСХДХТ-НИЙ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөөг монгол хүний насан туршийн хөгжил, түүнийг дэмжих чанартай боловсролын тогтолцоог бэхжүүлэх 3 үндсэн чиглэлийн хүрээнд тодорхойлсон.

1. Боловсролын чанар ба нийц

Монгол Улсын боловсролын салбарын нэн тэргүүний тулгамдаж буй асуудал нь боловсролын чанар, нийц гэдгийг салбарын судалгаа, дүн шинжилгээ болон талуудын оролцоотой хийсэн хэлэлцүүлгийн үр дүнгээс харагдсан. Суралцагчийн сурлагын амжилт нь доогуур, хот, хөдөөд болон нийгэм эдийн засгийн хувьд ялгаатай байна. Төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, хандлага суралцахуйн зорилтод хүрдэггүй, нийгмийн хэрэгцээ болон хөдөлмөрийн зах зээлийн шаардлагатай нийцэхгүй байна. Иймд боловсролын чанар ба нийцийг сайжруулах нь БСХДХТ-ний тэргүүлэх зорилт бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэх үндсэн стратеги

нь сургалтын хөтөлбөр, үнэлгээний уялдаа, чанарыг сайжруулах, багшийн чадавхыг бэхжүүлэх, боловсролын түвшин хоорондын залгамж холбоог хангах, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагатай нийцүүлэх явдал юм. Ялангуяа хөдөө, орон нутгийн сургалтын байгууллага, багш нарт чиглэсэн арга хэмжээ нь хөдөө орон нутгийн боловсролын чанар, нийцийг сайжруулахад томоохон түлхэц болно гэж үзэж байна.

2. Боловсролын хүртээмж, тэгш хамран сургалт

Боловсролын хүртээмж, тэгш хамран сургалттай холбоотой үндсэн асуудал нь малчин өрх, нийгмийн эмзэг бүлгийн болон тусгай хэрэгцээт суралцагч боловсролын үйлчилгээг бусадтай адил тэгш хүртэх боломж бага байгаад оршиж байна. Насан туршдаа суралцахуйг дэмжих, нээлттэй боловсрол, сургалтыг түгээн дэлгэрүүлэх, сургалтын уян

¹⁰⁰ Holistic human development

хатан хэлбэрийг ашиглах, үр дүнг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх нь боловсролын бүх түвшинд тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх гол стратеги юм.

Үүний зэрэгцээ сургалтын байгууллагын дэд бүтэц, орчныг тусгай хэрэгцээт суралцагчдад ээлтэй байдлаар сайжруулах, малчин болон амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхийн суралцагчдад чиглэсэн хувилбарт сургалтын боломжуудыг бий болгох нь зүйтэй байна.

3. Боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалт

Монгол Улсын боловсролын засаглал, удирдлага, менежментэд тулгарч буй бэрхшээл нь боловсролын салбарын хүний нөөцийн тогтвортой байдал алдагдсан явдал юм. Боловсролын удирдах ажилтны нөөц дөрвөн жил тутам өөрчлөгддөг, мэргэжлийн бус удирдлага томилогддог, түүнийг дагаад боловсролын бодлогын залгамж чанар, тогтвортой байдал алдагддаг, хэрэгжилт

саатдаг эсвэл зогсдог, өмнөх удирдлагын хийж бүтээснийг үгүйсгэж ямар ч нотолгоо, баримтгүйгээр шинэ ажил эхлүүлдэг зэрэг нь боловсролын салбарт ихээхэн саад бэрхшээл бас дарамт болж байна. БСХДХТ-ний гурав дахь тэргүүлэх чиглэл болох Боловсролын оновчтой засаглал, удирдлагыг бэхжүүлэх хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Мэргэжлийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж, чадавхыг бэхжүүлэх,
2. Салбарын хүний нөөцийн мерит зарчимд тулгуурласан улс төрөөс хараат бус бодлого хэрэгжүүлэх,
3. Багшийн менежментийг сайжруулах, өгөгдөл мэдээлэл, нотолгоонд суурилсан төлөвлөлтийн дагуу ажиллах,
4. Сургалтын байгууллагын тэр дундаа СӨБ болон бага, дунд боловсролын байгууллагын чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтыг сайжруулах зэргээр тулгамдаж буй асуудлуудыг шийднэ.

3.4 БСХДХТ-НИЙ ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө нь насан туршдаа

суралцахуй, СӨБ, БДБ, МБС, дээд боловсролыг 2021-2030 онд хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

3.5 БСХДХТ-НИЙ ЗОРИЛТЫН ХУРААНГУЙ

Монгол Улсын боловсролын хөгжлийн урт болон дунд хугацааны зорилтуудын хэрэгжилтийг хангах, дэлхийн нийтийн чиг

хандлагад нийцүүлэн салбарын 2021-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд дараах зорилтыг тодорхойлсон. Үүнд:

Зорилтуудын хураангуй

1. САЛБАРЫН ТҮВШИНД

Код ¹⁰¹	Зорилт
1.1	Боловсролын чанар, залгамж холбоо, нийцийг сайжруулах
1.2	Иргэдэд насан туршдаа суралцах боломжийг олгож боловсролын хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх
1.3	Боловсролын оновчтой засаглал, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх

¹⁰¹

2. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Код	Зорилт
2.1	Бага насны хүүхдийн цогц хөгжлийн хэрэгцээнд нийцсэн, дараагийн түвшний сургалттай уялдаатай СӨБ-ын чанартай үйлчилгээг бэхжүүлэх
2.2	Хөгжлийн онцлог, газарзүйн байршил, нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс үл хамааран бүх хүүхдийн СӨБ-ын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх
2.3	СӨБ-ын байгууллагын зохион байгуулалт, менежментийн үр ашигтай байдлыг сайжруулах

3. БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

Код	Зорилт
3.1	Бага, дунд боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах
3.2	Хөгжлийн онцлогоос үл хамааран суралцагчийн бага, дунд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх
3.3	Ерөнхий боловсролын сургуулийн зохион байгуулалт, менежментийн үр ашгийг сайжруулах

4. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ

Код	Зорилт
4.1	Иргэдийн ажил эрхлэх ур чадварын хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, олон улсын түвшинд нийцүүлэн чанарыг сайжруулах
4.2	Иргэдэд насан туршдаа суралцаж, мэргэжил, ур чадвар эзэмших, мэргэшлийн түвшин дээшлүүлэх уян хатан, нээлттэй сургалтын боломжийг олгох замаар хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх
4.3	Төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын зохицуулалт бүхий МБС-ын бие даасан засаглал, удирдлагыг боловсронгуй болгох

5 ДЭЭД БОЛОВСРОЛ

Код	Зорилт
5.1	Суралцагчийн хэрэгцээ, шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, олон улсын түвшинд нийцүүлэн чанарыг сайжруулах
5.2	Нээлттэй, уян хатан боловсролыг хөгжүүлэх замаар тэгш боломжийг нэмэгдүүлэх
5.3	Дээд боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох

Хүрэх үр дүнгийн хураангуй

1. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

Код	Зорилт
2.1	5 настай бүх хүүхэд сургуульд бэлтгэгдсэн байна.
2.2	Хүүхэд бүр ялангуяа малчин, бага орлоготой өрхийн болон тусгай хэрэгцээт хүүхдүүд хэрэгцээ, боломждоо нийцсэн СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан байна.
2.3	Бодлого, хэрэгжилтийн үр дүнг тооцдог чанарын баталгаажуулалттай болсон байна.

2. БАГА, ДУНД БОЛОВСРОЛ


Код	Зорилт
3.1	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтад ахиц гарч, хот, хөдөөгийн сурагчдын үнэлгээний гүйцэтгэлийн ялгаа багассан байна.
3.2	Газар зүйн байршил, нийгэм эдийн засгийн нөхцөл, хөгжлийн онцлог, ялгаатай байдлаас үл хамааран бага, дунд боловсролын үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна. /тэгш, хүртээмжтэй/
3.3	Ерөнхий боловсролын сургуулийн дотоод үр ашиг сайжирч, үр дүнг тооцдог чанарын баталгаажуулалттай болсон байна.

4. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ

Код	Зорилт
4.1	МБС-ын байгууллагын чадавх, багш нарын чадамж сайжирсан байна.
4.2	Тусгай хэрэгцээтэй иргэдийг дэмжсэн уян хатан суралцахуйн боломжийг бий болгож, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.
4.3	МБС-ын байгууллагыг төрөлжүүлж, бие даасан удирдлагын тогтолцоо бүрдсэн байна.

5. ДЭЭД БОЛОВСРОЛ

Код	Зорилт
5.1	Дээд боловсролын төгсөгчдийн мэргэшил олон улсын стандарт, Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн шаардлага хангасан байна. Хөдөө орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарыг эрдэмжүүлж, докторын зэрэгтэй багшийн эзлэх хувийг 50-д хүргэсэн байна.
5.2	Нээлттэй, цахим, онлайн, зайн сургалтын хэлбэрүүдийг өргөжүүлсэн байна. Хөдөө орон нутгийн авьяаслаг суралцагчдыг төрөөс дэмжсэн байна.
5.3	Төрийн өмчийн их сургуулиуд бие даасан засаглалтай болж, сургалтын байгууллагуудыг эрэмбэлж, чансаа тогтоосон байна. Их сургуулийг бүсчлэн хөгжүүлж, судалгааны их сургууль байгуулж төрөөс дэмжсэн байна.



ДӨРӨВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЗОРИЛТУУД

- Салбарын түвшинд
- Дэд салбарын түвшинд

ДӨРӨВ. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЗОРИЛТУУД

4.1 САЛБАРЫН ТҮВШИНД

4.1.1 Дэд салбар дамнасан зорилт, хөтөлбөр, үйл ажиллагаа

1. Зорилтууд

Зорилт 1.1 Боловсролын чанар, залгамж холбоо, нийцийг сайжруулах

Хүрэх үр дүн: Бүх түвшний боловсролын чанар, нийц хөдөө, хотод ижил түвшинд хүрч, мэргэшсэн, чадварлаг, тогтвортой хүний нөөцтэй болсон байна.

Боловсролын чанар, нийц түвшин бүрд сул байгааг судалгааны үр дүнгүүд илтгэж байна. Тэр дундаа боловсролын бүх түвшний сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг, үнэлгээний журам нь ойр ойрхон үндэслэл багатай өөрчлөгддөг, тэр бүр хоорондын уялдаа, залгамж холбоо алдагддаг нь чанарт сөрөг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, СӨБ-д “үйл ажиллагаанд суурилсан”; бага, дунд боловсролд “цогц чадамжид суурилсан”; МСҮТ-д “чадамжид суурилсан”; их дээд сургуульд “хөтөлбөр ба хичээлийн суралцахуйн үр дүнд суурилсан” гэх мэтээр янз бүрийн нэр томъёог хууль, тогтоомжид тусгаж, албажуулан хэрэглэж байгаа нь нэгдмэл нэг үзэл баримтлал бүхий суралцахуйн үр дүнд суурилсан төлөвлөлтийн үзэл санааг боловсролын түвшин бүрд ялгаатай мэт зөрүү ойлголтыг төрүүлж, түвшин хоорондын залгамж холбоог бүдгэрүүлэх хандлагатай байна¹⁰².

5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулах нь сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах боломжийг олгоно. Малчин өрхийн 5 настай хүүхдийг сургуульд бэлтгэхэд чиглэсэн хувилбарт сургалтыг нэмэгдүүлэх, эцэг эхэд нь дэмжлэг үзүүлэх, тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай.

Бүрэн дунд боловсрол, МБС болон дээд боловсролын залгамж холбоо хангалтгүй байна. Ахлах ангид сонгон судалсан хичээлийн үнэлгээг, политехник коллеж, ПТК дээд боловсролын сургалтын байгууллагын кредиттэй дүйцүүлдэг байх шаардлагатай байна.

Иргэдийн ажилгүйдэл боловсролын түвшнээс хамааралтай байна. Дунд түвшний боловсролтой иргэдийн 8.3 хувь, дээд боловсролтой иргэдийн 7.5 хувь нь ажилгүй байна¹⁰³. Их, дээд сургууль төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт хангалтгүй байгаа нь тэдний эзэмшсэн мэдлэг, ур чадвар хөдөлмөрийн зах зээлтэй нийцэхгүй байгаатай холбоотой.

Боловсролын салбарт тулгамдаж буй өөр нэг чухал асуудал нь хот, хөдөөгийн боловсролын чанарын зөрүү их байгаа явдал юм. СӨБ-д хамрагдаж байгаа хот, хөдөөгийн хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн түвшин, бага, дунд ангийн суралцагчийн сурлагын амжилт, МБС болон ДБСБ-ын төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн ялгаа их байна. Үндэсний цөөнхийн монгол хэлний мэдлэг, чадвар сул байгаа нь тэдний суралцахуй, сурлагын амжилтад сөргөөр нөлөөлж байгаа тул монгол хэлээр харилцах, уншиж бичих чадварыг сайжруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах шаардлагатай байна.

Судалгааны үр дүнгээс харахад боловсролын салбарын чанарт нөлөөлж буй өөр нэг хүчин зүйл нь салбарын хүний нөөцийн мэргэшсэн бус байдал, ялангуяа удирдах албан тушаалтан тогтвор суурьшилгүй, албан тушаалтны томилгоо улс төрөөс хараат, мерит зарчимд тулгуурлахгүй¹⁰⁴ байгаа явдал

¹⁰² ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

¹⁰³ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын бодлогын тойм шинжилгээ

¹⁰⁴ ЮНЕСКО, БХ. (2019). Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан.

юм. Тухайлбал, ЕБС-ийн захиралд 5 хүртэлх жилдээ ажиллаж байгаа удирдах ажилтны эзлэх хувь сүүлийн 10 жилийн хугацаанд 41.5 хувиас тасралтгүй өссөөр 2018-2019 оны хичээлийн жилд 70 хувьд хүрсэн байна. Мөн багш бус мэргэжлийн захирлын тоо нийт захирлын 32 хувийг эзэлж байна.

Сургалтын байгууллагын удирдах ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах, бэлтгэх тогтолцоогүй байна. Ажлын туршлага багатай, мэргэжил, онол, арга зүйн бэлтгэл хангалтгүй хүмүүсийг удирдах албан тушаалд томилж байгаа нь боловсролын чанар, тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байна¹⁰⁵. Боловсролын мэргэшсэн удирдах ажилтны нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх талаар хүний нөөцийн оновчтой бодлогыг тодорхойлж, үр бүтээлтэй, тогтвортой ажилладаг байх тогтолцоог бүрдүүлэх замаар удирдах ажилтны томилгоог улс төрийн шууд нөлөөллөөс ангид байлгах нь салбарын яамны хойшлуулшгүй зорилтын нэг болсон байна. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг зөв, бодитой тодорхойлж, шаардлага хангасан иргэнийг сонгон шалгаруулалтад оруулах, томилох эрх зүйн зохицуулалтын өндөр оноо авсан ч албан тушаалд томилогддоггүй “цоорхойг” арилгах, шаардлага хангаагүй хүнийг томилсон тохиолдолд уг шийдвэрийг гаргасан эрх бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгож баталгаажуулж, мөрддөг байх шаардлагатай байна¹⁰⁶. Иймд хүний нөөцөд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн бэлтгэл, хөгжил, албан тушаалын шатлал¹⁰⁷, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, цалин хөлс, эрэлт нийлүүлэлтийн асуудлыг уялдаатай байдлаар шинэчлэх шаардлагатай. Ялангуяа удирдах албан тушаалтанд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, удирдах ажилтныг бэлтгэх, давтан сургах, хөгжлийн асуудлыг салбарын түвшиндээ бэхжүүлэх зорилт дэвшүүлэх хэрэгтэй бөгөөд албан тушаалтны томилгоо нь илүү мэргэжлийн шинж чанартай болоход дэмжлэг үзүүлнэ.

Хүний нөөцийн бодлогыг үндэсний мэргэшлийн хүрээтэй нийцүүлэх, салбаруудын мэдээллийн нэгдсэн системийн уялдаа холбоог хангах, их, дээд сургуулийг түшиглэн удирдах албан тушаалтныг давтан сургах, мэргэшүүлэх, эрэлт, нийлүүлэлтийн судалгааг тогтмолжуулах шаардлагатай юм.

Олон улсын судалгааны үр дүнгээс боловсролын чанарт эерэг нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь мэргэжлийн чадамжтай багшийн нөөц байдаг. Гэтэл, багшийн хөгжих хэрэгцээнд суурилсан нээлттэй, сонголттой онлайн сургалтын хөтөлбөр, модулиудыг санал болгодог төр, төрийн бус байгууллага, их дээд сургуулиудын оролцоог хангасан тогтолцоо дутмаг байгаа нь чанартай багш бэлтгэх, давтан сургахад сөргөөр нөлөөлж байна.

Сургалтын байгууллагын багш нарын сургалтаас гадуурх ажил үүргийн ачаалал их байдаг нь тэдний хичээл сургалтад бэлтгэх, суралцагчидтай ажиллах цаг хомс болгодгийг судалгаагаар илрүүлсэн байдаг. Энэ нь боловсролын салбарын хүний нөөцийн ажил үүргийг шинээр тодорхойлох, үндсэн чиг үүрэгт нь нийцүүлж ажлын ачааллын зохицуулах шаардлагатайг харуулж байна.

Зорилт 1.2 Иргэдэд насан туршдаа суралцах боломжийг олгож, боловсролын хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Иргэд цаг хугацаа, оройн зай болон хөгжлийн онцлогоос үл шалтгаалан боловсролын үйлчилгээг хүртэх, тэгш хамрагдах боломжтой болсон байна.

Монгол Улсын иргэдэд хөгжлийн онцлог, орон зай, цаг хугацаанаас үл хамааран насан туршдаа суралцаж хөгжих, амьдралын чанараа дээшлүүлэх боломж бага байна. Тухайлбал сургууль завсардсан суралцагчдын гуравны хоёр нь л дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байна. Боловсролын ямар нэг үйлчилгээнд хамрагдахгүй байгаа, сургууль завсардсан, эсвэл ажил хөдөлмөр эрхлээгүй иргэнийг мөшгөх, шалтгааныг

¹⁰⁵ ЮНЕСКО, БХ. (2019). Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан.

¹⁰⁶ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын бодлогын тойм шинжилгээ. 1.2.2 Зөвлөмж

¹⁰⁷ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын бодлогын тойм шинжилгээ. 1.2.3 Зөвлөмж

илрүүлж түүнд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх нь иргэдэд ажил хөдөлмөр, амьдралын чанараа дээшлүүлэхэд чухал үр дүнтэй. Одоогийн насан туршийн боловсролын тогтолцоо нь дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хангалтгүй тул насан туршдаа суралцахуйн хүрээнд дахин томьёолж, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Иймд МХТ-ийн ололтыг ашиглан албан, албан бус болон амьдралын орчны суралцахуйн уян хатан хэлбэрийг түгээн дэлгэрүүлэх нь иргэдэд илүү боломжийг олгож мэдлэг, ур чадвараа хүлээн зөвшөөрүүлэх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх нөхцөлөөр хангах шаардлагатай.

Насан туршдаа суралцахуйг ҮМХ-тэй уялдуулан тасралтгүй зохион байгуулснаар иргэдэд илүү олон боломжтой нээлттэй болох юм. Нээлттэй боловсролыг хөгжүүлэх хүний болон материаллаг нөөц, түүний чанарыг баталгаажуулах, бүртгэл мэдээллийн тогтолцоог бий болгох хэрэгтэй. Албан, албан бус болон амьдрах орчинд онлайн, цахим, зайн болон нээлттэй сургалтын хэлбэрээр хүний нөөцийг чадавхжуулна. Боловсролын бүх түвшинд нээлттэй боловсрол, сургалтын агуулга болон нөөц материал, зайн платформ хөгжүүлнэ.

Нээлттэй, зайн, цахим сургалтыг хөгжүүлж, түгээн дэлгэрүүлэх нь Монгол Улсын иргэдийн хэрэгцээнд нийцсэн боловсрол, сургалт хүртээмжтэй болж хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлээд зогсохгүй нийгмийг хамарсан онцгой нөхцөл байдал, цар тахлын үед боловсролын үйлчилгээг тасралтгүй зохион байгуулах боломжийг олгоно. Нээлттэй боловсрол, зайн сургалтыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллагатай хамтран ажиллах, түншлэх асуудлыг тусгах шаардлагатай.

Зорилт 1.3 Боловсролын оновчтой засаглал, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх

Хүрэх үр дүн: Боловсролын мэргэжлийн болон сургалтын байгууллагуудын чадавх

сайжирч, удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт илүү оновчтой болсон байна.

Боловсролын мэргэжлийн байгууллагуудын нөөц болон чадавхад хийсэн үнэлгээнээс¹⁰⁸ харахад яамд болон мэргэжлийн байгууллага хоорондын зохицуулалт дутагдалтай, судалгааны өндөр зэрэглэлийн сэтгүүл, ном, лавлах материал бүхий онлайн/оффлайн номын сангийн хүртээмж хангалтгүй, хүний нөөцийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоо бүрдээгүй, байгууллагын бие даасан байдал сул байгаа нь санхүүжилт болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд сөрөг нөлөөтэй (БХ, БМИҮЗ, НТБҮТ) байна. Мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан, арга зүйчид сургалтын байгууллагад зөвлөн туслах, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх цаг хугацаа хийгээд санхүүгийн боломжгүй байгаа нь бодлогын хэрэгжилт, чанарт сөргөөр нөлөөлж байна.

Боловсролын тухай хуулиудад боловсролын бүх шатны удирдах ажилтны эрх үүргийг захиргааны төвлөрсөн удирдлагын үүднээс томьёолсон нь удирдлагын төвлөрлийг сааруулахтай холбоотой заалтууд хэрэгжих боломж хязгаарлагдмал байхад хүргэсэн. Боловсролын бүх шатны удирдах ажилтан, ялангуяа дунд түвшний мэргэжлийн албан хаагч нарыг бэлтгэх, мэргэжлийн чадамжийг хөгжүүлэх тэдний тогтвортой байдлыг нь хангах тогтолцоо бий болгож мэргэжлийн менежментийн үйлчилгээ үзүүлэх явдал чухал байна.

Дээрх асуудлыг шийдэхэд чиглэсэн арга хэмжээ нь БХ, БМДИ, БҮТ, БМИҮЗ, МБС-ын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн (ҮМАЗТ) хүний нөөцийг чадавхжуулах, БХ-г бодлого боловсруулалт, төлөвлөлт; БМДИ-ийг багш болон удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийг дэмжсэн менежментийн чиглэлээр чадавхжуулж, БҮТ-ийг психометрик шинжилгээний нэгжтэй, БМИҮЗ-ийг чанарын хөндлөнгийн баталгаажуулалтын, бие даасан байгууллагаар ажиллах, хүний нөөцийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах

¹⁰⁸ Мэргэжлийн байгууллагын удирдах албан тушаалтантай 2019 оны 9 сард хийсэн ярилцлагын үр дүн

сургалтын тогтолцоог бий болгоход чиглэх шаардлагатай юм.

МБС-ын ҮМАЗТ-ийг иргэдийн ур чадварын түвшнийг тодорхойлох, ахиулахад дэмжлэг үзүүлэх, иргэдийн тодорхой чиглэлээр эзэмшсэн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлэх үнэлгээ хийхэд удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилладаг үндэсний байгууллага болгон бэхжүүлнэ.

Орон нутгийн БСУГ-ын бүтэц, орон тоо, чиг үүргийг тодорхой болгох, хүний нөөцийг мэргэжлийн байгууллага, их, дээд сургуулиудыг түшиглэн хөгжүүлэх тогтолцоо бүрдүүлж, чадавхыг нь бэхжүүлнэ.

Бодлогын төлөвлөлт, удирдлагатай холбоотой тулгамдсан асуудал нь боловсролын салбарын мэдээллийн системийн мэдээллийг ашиглах, байгууллага хоорондын мэдээллийн

урсгалыг нэмэгдүүлэх, солилцох, бодлогын түвшинд хамтран ажиллах байдал дутмаг байна.

Мэдээллийн эх үүсвэр тодорхой бус, өгөгдөл оруулагчийн ур чадвараас шалтгаалан мэдээлэл нэгжээсээ зөрүүтэй ирэх, хэрэглэгчдийн ойлголт, хандлагаас шалтгаалан мэдээллийг буруу хэрэглэх, тайлбарлах асуудал байсаар байна. Статистик мэдээний мөн чанар, үр дүн, мэдээллийг хэрхэн хэрэглэх талаарх ойлголт, ур чадварыг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг тогтмол явуулах, түвшин бүрд хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад анхаарах шаардлага гарч байна. Мэдээллийг хэрэглэгчдэд илүү ойр, ашиглахад хялбар байхаар боловсруулалт хийж, тайлагнах шаардлагатай байна¹⁰⁹.

1. Зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа

Хөтөлбөр	Үйл ажиллагаа
Зорилт 1.1 Боловсролын чанар, залгамж холбоо, нийцийг сайжруулах	
Хөтөлбөр 1.1.1: Бүх түвшний сургалтын хөтөлбөр, үнэлгээний нийцийг сайжруулах	<ol style="list-style-type: none"> Бүх түвшний хөтөлбөр болон үнэлгээний агуулгын залгамж холбоо, нийцийг сайжруулах Үндэсний цөөнхөд зориулсан хос болон олон хэлний сургалтын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах Монгол хэлний сургалт, түвшин тогтоох үнэлгээний системийг хэрэгжүүлж, боловсролын бүх түвшинд нэвтрүүлэх Боловсролын бүх түвшинд суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй¹¹⁰ өргөжүүлэх
Хөтөлбөр 1.1.2: Хүний нөөцийн чадавх, менежментийг сайжруулах, багшийн үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх	<ol style="list-style-type: none"> Үндэсний мэргэшлийн хүрээний дагуу боловсролын салбарын хүний нөөцийн ажлын байрны тодорхойлолт, тавигдах шаардлагыг шинэчлэх, албан тушаалын шатлалыг тодорхой болгож баталгаажуулах, жендэрийн мэдрэмжтэй хүний нөөцийг бүрдүүлэх Албан тушаалын сонгон шалгаруулалт, томилгоог мэргэшсэн байдал, мерит зарчимд тулгуурлах, төрөөс хараат бус, бие даасан болгох Багшийн хөдөлмөрийн үнэлгээг бодитой тооцож, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний шинэ тогтолцоог нэвтрүүлэх Багшийн нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэх, амьдрах нөхцөлийг сайжруулж, орон сууцны хөтөлбөрт хамруулах Боловсролын салбарын хүний нөөцийн эрэлт, нийлүүлэлт, ур чадварын судалгаа, багшийн ил, далд хомсдолын тандалт хийж, төлөвлөлтөд хэрэглэх БУМС-ийн хүний нөөцийн мэдээллийн санг сайжруулан хөгжүүлэх, түүнийг бодлого болон санхүүгийн төлөвлөлтөд ашиглах Хүний нөөцийн мэргэжил дээшлүүлэх уян хатан холимог хэлбэрийн сургалтыг нээлттэй боловсрол, дижитал технологи ашиглан хөгжүүлэх Удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоог мэргэжлийн их, дээд сургуулийг түшиглэн бий болгох

¹⁰⁹ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын салбарын суурь мэдээллийн тайлан

¹¹⁰ БШУЯ. (2017). Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого 2017-2024, А130 дугаар тушаалын хавсралт

Хөтөлбөр 1.1.3: Хөдөө, орон нутгийн сургалтын байгууллагын чанарыг дэмжих	<ol style="list-style-type: none"> 1. Хөдөө, орон нутгийн сургалтын байгууллагын удирдах албан тушаалтан болон багшийн чадавхыг сайжруулах 2. Хөдөө, орон нутгийн сургалтын байгууллагын орчныг сайжруулах
---	--

Зорилт 1.2 Иргэдэд насан туршдаа суралцах боломжийг олгож боловсролын хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх

Хөтөлбөр 1.2.1: Насан туршдаа суралцахуйг дэмжих	<ol style="list-style-type: none"> 1. Иргэдийн насан туршдаа суралцахуйн хэрэгцээг тодорхойлох үндэсний хэмжээний судалгаа зохион байгуулж, суралцахуйн хэлбэр, төрөл, агуулгыг ҮМХ-тэй нийцүүлэн тодорхойлох 2. Боловсролын түвшин бүрд насан туршдаа суралцахуйг хэрэгжүүлэх санхүүжилтийг тодорхой болгож, баталгаажуулах 3. Иргэдийн насан туршдаа суралцахуйг төрийн болон төрийн бус өмчийн сургалтын байгууллага, хувийн хэвшил, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулах тогтолцоог бий болгож, баталгаажуулах 4. Насан туршдаа суралцахуйг боловсролын түвшин бүрд удирдан чиглүүлэх, сургалт зохион байгуулах хүний нөөцийн чадавх бэхжүүлэх 5. Гадаад улсад насан туршийн боловсролын төв байгуулах, монгол хэл, түүх, соёлын боловсрол олгоход дэмжлэг үзүүлэх, 6. Иргэдийн насан туршдаа суралцахуйн үр дүн, өмнө эзэмшсэн мэдлэг, ур чадварыг нь хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх 7. БУМС-д насан туршдаа суралцахуйн мэдээлэл, бүртгэл, баталгаажуулалтын модулийг хөгжүүлэх
--	--

Хөтөлбөр 1.2.2: Сургалтын цахим платформыг хөгжүүлж, онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан цахим контент, цахим хичээл боловсруулах	<ol style="list-style-type: none"> 1. Боловсролын салбарын мэдээллийн системд хөгжүүлэлт хийж, нэгдсэн сүлжээг өргөтгөх замаар салбар дундын мэдээллийг харилцан солилцох боломжийг бүрдүүлэх 2. Олон улсын жишигт нийцсэн мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийг байгуулж, чадавхыг бэхжүүлэх 3. Хиймэл оюун ухаан, их өгөгдлийн шинжлэх ухаан, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр хүний нөөц бэлтгэх 4. Цахим бичвэр, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж цахим контент, цахим хичээл боловсруулан насан туршийн боловсролд ашиглах 5. Багш бүрийг компьютержуулж ухаалаг сургууль, ухаалаг анги төсөл хэрэгжүүлэх 6. Нээлттэй, цахим, онлайн, зайн сургалтын агуулга, нөөц хэрэглэгдэхүүний чанарыг баталгаажуулж, бүртгэлжүүлэх
---	--

Зорилт 1.3 Боловсролын оновчтой засаглал, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх

Хөтөлбөр 1.3.1: Хамтын хариуцлагыг бэхжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Боловсролын мэргэжлийн болон сургалтын байгууллага, бусад талуудын хамтын хариуцлагыг бэхжүүлэх, боловсролын үйлчилгээний зарим төрлийн үйл ажиллагааг холбогдох байгууллагад шилжүүлэх, хяналтыг сайжруулах
--	---

Хөтөлбөр 1.3.2: Бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг боловсронгуй болгох	<ol style="list-style-type: none"> 1. Өгөгдөл мэдээлэл, нотолгоонд суурилсан төлөвлөлтийг хэрэгжүүлэх 2. Хүн амын өсөлт, газарзүйн мэдээллийн системд суурилж боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг төлөвлөдөг болох чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүх дэд салбарт бий болгож, чанарын баталгаажуулалтыг бусад механизмтэй¹¹¹ уялдуулах БУМС-д МБС-ын удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг нэгтгэх, өгөгдөл мэдээллийн төрөл, шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэх 3. БУМС-ийн тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах 4. Боловсролын үндэсний тооцоолол хийх тогтолцоог бүрдүүлэх 5. "ТХЗ-4"-ийн хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний арга зүйг боловсруулж дунд болон сүүлчийн шатны үнэлгээг хийх
--	---

Хөтөлбөр 1.3.3: Мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. БХ, БМДИ, БҮТ, БМИҮЗ, МБС-ын ҮМАЗТ, орон нутгийн БСУГ-ын чиг үүрэг, үйл ажиллагаа, хүний болон материаллаг нөөцийн шинжилгээ хийх 2. Боловсрол, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, сургалтын байгууллагын чиг үүргийг оновчтой болгох 3. Мэргэжлийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог их, дээд сургуулийг түшиглэн бий болгох 4. Сургалтын байгууллагын багш, ажилтанд мэргэжлийн тасралтгүй дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг олгох үүднээс БМДИ, МБС-ын ҮМАЗТ-д нээлттэй, онлайн, зайн хэлбэрээр зөвлөгөө өгөх орчныг бий болгох 5. Мэргэжлийн байгууллагыг чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа тогтвортой, чанартай, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бүрэн олгохоор дэд бүтэц, орчин, тоног төхөөрөмжөөр хангах 6. НТБТ-ийн дэд бүтэц, МХТ, интернэтийн орчныг сайжруулах
--	---

¹¹¹ Мэргэжлийн хяналтын үзлэг, хяналт, Үндэсний аудит, Магадлан итгэмжлэл, аттестатчилал гэх мэт

4.2 ДЭД САЛБАРЫН ТҮВШИНД

4.2.1 Сургуулийн өмнөх боловсрол

Зорилго: Монгол Улсын сургуулийн өмнөх насны хүүхдийн цогц хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангасан эцэг эхийн оролцоог дэмжсэн, чанартай, хүртээмжтэй, стандартад нийцсэн сургалт, аюулгүй, эрүүл, ногоон орчинтой, чадварлаг багш бүхий сургуулийн өмнөх боловсролыг хөгжүүлнэ.

СӨБ-ын чанартай үйлчилгээ нь хүүхдийн ирээдүйн амьдрал, хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо, ядуурлыг бууруулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хөгжилд хувь нэмэр оруулах болон хүмүүс хоорондын харилцаанд эерэг үр дүнг авчирдаг (Sammons et al., 2008; Sylva et al., 2004). Судалгаагаар энэ эерэг харилцаанд багшийн мэргэжлийн бэлтгэл, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байдал, чанарын хяналт, үнэлгээний үр дүн эерэг нөлөөтэй байдаг¹¹². Ийм учраас СӨБ-ын багшийн чанар, бэлтгэл, давтан сургалтын чанарыг сайжруулах, стандартын түвшинд бэлтгэдэг, сургадаг байх, түүнчлэн СӨБ-ын үйлчилгээний чанар, үр дүнг хүүхдийн хөгжил, сургуульд бэлтгэгдсэн байдлын талаарх мэдээлэлд суурилан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх зарчимд шилжих шаардлагатай¹¹³.

СӨБ-ын үйлчилгээний чанарт багшийн мэргэжлийн чадамж, хүүхэдтэй харилцах эерэг харилцаа, эцэг эхийн дэмжлэг чухал хүчин зүйл болдог гэдгийг ЭЗХАХБ-аас хийсэн судалгааны үр дүн харуулдаг¹¹⁴. Энэ нь эцэг, эх, олон нийтэд хүч боломж олгох, тэдний хүүхдийн хөгжилд хандсан оролцоог дээшлүүлэх хэрэгтэйг илтгэж байна.

1. Зорилтууд

Зорилт 2.1 (Чанар). Бага насны хүүхдийн цогц хөгжлийн хэрэгцээнд нийцсэн, дараагийн түвшний сургалттай уялдаатай сургуулийн өмнөх боловсролын чанартай

үйлчилгээг бэхжүүлэх

Хүрэх үр дүн: 5 настай бүх хүүхэд сургуульд бэлтгэгдсэн байна.

Манай улс СӨБ-ын хүүхдийн хөгжлийн үзүүлэлтээр бичиг үсэг, тоо бодох чадвараараа ижил түвшний орнуудаас хоцрогдолтой явж байна. 3-5 насны монгол хүүхдүүдийн 9 хувь нь энгийн бичиг үсэг нэрлэж, энгийн тоо бодох чадвартай байгаа нь бусад орноос доогуур үзүүлэлт юм.

Бага насны хүүхдүүдийн чадвар ялгаатай, хөдөө, орон нутгийн эсвэл амьжиргааны түвшин багатай өрх, үндэсний цөөнхийн хүүхдүүд танин мэдэхүй, хэл яриа, нийгэм сэтгэл зүйн чадвараар хоцрогдож байна¹¹⁵. СӨБ-ын насны хүүхдийн хөгжлийн хоцрогдолд нөлөөлөх гол хүчин зүйл нь багшийн чадавх бөгөөд тэд мэргэжлийн чадавхаа тасралтгүй дээшлүүлэх нөхцөл боломжоор дутмаг байна. Ажлын ачаалал их байдгаас багш нар өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаанд бэлтгэх боломж хомс. Үүнийг дан ганц танхимд суурилсан сургалтаар бус ажлын байрандаа хаанаас ч хэзээ ч сурч, өөрийгөө боловсруулах уян хатан боломжийг олгосноор шийднэ.

Үндэсний хэмжээнд 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал хангалтгүй байна. Тэр дундаа бага орлоготой өрхийн хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал үе тэнгийнхнээсээ 27.2 пүнкээр доогуур буюу 63.1 хувьтай байна. Энэ бүлгийн хүүхдүүдийн хөгжлийг дэмжихийн тулд хүүхэдтэйгээ гэр бүлийн орчинд ажиллахад дэмжлэг хэрэгтэй гэж тэдний эцэг, эхийн 81.8 хувь нь үзсэн байдаг. Энэ нь бага насны хүүхдийн хөгжлийг зөвхөн цэцэрлэгийн үйл ажиллагаагаар хязгаарлах боломжгүйг харуулж байна. Бага насны хүүхдийн танин мэдэхүй, нас сэтгэхүйн хөгжлийн онцлогийн талаар мэдээлэл авах,

¹¹² OECD. (2018). Starting Strong Report

¹¹³ АХБ, БШУЯ. (2019). Сургуулийн өмнөх боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

¹¹⁴ OECD. (2018). Starting Strong Report

¹¹⁵ Дэлхийн банк. (2018). Монгол улсын СӨБ-ын цогц дүн шинжилгээ, 2018

хүүхдээ зүй зохистой хүмүүжүүлэх арга барилд сургах, хүүхэд өсгөх, тухайлбал хоол тэжээл, эрүүл мэнд, эрүүл ахуй, нийгэмшлийн талаарх мэдлэг ойлголттой болоход эцэг эх, асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх нь хүүхдийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ. 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг жил бүр үндэсний хэмжээнд зохион байгуулж, үр дүнг бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд ашиглана.

Хүүхдийн хөгжлийн бенчмарк байхгүйгээс шалтгаалан хүүхдийн биеийн, танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн хөгжлийн төлөв онцлогт гарч буй ахиц өөрчлөлт, сургалтын болон сургалтын бус үйл ажиллагааны тохирцтой байдлыг тодорхойлох боломжгүй байна. СӨБ-ын хүүхдийн хөгжлийн судалгааг тогтмолжуулж, бага боловсролын сурлагын амжилттай холбох, хөгжлийн бенчмаркыг боловсруулж, сургалтын үйл ажиллагаа, багшийн арга зүйд тусгах нь хойшлуулшгүй зорилтын нэг юм.

Зорилт 2.2 (Хүртээмж): Хөгжлийн онцлог, газарзүйн байршил, нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс үл хамааран бүх хүүхдийн СӨБ-ын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Хүүхэд бүр ялангуяа малчин, бага орлоготой өрхийн болон тусгай хэрэгцээт хүүхдүүд хэрэгцээ, боломждоо нийцсэн СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан байна.

СӨБ-ын насны хүн амын 2030 он хүртэлх таамаглалаас харахад 2-5 настай хүүхдийн тооны өсөлт 2026 он хүртэл 1-2 хувьтай, 2027 оноос нэг хувиар буурах хандлагатай байна. Өсөлтийн хандлага, нэг багшид ногдох хүүхдийн тоог 2030 он гэхэд 20 хүргэх¹¹⁶ зорилттой уялдуулан тооцоход цэцэрлэгийн хүчин чадлыг 24,200 орчим ороор нэмэгдүүлэх шаардлагатай байна. Нийслэл хот, аймгийн төвийн цэцэрлэгүүд хүчин чадлаасаа хэтэрсэн хүүхэдтэй, ариун цэврийн байгууламж стандартын шаардлага

хангаагүй байгаа нь бага насны хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. 2030 он хүртэл тухай үеийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан цэцэрлэгийн орны тоог нэмэгдүүлэх, сургалтын орчин тэр дундаа ариун цэврийн байгууламжийг шинэчлэн сайжруулах шаардлага тулгарч байна.

Тэгш хамран сургалттай холбоотой гол бэрхшээл нь малчин, бага орлоготой өрхийн хүүхэд болон тусгай хэрэгцээт хүүхдийг СӨБ-д хамруулах асуудал юм. Малчин өрхийн хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт 45.2 хувь байгаа нь нүүдэлчин ахуйн онцлог, хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжин суурьшилт, хувилбарт сургалтын чанар, санхүүжилт буурсан нь нөлөөлсөн байж болох юм¹¹⁷. Дээрх бүлгийн хүүхдэд чиглэсэн СӨБ-ын хувилбарт үйлчилгээг хэрэгжүүлж байгаа хэдий ч хүртээмж харилцан адилгүй байна. СӨБ-ын үйлчилгээнд хамрагдахад тулгардаг бэрхшээл төдийлөн багасахгүй байгаа учраас энэ бэрхшээлд чиглэсэн хувилбарт сургалтын үр ашигтай байдлыг судлан, төрөл хэлбэрийг нэмэгдүүлэх нь нэн чухал шийдэл байх юм.

Амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт 34 хувь байна¹¹⁸. Цэцэрлэгийн багш, эцэг эхчүүдтэй хийсэн ярилцлагаас харахад хүүхэд бүрээс авдаг ариун цэврийн болон хичээлийн хэрэгсэл, цэцэрлэгийн орчныг сайжруулах хандив, сургалт хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой гарах зардлууд, мөн цэцэрлэгт явахад шаардлагатай 3 улирлын хувцас зэрэг нь орлого багатай өрхүүдэд санхүүгийн дарамт болдог байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн СӨБ-д хамрагдалт сүүлийн 10 жилд өөрчлөгдөөгүй байна. Цэцэрлэгийн удирдлага, багшийн ачаалал их, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаагүй, орчин бүрдээгүй зэрэг шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлэхээс цааргалсан байдалтай байна. Цэцэрлэгт тохируулгат орчныг бүрдүүлэх,

¹¹⁶ Монгол Улсын ТХҮБ 2030

¹¹⁷ Дэлхийн банк, БТДНТ. (2019). СӨБ-ын судалгааны тайлан

¹¹⁸ Дэлхийн банк, БТДНТ. (2019). СӨБ-ын судалгааны тайлан

багшийн стандарт, мэргэжил дээшлүүлэх сургалтад тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах үр чадварыг тусгах, туслах багшийн тоог нэмэгдүүлэх зэргээр шийдэх боломжтой.

СӨБ-ын хүртээмж, тэгш хамран сургалтыг дэмжих өөр нэг арга зам нь нээлттэй боловсрол, сургалтыг хөгжүүлэх, хүүхдийн хөгжилд эцэг, эхийн оролцоог насан туршдаа суралцахуйн хэлбэрээр нэмэгдүүлэх явдал юм. Нээлттэй, цахим, онлайн, зайн сургалт нь хүүхдийн болон тэдний эцэг эхийн боловсрол, нийгэм, эдийн засгийн нөхцөл, хөгжлийн онцлог, амьдралын хэв маягаас үл шалтгаалан СӨБ-д хамрагдах, оролцох боломжийг нэмэгдүүлдэг давуу талтай юм. Эцэг, эхчүүд хүүхдийнхээ хөгжлийн түвшнийг таньж мэддэг, тодорхойлдог, түүний дагуу СӨБ-ын байгууллагаас дэмжлэг тусламж авдаг байх нь цэцэрлэгийн бус орчинд хүүхэд тасралтгүй хөгжихөд эерэг нөлөө үзүүлнэ.

Зорилт 2.3 (Менежмент): СӨБ-ын байгууллагын зохион байгуулалт, менежментийн үр ашигтай байдлыг сайжруулах

Хүрэх үр дүн: Бодлого, хэрэгжилтийн үр дүнг тооцдог чанарын баталгаажуулалттай болсон байна.

СӨБ-ын байгууллагын зохион байгуулалтад тулгарч буй гол асуудал нь цэцэрлэгийн хүчин чадлаас хэтэрсэн анги дуургэлт хүүхэдтэй ангиуд, бодит эрэлт хэрэгцээг, тооцоонд үндэслээгүй хамран сургалтын тойрог тогтоосон явдал юм. “Алсын хараа 2050”-ийн СӨБ-ын зорилтот хэсэгт цэцэрлэгийн нэг бүлгийн хүүхдийн тоог 25-аас хэтрүүлэхгүй байхыг зорьж байна. Үүнийг

хэрэгжүүлэхийн тулд цэцэрлэгийн байршлын зураглал болон тухайн байршлын хүн амын амьдралын хэв маягийн онцлог, орлогын байдал, цэцэрлэгийн насны хүүхдийн тооны өсөлтийн таамаглалд тулгуурлан зураглал хийж, эрэлт, хэрэгцээг бодитой тодорхойлж, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийх шаардлагатай.

Гурваас доош насны хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, арга хэлбэр нь дутагдалтай байгаа учир байршил бүрд уг асуудлыг шийдэхэд түлхүү анхаарах, өнөөгийн хэв шинж нь зорилтот бүлэгт чиглэж байгааг харгалзан цэцэрлэгүүдийг дахин төлөвлөх, нийт хүүхдэд чиглэсэн хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэрийг судалж хэрэгжүүлнэ.

СӨБ-д тулгарч буй дараагийн асуудал нь үйлчилгээний үр ашиг хангалтгүй байгаа явдал юм. Энэ асуудал СӨБ-ын байгууллага чанарын дотоод хяналт сул, чанарын хөндлөнгийн баталгаажуулалт хангалтгүй, чанарын баталгаажуулалт хоорондоо уялдаагүй байгаатай холбоотой юм. СӨБ-ын байгууллагын чанарыг хянаж буй өнөөгийн механизмууд нь хоорондоо уялдаа муутай, цэцэрлэгийн үйл ажиллагааны чанар, хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулахаас илүүтэй багш, ажилчдад дарамт, ачаалал үүсгэж байна.

СӨБ-ын дотоод үр ашгийг нэмэгдүүлэхэд чанарын дотоод баталгаажуулалтыг бэхжүүлж, хөндлөнгийн бусад механизмтай уялдуулах шаардлагатай байна.

2. Зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа

Хөтөлбөр	Үйл ажиллагаа
Зорилт 2.1 (Чанар): Бага насны хүүхдийн цогц хөгжлийн хэрэгцээнд нийцсэн, дараагийн түвшний сургалттай уялдаатай СӨБ-ын чанартай үйлчилгээг бэхжүүлэх	
Хөтөлбөр 2.1.1: Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг Монгол хүүхдийн хүмүүжил, төлөвшлийг хангах чиглэлээр сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн агуулгыг монгол хүүхдийг төлөвшүүлэх, хэл, түүх, соёл, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал бүхий агуулгаар баяжуулах, сайжруулах 2. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан уян хатан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох
Хөтөлбөр 2.1.2: Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан үнэлгээний тогтолцоонд шилжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. СӨБ-ын багш мэргэжлийн стандартыг боловсруулж баталгаажуулах, стандартад тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах чадварыг тусгах 2. Стандартад нийцүүлэн СӨБ-ын багш мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх 3. Цэцэрлэгт тусгай хэрэгцээт боловсролын багш, ээлжийн багш ажиллуулах 4. СӨБ-ын туслах багшийг багш бэлтгэдэг их, дээд сургуульд бэлтгэх
Хөтөлбөр 2.1.3: Эцэг, эх, асран хамгаалагчийн боловсролын хөтөлбөр	<ol style="list-style-type: none"> 1. Эцэг, эх, асран хамгаалагчийн ур чадварыг үнэлэх суурь судалгаа хийх 2. Хүүхдийн хөгжлийг дэмжих, эцэг эх, асран хамгаалагчийн сургалтын багцыг¹¹⁹ жендэрийн мэдрэмжтэй¹²⁰ боловсруулах 3. Сургалтуудыг орон нутгийн боловсролын газар, насан туршийн боловсролын төвүүдийг түшиглэн зохион байгуулах
Хөтөлбөр 2.1.4: Бага насны хүүхдийн хөгжлийн судалгааны чанар, нийцийг сайжруулан бодлогод тусгах	<ol style="list-style-type: none"> 1. 5 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийн судалгааг гурван жил тутамд зохион байгуулж, хүүхдийн хөгжлийн үндэсний жишиг (бенчмарк)-ийг тогтоох 2. Судалгааны үр дүнг СӨБ-ын сургалтын хөтөлбөр, арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад тусгах 3. 5 настай хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үндэсний үнэлгээг жил бүр зохион байгуулах
Зорилт 2.2 (Хүртээмж): Хөгжлийн онцлог, газарзүйн байршил, нийгэм, эдийн засгийн нөхцөлөөс үл хамааран бүх хүүхдийн СӨБ-ын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх	
Хөтөлбөр 2.2.1: Цэцэрлэгийн дэд бүтэц, орчныг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Цэцэрлэгийн хүчин чадал, бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоох 2. Цэцэрлэгийн насны хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан хүчин чадлыг нэмэгдүүлэх 3. Гадаа жорлонтой цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох 4. Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилттой нийцүүлэн жендэрийн мэдрэмжтэй тоглоом, сургалтын материалаар хангах¹²¹

¹¹⁹ Тус багцад эцэг эхийн нийгэм, эдийн засгийн ялгаа, бичиг үсэгт тайлагдсан байдлыг харгалзан тусгасан байна

¹²⁰ БШУЯ. (2017). Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого 2017-2024, А130 дугаар тушаалын хавсралт

¹²¹ Заавар ном, будах ном, үлгэрийн ном гэх зэрэг

Хөтөлбөр 2.2.2: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар, шим тэжээл, илчлэгийг нэмэгдүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Хүүхдийн хоолны шим тэжээл, илчлэгийг нормд хүргэх 2. Цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн ажилтны ур чадварыг сайжруулах 3. Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлж, эцэг эх, асран хамгаалагчаас тодорхой хувийг гаргуулах
Хөтөлбөр 2.2.3: Хот, хөдөөгийн бага орлоготой өрхийн хүүхдийг шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах	<ol style="list-style-type: none"> 1. БУМС дахь эмзэг, бага орлоготой өрхийн мэдээллийн санг ХНХЯ-ны мэдээллийн баазтай уялдуулах 2. Сургалтын шаардлагатай хэрэглэгдэхүүн, эрүүл ахуйн материалын жагсаалтыг шинэчилж, цэцэрлэг, хүүхдийн асрамжийн төвд нийлүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх
Хөтөлбөр 2.2.4: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэгт хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх 2. Тусгай цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр хангах 3. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, шинж чанарт тохирсон, жендэрийн мэдрэмжтэй сургалтын модуль боловсруулах 4. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлогийг харгалзан сургалтыг зайнаас, онлайн болон танхимын орчинд явуулах арга зүйн сургалтыг СӨБ-ын багш нарт зохион байгуулах
Хөтөлбөр 2.2.5: Нээлттэй боловсролын хөтөлбөр	<ol style="list-style-type: none"> 1. Хүүхэд, эцэг эхчүүдэд зориулсан нээлттэй, цахим, онлайн, зайн сургалтын агуулга, хэрэглэгдэхүүний сан, платформыг их, дээд сургууль, мэргэжлийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага болон хувийн хэвшилтэй хамтран хөгжүүлэх 2. Цэцэрлэгийн мэдээлэл, харилцаа технологийн дэд бүтцийг сайжруулах 3. Нээлттэй, онлайн, зайн сургалтын агуулга, нөөцийн чанарыг баталгаажуулах мэргэжлийн байгууллагад дэмжлэг үзүүлэх

Зорилт 2.3 (Менежмент): СӨБ-ын зохион байгуулалт, менежментийн үр ашигтай байдлыг сайжруулах

Хөтөлбөр 2.3.1: Хөтөлбөр 2.1 (чанар)-ийн хэрэгжилтийг дэмжих хүрээнд чанарын баталгаажуулалтын механизмыг бий болгох	<ol style="list-style-type: none"> 1. СӨБ-ын байгууллагын чанарын дотоод баталгаажуулалтын стандарт¹²² боловсруулж, мөрдөх 2. Чанарын дотоод баталгаажуулалтын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх 3. Чанарын дотоод баталгаажуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх
---	---

4.2.2 Бага, дунд боловсрол

Зорилго: Монгол хэл, түүх, соёлыг дээдэлсэн, хүмүүжил төлөвшилтэй, дэлхийд өрсөлдөх иргэнийг бэлтгэх чадвартай багш бүхий, тэгш хамруулсан, үр ашигтай бага, дунд боловсролыг хөгжүүлнэ.

Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт монгол хүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлсэн байдаг. Монголчууд өрсөлдөх чадвараа дээшлүүлэхийн тулд эрэл хайгуулд суурилсан суралцахуйн шинэ ур чадвар

болон “зөөлөн ур чадвар” эзэмшиж, аж үйлдвэрийн шинэ хувьсгалтай зэрэгцэн эдийн засгийн үйл ажиллагааны хэв шинжийг эрс өөрчилж буй боломж бололцоонд бэлтгэгдсэн байх хэрэгцээ үүсэж байна. Шинэ технологиуд хурдацтай хөгжин, бүх томоохон үйлдвэрлэлийн салбарт нөлөө үзүүлж байгаа нь ажлын байрны хэв шинжийг өөрчилсөөр байна. Мөн бага, дунд боловсролын суралцагчид хөдөлмөрийн суурь ур чадварыг эзэмших, багаар ажиллаж сурах, нийгмээрээ хамтдаа жигд хөгжих шаардлагатай байна.

¹²² Шалгуур үзүүлэлт, заавар, үзэл баримтлалыг багтаасан байна

Монгол Улс ЭЗХАХБ-ын сурлагын амжилтын олон улсын үнэлгээнд 2022 онд хамрагдана. Энэ үнэлгээний үр дүнг сайжруулахын тулд суралцагчдын зөөлөн ур чадвар, шинжлэх ухааны аливаа асуудалд эрэл хайгуул хийх чадварыг бага, дунд боловсролын үнэлгээнд тусгах шаардлагатай.

1. Зорилтууд

Зорилт 3.1 (Чанар): Бага, дунд боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах

Хүрэх үр дүн: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын амжилтад ахиц гарч, хот, хөдөөгийн сурагчдын үнэлгээний гүйцэтгэлийн ялгаа багассан байна.

Бага, дунд боловсролын чанартай холбоотой тулгамдсан асуудал нь ЕБС-ийн суралцагчийн сурлагын амжилт 60-аас доош хувьтай, хот хөдөөгийн суралцагчийн гүйцэтгэлийн зөрүү их байна. Сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээгээр багшийн мэргэжлийн чадавх гол хүчин зүйл болж байна. Иймд багшийн мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх шаардлагатай. Багш бэлтгэх их, дээд сургуулиуд нэгдсэн хөтөлбөргүй, төгсөгчдийн чанар харилцан адилгүй, орон нутгийн болон үндэсний хэмжээний мэргэжил дээшлүүлэх сургалт хоорондоо уялдаагүй, сургалтын агуулга нь багшийн зайлшгүй эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагад нийцэхгүй байна¹²³. ЕБС-ийн багшийн тасралтгүй хөгжлийг хангахад ажлын байрандаа хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэхэд тусгайлсан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, цахим, онлайн, зайн сургалтуудыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Нөгөө талаас сурлагын амжилтыг тодорхойлж буй үндэсний, орон нутгийн болон сургуулийн түвшний үнэлгээний үр дүн хоорондоо зөрүүтэй байна. Тухайлбал, 2018 оны чанарын судалгаа, улсын шалгалт болон сургуулийн өөрийн үнэлгээний дундаж оноо

хоорондоо бага боловсролд 31.1–41.1, суурь боловсролд 29.4–46.8, бүрэн дунд боловсролд 30.1–51.5 хувийн зөрүүтэй тус тус байсан. Энэ зөрүү нь үнэлгээний арга, аргачлал түвшин бүрд өөр өөрөөр ойлгогддог, үнэлгээний даалгаврын боловсруулалт харилцан адилгүй, гүйцэтгэлийг үнэлэх арга зүй тодорхойгүй, үнэлгээний даалгавар боловсруулагчдын чадавх дутагдаж байгаатай холбоотой¹²⁴. Иймээс ЕБС-ийн суралцагчийн үнэлгээнд шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай юм.

Бага, дунд боловсролын чанарт нөлөөлж буй өөр нэг хүчин зүйл нь сургалтын хөтөлбөр ойр ойрхон өөрчлөгддөг явдал. Энэ асуудлыг шийдвэрлэх нэг арга зам хөтөлбөрийн менежментийн бодлоготой байх, түүний дагуу тодорхой циклийн давтамжтай хөтөлбөрийг сайжруулах юм. 2018 онд хөтөлбөрийн менежментийн циклийг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2019 онд хийсэн судалгаанаас хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагаа тодорхойгүй байгаа нь харагдсан. Хөтөлбөрийн менежментийн циклийг 10 жилээр тогтоосон нь технологийн хөгжлийн хурд, олон улсын үнэлгээний үр дүнтэй харгалзахад төдийлөн тохиромжтой бус гэж үзэхээр байна. Иймд хөтөлбөрийн менежментийн циклийн хугацааг оновчтой тогтоох, талуудын оролцоог үйл ажиллагааны чиглэлтэй нийцүүлэн сайжруулах, тогтмол үнэлж дүгнэх, сургалтын чанарыг дээшлүүлэхэд үр дүнг ашигладаг байх хэрэгтэй. 2025 он хүртэл хөтөлбөрийн менежментийн цикл оролцох байгууллагын чиг үүрэг, оролцоо, хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацааг боловсролын бодлогын төлөв, шинэчлэл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдалтай нийцүүлэн эргэж дүгнэнэ.

Ахлах ангийн суралцагчид хөтөлбөр, хичээлээ сонгон судалдаг боломжтой ч дараагийн түвшний боловсрол, сургалттай залгамж холбоогүй байна. Ийм учраас сонгон судалсан хөтөлбөрийн онцлогт тохирсон үнэлгээ, баталгаажуулалт байх шаардлагатай.

¹²³ АХБ, БШУЯ. (2019). Бага, дунд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

¹²⁴ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

Зорилт 3.2 (Хүртээмж): Хөгжлийн онцлогоос үл хамааран суралцагчийн бага, дунд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Газар зүйн байршил, нийгэм эдийн засгийн нөхцөл, хөгжлийн онцлог, ялгаатай байдлаас үл хамааран бага, дунд боловсролын чанартай үйлчилгээнд бүрэн хамрагдсан байна.

БДБ-ын хүртээмжтэй холбоотой суурь асуудал нь 2030 он хүртэлх ЕБС-ийн насны хүн амын өсөлттэй холбоотой юм. 6-18 насны хүн амын өсөлтийн төсөөллөөс харахад 2018 онтой харьцуулахад дунд, ахлах ангийн суралцагчийн тоо 2024 онд 56 хувь, 2030 онд 71 хувь өсөх төлөвтэй байна. “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн нэг ангид ноогдох хүүхдийн тоог 20-оос хэтрүүлэхгүй байх зорилтыг хэрэгжүүлэхэд 2030 он хүртэл ЕБС-д 43,104 орчим суудал нэмэх шаардлагатай байна. Энэ нөхцөл байдлаас шалтгаалан суудлын тоог тухайн хичээлийн жилийн эрэлтэд нийцүүлэн үе шаттай нэмэгдүүлэх нь хүртээмжтэй холбоотой суурь асуудлыг шийдэх арга зам юм.

Нөгөө талаас сургуулийн насны хүүхдийн тооны өсөлтөөс хамаарч багшийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Багш бэлтгэх их, дээд сургууль төгсөгчийн тооны өнөөгийн эрчим буурахгүй тохиолдолд багшийн нийлүүлэлтэд төдийлөн их асуудал гарахааргүй байна. Харин далд хомсдолыг арилгах шаардлагатай байгаа ба ЕБС-ийг бүтэц, байршил, хэв шинжийн хувьд дахин зураглаж, зохион байгуулахад энэ асуудал шийдэгдэх боломжтой юм.

БДБ-ын тэгш хамран сургалттай холбоотой тулгамдаж буй асуудал нь тусгай хэрэгцээт суралцагчид ЕБС-д бусад суралцагчдын адил тэгш хамрагдаж чадахгүй байгаа явдал билээ. Одоогоор тэдний дийлэнх нь тусгай сургуульд суралцаж байгаа ба энгийн ЕБС-д хамрагдалт маш бага байна. Гол шалтгаан нь сургуулийн орчин тэдний хэрэгцээнд нийцдэггүй, багш нар тусгай хэрэгцээт суралцагчдыг хүлээж авахаас зайлсхийдэг явдал юм. Учир нь

тэдэнд ийм онцлогтой хүүхэдтэй ажиллах мэргэжлийн ямар нэг бэлтгэл байхгүй байна. Сургалтын байгууллагад хамрагддаггүй тусгай хэрэгцээт суралцагчийн хувьд НТБ-ын төвөөр дамжуулан дүйцсэн сургалтад хамрагддаг хэдий ч энэ нь тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээтэй төдийлөн нийцдэггүй учраас удалгүй орхих хандлагатай байна. Үүнийг шийдэх боломжит арга зам нь сургалтын арга, хэлбэрийг өөрчлөх, төрлийг нэмэгдүүлэх мөн нээлттэй, цахим, зайн, онлайн сургалтаар дамжуулан насан туршдаа суралцах, үр дүнг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах боломжийг олгох юм.

БДБ-ын хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэхэд суурь шийдлүүд болох сургуулийн үдийн хоолны үйлчилгээг нэвтрүүлэх, түүний аюулгүй байдлыг хангах, сурах бичгийн хангамж, дотуур байрны үйлчилгээг нэмэгдүүлэх арга хэмжээг тасралтгүй сайжруулах шаардлагатай. Сурах бичгийн хангамжийн хувьд тулгардаг хамгийн том бэрхшээл нь дунд болон ахлах ангид сурах бичгийн түрээсийн хуримтлалын сангийн ашиглалттай холбоотой асуудал учраас үүнийг БДБ-ын менежментийн зорилтын хүрээнд авч үзсэн. Түрээсийн төлбөрөөс хуримтлагдсан сан нь сурах бичгийг дахин хэвлэх, засварлахад зарцуулагдах ёстой тул түрээсийн санхүүжилтийг оновчтой болгох шаардлагатай.

Зорилт 3.3 (Менежмент): ЕБС-ийн зохион байгуулалт, менежментийн үр ашгийг сайжруулах

Хүрэх үр дүн: Ерөнхий боловсролын сургуулийн дотоод үр ашиг сайжирч, үр дүнг тооцдог чанарын баталгаажуулалттай болсон байна.

БДБ-ын удирдлага, зохион байгууллагатай холбоотой нэн тэргүүнд тулгамдаж буй асуудал нь сургуулийн бүтэц, байршил, хэв шинжтэй холбоотой. Нийслэл, аймаг, сумдад хүн амын тоо, сургуулийн хүчин чадлаас үл хамааран бүрэн дунд сургууль олон байгаа нь боловсролын үйлчилгээг үр ашиггүй болгож байна. Сургуулийн хүчин чадал, суралцагчийн тооноос хамааруулан ээлжийн

коэффициентыг тооцож үзэхэд бүх сургуулийн тэн хагас нь 0.5-аас доош байгаа нь тухайн сургууль үр ашиггүй ажиллаж байгааг илэрхийлнэ. Сургуулийн бүтэц, байршил нь хүн ам сийрэг, цөөн байдаг хөдөө, орон нутгийн хувьд онцгойлон авч үзвэл зохих, “сургуулийн насны хүүхэд боловсролын үйлчилгээ хүртэх эсэх тухай асуудал нь зөвхөн биеэр сургуульд хамрагдах боломжоос гадна эдийн засаг, нийгэм-соёлын бусад хүчин зүйлтэй холбоотой ойлголт” болохыг анхаарч үзэх шаардлагатай байна. Үүнд, сургууль ба гэр хүртэлх зай, зарцуулагдах хугацаа, тээврийн хэрэгсэл, тухайн орон нутгийн байгаль, газар зүйн онцлог (уул, даваа, ус гол гэх мэт бартаа саад)-ийг тооцсон хамран сургах тойргийг тогтоох, нөгөөтээгүүр сургуулийн хүчин чадлын стандарт ба хамгийн их, хамгийн бага хэмжээг тооцох нь бага, дунд боловсролын системийн дотоод үр ашгийг оновчлох асуудалтай холбоотой.

Ахлах ангийн суралцагчид ирээдүйд эзэмших ажил мэргэжлийн баримжаандаа түшиглэн хичээлээ сонгон судлах зохицуулалттай хэдий ч хөдөө орон нутаг, тэр дундаа хүн ам цөөнтэй сумын сургуулиудад хэрэгжих боломжгүй байна. Тэд сонгосон хичээлээ сумын сургуулийн багшийн нөөц,

төсвийн хомсдолоос шалтгаалан судалж чаддаггүй. Энэ нь суралцагчийн цаашдын сонголтод сөргөөр нөлөөлж байна. Үүнийг шийдэх арга зам нь ЕБС-ийн бүтэц, байршил, хэв шинжийг тухайн орон нутгийн хүн амын тоо, цаашдын хандлага, нийгэм, эдийн засгийн онцлогоос шалтгаалан дахин зураглаж, төрөлжсөн ахлах сургуулийг үе шаттай байгуулах явдал юм. Төрөлжсөн ахлах сургууль нь багш нарыг мэргэжлийн чиглэлээр хамтран үр дүнтэй ажиллах, сургалтыг чанартай зохион байгуулах, сургуулийн хөрөнгө оруулалтыг төрөлжсөн чиглэлээр үр ашигтай хийх, суралцагчдад сонгосон хичээлээ ямар нэг саад бэрхшээлгүй судлах, сургалтын орчныг бүрдүүлэх, төсвийг үр ашигтай зарцуулах зэрэг олон давуу талыг бий болгоно.

БДБ-ын удирдлага, менежменттэй холбоотой асуудал нь ЕБС-ийн чанарын баталгаажуулалт сургалтын орц, явц, гарцын алинд ч хангалтгүй байгаа бөгөөд энэ нь чанарын хяналт, үнэлгээний тогтолцоо байхгүйгээс үүдэлтэй юм. ЕБС бүрд чанарын дотоод баталгаажуулалтыг бэхжүүлэх, түүнийг нь хөндлөнгөөс баталгаажуулдаг тогтолцоо бий болгох нь үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал юм.

2. Зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа

Хөтөлбөр	Үйл ажиллагаа
Зорилт 3.1 (Чанар): Бага, дунд боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах	
Хөтөлбөр 3.1.1: БДБ-д монгол хэл, түүх, соёл, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан Монгол хүүхдийн хүмүүжлийг дээдэлсэн, хүүхдийн онцлогт нийцсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	<ol style="list-style-type: none"> БДБ-ын сургалтын цөм хөтөлбөрийн агуулгыг монгол хүүхдийг төлөвшүүлэх, эх хэл, түүх, соёл, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулах, сайжруулах Сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, материалд тавигдах шаардлагыг шинэчилж, нээлттэй, сонголттой, цахим эх үүсвэрүүдийг бий болгох Хүүхдийн хөгжлийн онцлог, суралцах чадамжид суурилсан уян хатан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох Хүүхдийн цогц хөгжлийн судалгаа хийж, хүүхдийн хөгжлийн жишиг үзүүлэлтүүдийг гурван жил тутамд тодорхойлох Ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг өргөжүүлэх, жендерийн мэдрэмжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Хөтөлбөр 3.1.2: Чадварлаг багш арга хэмжээ хэрэгжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Бага, дунд боловсролын багшид тавигдах мэргэжлийн нэгдсэн шаардлага буюу “Багш мэргэжлийн стандарт”¹²⁵ боловсруулах 2. Бага, дунд боловсролын багш бэлтгэх хөтөлбөрийг сайжруулсан хөтөлбөртэй уялдуулан шинэчилж, багш бэлтгэх 3. Бага, дунд боловсролын багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог уян хатан болгож, хэрэгжүүлэх (одоо мөрдөж буй журмыг шинэчлэх) 4. Багш нарт мэргэжлийн ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх 5. ЕБС-д тусгай боловсролын багшийг давтан сургах, сэтгэл зүйч ажиллуулах 6. Залуу багшийг дадлагажуулах сургуульд суурилсан ментор сургалтыг хөгжүүлэх
Хөтөлбөр 3.1.3: Бага, дунд боловсролын үнэлгээг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг үнэлэх судалгааг жил бүр зохион байгуулж, үр дүнд суурилан чанарыг сайжруулах 2. 2022 онд олон улсын PISA үнэлгээнд хамрагдах 3. Олон улсын үнэлгээний үр дүнд үндэслэн үнэлгээг шинэчлэх 4. Үнэлгээг хэрэгжүүлэх багш, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэх 5. БҮТ-ийн математик, байгалийн ухааны даалгаврын санг шинэчлэх 6. Анги дэвших ба сургууль төгсөх шалгалтын даалгаврыг сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтод нийцүүлэн боловсруулж хэвших 7. Улс, орон нутаг, сургуулийн шалгалт, анги танхимын үнэлгээний залгамж холбоо, нийцийг сайжруулах үйл ажиллагаануудыг санаачлан хэрэгжүүлэх
Хөтөлбөр 3.1.4: Хөдөө орон нутгийн ЕБС-ийн чанарыг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Багш нарын хөгжих хэрэгцээг тодорхойлох үнэлгээг орон нутгийн боловсролын газрууд жил бүр хийж, үр дүнг мэргэжил дээшлүүлэх төлөвлөлтөд тусгах 2. Хөдөө, орон нутгийн ЕБС-д зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх 3. Аймаг, сумын сургуулиудад удирдлага болон багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх 4. Хөдөө, орон нутгийн багшийн МХТ-ийн чадварыг хөгжүүлэх 5. Сургалтын цагийн норм хүрэхгүй байгаа¹²⁶ багш нар дотуур байрны хүүхдүүдэд нэмэлт дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг нэвтрүүлэх

Зорилт 3.2 (Хүртээмж): Хөгжлийн онцлогоос үл хамааран суралцагчийн бага, дунд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх

Хөтөлбөр 3.2.1: ЕБС-ийн дэд бүтэц, барилга байгууламжийг сайжруулах хөтөлбөр	<ol style="list-style-type: none"> 1. Сургуулийн хүчин чадал, дэд бүтэц, барилгын насжилт, байршлыг оновчтой тогтоох 2. ЕБС-ийн насны хүн амын өсөлттэй уялдуулан сургуулийн хүчин чадлыг нэмэгдүүлэх 3. Нүхэн жорлонтой ЕБС, дотуур байрыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох 4. ЕБС-ийн дотуур байрны орчны стандартын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх 5. ЕБС, дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээг стандартын шаардлагад нийцүүлэх, суралцагчдыг эрүүл аюулгүй, шим тэжээллэг хоол хүнсээр хангах 6. ЕБС-ийн тавилга, хэрэглэгдэхүүн, зөөлөн эдлэлийг орон нутагт түшиглэн стандартын дагуу үйлдвэрлэх зохион байгуулалтаар хангах
---	--

¹²⁵ Тус стандарт нь “Багшлах эрх олгох, хасах журам”-д нийцсэн байна

¹²⁶ Долоо хоногт 19 цаг гэж журамд заасан байдаг

Хөтөлбөр 3.2.2: БДБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш боломжоор хангах	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа ЕБС-д хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх 2. Тусгай сургуулийн барилгыг өргөтгөх, шинэчлэх, тавилга, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр хангах 3. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, шинж чанарт тохируулан сургах арга зүйг багш нарт эзэмшүүлэх сургалтын модуль боловсруулж, багш нарыг чадавхжуулах
--	--

Хөтөлбөр 3.2.3: Нээлттэй боловсролыг дэмжих хөтөлбөр	<ol style="list-style-type: none"> 1. Орон нутагт ЕБС-д түшиглэсэн нээлттэй, цахим, зайн болон онлайн сургалтын төв байгуулах 2. Суралцагчид хөгжлийн онцлог, орон зай, цаг хугацаанаас үл хамааран БДБ-ын үйлчилгээ хүртэх, өөрийгөө бие даан хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжааны боломжийг олгох нээлттэй, онлайн, зайн сургалтыг их, дээд сургууль, мэргэжлийн байгууллага болон хувийн хэвшилтэй хамтран хөгжүүлэх, чанарыг баталгаажуулах, нээлттэй сургалтын агуулга, хэрэглэгдэхүүний сан бий болгох 3. Багш нарт ажлын туршлага, байршил, цаг хугацаанаас үл хамааран нээлттэй, зайн болон онлайн сургалтаар ашиглах нөөцийг бүрдүүлэх 4. Нээлттэй, зайн болон онлайн сургалтын нөөцийг боловсруулах тэдгээрийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах талаар сургуулийн удирдлагууд, багш нарын чадавхыг бэхжүүлэх 5. Албан болон албан бус сургалтын орчноос эзэмших боловсролын үр дүнг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх механизмыг бий болгох
---	---

Хөтөлбөр 3.2.4: Хэвлэмэл болон цахим сурах бичгийн тогтолцоог бэхжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Сурах бичгийг түрээсийн төлбөрөөр хуримтлалын санг бүрдүүлж хэвлэмэл болон цахим сурах бичгийг зохиох, хэвлэн нийтлэх, түгээх, ашиглах, сайжруулах, үйл ажиллагааг төлөвлөж, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх 2. Сурах бичгийн хэрэглээний судалгааг хоёр жил тутамд хийх
--	---

Зорилт 3.3 (Менежмент): Ерөнхий боловсролын сургуулийн зохион байгуулалт, менежментийн үр ашгийг сайжруулах

Хөтөлбөр 3.3.1: Төрөлжсөн ахлах сургууль байгуулах	<ol style="list-style-type: none"> 1. Төрөлжсөн ахлах сургууль байгуулах хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийх, төрөлжих чиглэлүүдийг оновчтой болгох, ахлах сургууль байгуулах зураглал боловсруулж, батлуулах 2. Төрөлжсөн ахлах сургууль байгуулахад шаардагдах санхүүгийн болон хүний нөөцийн урьдчилсан тооцоо хийж, сургуулийн барилга, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний хөрөнгө оруулалтыг үе шаттай хийх 3. Улаанбаатар хот, аймаг, зарим сумдад төрөлжсөн ахлах сургууль байгуулах 4. Ахлах сургуулийн багш нарыг давтан сургах 5. Ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөртэй сургуулийг аймаг, нийслэлд үе шаттай байгуулах
---	--

Хөтөлбөр 3.3.2: БДБ-ын үйлчилгээний үр ашгийг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Сургуулийн байршил, бүтэц (бага, дунд, ахлах) ба хэв шинжийн зураглал боловсруулж, үр ашгийг сайжруулах зөвлөмж боловсруулах 2. Одоо байгаа сургуулийн байгууламж, багшийн хангамжийг харгалзан сургуулиудыг хэв шинж, байршил, бүтцээр нь дахин төлөвлөж зохион байгуулах 3. Дээрх төлөвлөгөөний дагуу ЕБС-ийг үе шаттайгаар дахин зохион байгуулах (дор хаяж 3 бүсэд) 4. БУМС-ийн шалгуур үзүүлэлтийг боловсролын бодлого, төлөвлөлттэй холбоотойгоор нэмэгдүүлэх 5. БУМС-ийн мэдээллийг бодлогын төлөвлөлтөд үр дүнтэй ашиглах чиглэлээр мэргэжлийн байгууллагын ажилтнууд, удирдлагын чадавхыг бэхжүүлэх
---	---

Хөтөлбөр 3.3.3: Сургуулийн чанарын дотоод баталгаажуулалт	1. Сургуулийн чанарын дотоод баталгаажуулалтын стандарт ¹²⁷ , арга хэрэгслийг боловсруулах 2. Сургуулийн удирдлага, сургалтын менежер, орон нутгийн боловсролын газрын мэргэжилтнүүдийг чадавхжуулах
--	--

4.2.3 Мэргэжлийн боловсрол, сургалт

Зорилго: Төр хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын зохицуулалтын механизмыг бэхжүүлэх замаар МБС-ыг олон улсын стандартад нийцүүлнэ.

МБС-ын салбар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж, төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, МБС-ын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер, техникийн ажилтны түвшинд чадваржуулах, үйлдвэрлэл-дадлагын сургалтын бааз, лабораторийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх¹²⁸ зорилтуудыг чиг баримжаа болгон хэрэгжүүлж байна.

Цаашид салбар дундын зохицуулалт бүхий салбарын засаглал удирдлагын тогтолцоог бүрдүүлэх замаар шинэчлэлийн зорилтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

1. Зорилтууд

Зорилт 4.1 Иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадварын хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, олон улсын түвшинд нийцүүлэн МБС-ын чанарыг сайжруулна.

Хүрэх үр дүн: МБС-ын төгсөгчдийн чадамж хөдөлмөрийн зах зээлийн ур чадварт нийцсэн байна.

МБС-ын чанарыг ахиулж, төгсөгчдийн

хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байранд шаардагдах ур чадвар, хандлага, төлөвшил, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, бие даан бизнес эрхлэх чадварыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх тухайн мэргэжлийн ажлын байранд тавигдах мэргэжлийн ур чадвараас гадна хувь хүнд тавигдах ерөнхий ур чадварууд МБСБ-ын төгсөгчдөд хангалттай бус байна¹²⁹. ХЗЗ-ийн эрэлт, хэрэгцээ, эдийн засгийн тэргүүлэх салбар, томоохон бүтээн байгуулалтад шаардлагатай ажиллах хүчний тоон болон чанарын судалгаа мэдээлэл дутмаг, богино хугацаанд эрэлтийг тодорхойлж, мэдээлэх механизм бүрдээгүй.

ХЗЗ-ийн эрэлтэд үндэслэн МБС-ын стандарт, хөтөлбөрийг боловсруулан шинэчлэхдээ техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын агуулгын залгамж холбоог хангах шаардлагатай.

Чадамжид суурилсан сургалтын орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, дадлагын материал түүхий эдийн хангамж, санхүүжилт хүрэлцээгүй¹³⁰.

Шинээр багш бэлтгэх, багшийн мэргэжил, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх хүрээнд дижитал ур чадвар, мэдээллийн технологи, гадаад хэл, ногоон боловсрол, хөрвөх ур чадваруудыг эзэмшүүлэх шаардлагатай. МБС-д багш бэлтгэх, давтан сургах тогтолцоо төлөвшөөгүй байгаатай^{131,132,133,134}

¹²⁷ Шалгуур үзүүлэлт, заавар, үзэл баримтлалын хамт

¹²⁸ ХНХЯ. (2016). Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2021

¹²⁹ ХНХСИ. (2018). Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

¹³⁰ АХБ, БШУЯ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинжилгээний тайлан

¹³¹ ХНХЯ. (2019). ХНХЯ-ны сайд С. Чинзориг “МБС-ын багшийн шинэ дүр төрх” илтгэл

¹³² ХНХЯ. (2016). Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2021

¹³³ ЮНЕСКО, БХ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын тойм шинжилгээ

¹³⁴ ХНХЯ. (2019). Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх, төр хувийн хэвшлийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааны санамж бичиг. 6 дугаар зүйл

холбогдуулан шинээр нэвтэрч буй техник, технологийн өөрчлөлттэй уялдуулан багш нарыг үйлдвэрлэл, ажлын байранд нь мэргэшил, ур чадварыг сайжруулах тусгай хөтөлбөрийг хувийн хэвшил, ажил олгогчтой хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй.

МБС-ын техник, технологи, инновацийн судалгааг институцийн түвшинд хүргэх^{135, 136, 137}, аж үйлдвэрийн ирээдүйн хувьсгал, өөрчлөлтөд мэдрэмж бүхий МБС-ын тогтолцоог бий болгох нь МБС-ын салбарын тэргүүлэх зорилтуудын нэг болж байна.

Зорилт 4.2 Иргэд насан туршдаа суралцаж, мэргэжил, ур чадвар эзэмших, мэргэшлийн түвшин дээшлүүлэх уян хатан нөхцөл, нээлттэй сургалтын боломжийг олгох замаар МБС-ын хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлнэ.

Хүрэх үр дүн: Иргэд нээлттэй, онлайн, зайн хэлбэрээр мэргэжлийн ур чадвар эзэмшдэг, үр дүнгээ хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулдаг болсон байна.

МБС-ын тухай ойлголт, ажил мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтын талаар хүүхэд, эцэг эх, зорилтот бүлгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид сурталчлан таниулах, салбарын нийгэм дэх эерэг хандлага, нэр хүндийг дээшлүүлэх үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Судалгаанаас харахад МБС-ын нэр хүнд тааруу байгаа нь хүртээмжид нөлөөлөх гол шалтгаан байна.

Иргэдийг насан туршдаа тасралтгүй сурч боловсрох, мэргэжлийн ур чадвар, чадамж эзэмших боломжийг олгох чиглэлээр албан сургалтаас гадна нээлттэй, онлайн, зайн сургалтыг явуулах, өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг тогтмолжуулахад бодлого төлөвлөлт, хүний нөөц, санхүүгийн дэмжлэг дутагдалтай¹³⁸.

МБС-ын байгууллагад суралцагчдын 2 орчим хувийг тусгай хэрэгцээт суралцагчид эзэлж байна.

Үндэсний хэмжээнд тусгай хэрэгцээт иргэдэд чиглэсэн МБСБ цөөн байна. Тэгш хамран сурах боломжийг нэмэгдүүлэхэд тусгай сургалтын байгууллага байгуулахаас илүүтэй МБСБ-д мэргэжлийн онцлогоос шалтгаалан тохируулгат орчныг бий болгож тэдэнд бусад үе тэнгийнхэнтэйгээ мөр зэрэгцэн суралцах боломжийг олгох хэрэгтэй юм. Тусгай хэрэгцээт болон бусад суралцагчдад чиглэсэн дэмжлэг хүртээмж, тэгш хамран сургалтад чухал үүрэгтэй. МБС-ын салбарын хувьд оюутныг дэмжих үйлчилгээний гол зорилго бол элсэгчид болон суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, төгсөгчдийн бизнес эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх, боловсролын болон хөдөлмөрийн зах зээлд зуучлах, мэдээллээр хангах, дадлага сургалтыг ААН-тэй хамтран зохион байгуулах явдал юм.

Олон улсын донор байгууллагуудын төслүүдийн дэмжлэгээр сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хангамж хүрэлцээ тасралтгүй нэмэгдсээр байгаа ч зарим сургалтын байгууллагад олон жил ашиглаж буй тоног төхөөрөмж, барилга байгууламж, тавилга, эд хогшил, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг орчин үеийн хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Зорилт 4.3 Төр хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын зохицуулалт бүхий МБС-ын бие даасан засаглал, удирдлагыг боловсронгуй болгоно.

Хүрэх үр дүн: МБС-ын асуудал эрхэлсэн бие даасан, салбар дундын байгууллагатай болсон байна.

МБС-ын удирдлагын тогтолцоо нь салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал, тогтвортой байдлыг хангахгүй байна¹³⁹.

¹³⁵ ХНХЯ. (2019). ХНХЯ-ны сайд С. Чинзориг “МБС-ын багшийн шинэ дүр төрх” илтгэл

¹³⁶ АХБ, БШУЯ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинжилгээний тайлан

¹³⁷ ХНХЯ. (2016). Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2021

¹³⁸ АХБ, БШУЯ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинжилгээний тайла

¹³⁹ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын салбарын суурь мэдээллийн тайлан

МБС-ын салбар нь ХЗЗ-ийн эрэлтээр удирдуулсан, салбар дундын зохицуулалт бүхий^{140, 141} онцлогтой салбар юм. Ажил олгогчийн оролцоо, бусад салбарын дэмжлэггүйгээр үндэсний ажиллах хүчнийг бэлтгэх боломжгүй учир төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан бие даасан удирдлагын тогтолцоог цаашид бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэх, МБС-ын санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд МБСБ-ыг төрөлжүүлэх, хотхон хэлбэрээр хөгжүүлэх бодлого боловсруулах, төсөл, хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага байна.

МБСБ-ын чанарын удирдлага, ЧСС-ын үнэлгээ, гэрчилгээжүүлэх тогтолцоог сайжруулах хэрэгтэй.

МБС-ын салбарын ойрын болон ирээдүйн тэргүүлэх зорилтуудын нэг бол ХЗЗ-ийн мэдээллийн ашиглалтыг сайжруулж, МБС-ын үйл ажиллагаа, бодлого төлөвлөлтөд оновчтой ашиглах явдал юм. Салбарын бодлогын баримт бичгүүдэд энэхүү үйл ажиллагааг зорилт болгосон байдаг. 2019 онд ЮНЕСКО-оос Монгол Улсын МБС-ын салбарт хийсэн бодлогын тойм судалгаанд ХЗЗ-ийн мэдээллийг ашиглах, бодлогын уялдаа холбоог сайжруулах талаар зөвлөмж^{142,143} өгсөн. Иймд ирэх таван жилд МБС-ын салбарын нэг зорилт бол ХЗЗ-ийн болон МБС-ын салбарын мэдээллийн уялдаа холбоог сайжруулах болно.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажиллах хүчний тоон мэдээллээс гадна шаардлагатай байгаа ажиллах хүчний ур чадвартай холбоотой судалгааг тогтмолжуулах нь МБС-ын чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлнэ.

2. Хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа

Хөтөлбөр	Үйл ажиллагаа
Зорилт 4.1 (Чанар): Иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадварын хэрэгцээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлага, олон улсын түвшинд нийцүүлэн МБС-ын чанарыг сайжруулах	
Хөтөлбөр 4.1.1: Сургалтын чанар, эрэлтийн нийцлийг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Ажил мэргэжлийн лавлах, МБС-ын стандарт, ЧСС-ын хөтөлбөрийг ажил олгогч, мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулж, баталгаажуулах 2. ХЗЗ-ийн эрэлтэд нийцүүлэн МБС-ын стандарт, хөтөлбөрийг шинэчлэхдээ техникийн боловсрол, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын агуулгын залгамж холбоог хангах 3. ҮМХ-нд нийцүүлэн техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийг их, дээд сургуулийн хөтөлбөрийн агуулгатай дүйцүүлэх 4. Мэргэжлийн болон хувь хүний хөгжлийн ур чадварыг сургалтын хөтөлбөрт тусгах, хэрэгжүүлэх 5. ЧСС-ын орчин, хэрэглэгдэхүүн, дадлагын материал, нөөцийн хангамж, хүртээмжийг сайжруулах 6. МБС-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын байгууллагад дэмжлэг үзүүлэх чиглэлээр захирал, менежер, арга зүйч, багш болон үйлдвэрлэлийн сургагч нарт сургалт зохион байгуулах 7. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийх арга зүйн сургалт зохион байгуулж, өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний үр дүнд нийцүүлэн хөтөлбөрийн чанарыг сайжруулах 8. Албан ба албан бус сургалтын агуулга, хэрэглэгдэхүүний сан бий болгох

¹⁴⁰ ЮНЕСКО, БХ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын тойм шинжилгээ

¹⁴¹ ХНХЯ. (2019). ХНХЯ-ны сайд С. Чинзориг “МБС-ын багшийн шинэ дүр төрх” илтгэл

¹⁴² ЮНЕСКО, БХ. (2019). Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын тойм шинжилгээ

¹⁴³ Ts. Batdorj. (2019). Presentation on current utilization of data and information of labor market in Mongolia

Хөтөлбөр 4.1.2: Шинээр багш бэлтгэх, давтан сургах	<ol style="list-style-type: none"> 1. Шинээр багш бэлтгэх, багшийн мэргэжил, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлэх 2. Шинээр багш бэлтгэх, багшийн мэргэжил ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх 3. МБС-ын багшийн нээлттэй, онлайн, зайн сургалтын агуулга, нөөц хэрэглэгдэхүүнийг хөтөлбөрийн дагуу мэргэжлийн байгууллага, чадамжийн төвүүд, их, дээд сургууль, ажил олгогчтой хамтран боловсруулах, хэрэгжүүлэх 4. Нээлттэй, зайн сургалтад хамрагдсан багшийн мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах 5. МБС-ын багшийн хөгжлийн хөтөлбөрийг мэргэжлийн их, дээд сургууль, ажил олгогч, мэргэжлийн холбоод, чадамжийн төвтэй хамтран хэрэгжүүлэх 6. Шинээр нэвтэрч буй техник, технологийн өөрчлөлттэй уялдуулан багш нарыг ажлын байр, үйлдвэрлэл дээр мэргэшил ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх 7. МБС-ын багш нарыг судалгааны арга зүйд сурган судлаач багш нарыг бэлтгэх
---	--

Зорилт 4.2 (Хүртээмж): Иргэдэд мэргэжил, ур чадвар эзэмших, мэргэшлийн түвшин дээшлүүлэх, насан туршдаа суралцахуйн уян хатан нөхцөл боломжийг олгох замаар МБС-ын хүртээмж, тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх

Хөтөлбөр 4.2.1: МБС-ын тэгш хамран сургалтыг нэмэгдүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. МБС-ын тухай ойлголт, эерэг хандлага бий болгож нийгэм дэх нэр хүндийг дээшлүүлэх 2. Албан ба албан бус сургалтыг нээлттэй, онлайн, зайн хэлбэрээр явуулах 3. МБС-ын нээлттэй, онлайн, зайн сургалтыг хэрэгжүүлэгч, оролцогч талуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах 4. Суралцагчийг дэмжих орчин нөхцөл, үйлчилгээний төрөл, чанарыг сайжруулах 5. Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан сонголтот сургалтын хөтөлбөр боловсруулах 6. Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлэгт чиглэсэн мэргэжил эзэмшүүлэх багш, хүний нөөцийг үе шаттай бэлтгэх 7. МБС-ын салбарын жендерийн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх 8. Судалгааны үр дүнд суурилан жендерийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх 9. Ажил мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтын зөвлөх багш, ажилтан бэлтгэх 10. Ажил мэргэжлийн чиг баримжаа, мэргэжил сонголтыг дэмжих олон талт хэлбэрүүдийг дэмжих, хөгжүүлэх.
---	--

Хөтөлбөр 4.2.2: МБС-ын дэд бүтэц орчныг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Сургалтын байгууллагын тоног төхөөрөмж, технологи, симуляцийн төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх 2. Сургууль болон үйлдвэрлэлийн салбар дундын дадлага сургалтын баазыг бүрдүүлэхэд чиглэсэн судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах 3. Салбар дундын дадлага сургалтын баазыг бүрдүүлэх 4. МБСБ-д тусгай хэрэгцээт иргэдэд чиглэсэн мэргэжлийн онцлог бүхий тохируулгат орчинг бий болгох 5. Шаардлагатай тоног төхөөрөмж, барилга байгууламж, тавилга, эд хогшил, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх
---	--

Хөтөлбөр 4.2.3: Насан туршдаа суралцахуйг дэмжих	<ol style="list-style-type: none"> 1. Иргэдэд МБС-д хамрагдах, өөрийгөө бие даан хөгжүүлэх боломж олгох, нээлттэй, онлайн, зайн сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, чанарыг баталгаажуулах 2. Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх тогтолцоог бэхжүүлэх 3. Иргэдэд ажил хөдөлмөр эрхлэх ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвараа ахиулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, үр дүн баталгаажуулах
---	--

Зорилт 4.3 Төр, хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын зохицуулалт бүхий МБС-ын бие даасан засаглал, удирдлагыг боловсронгуй болгох.

Хөтөлбөр 4.3.1: МБС-ын удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлтийг боловсронгуй болгох	<ol style="list-style-type: none"> 1. Салбар дундын зохицуулалттай төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан бие даасан удирдлагын тогтолцоог бүрдүүлэх 2. МБСБ-ыг төрөлжүүлэх, хотхон хэлбэрээр хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх 3. Салбарын санхүүжилтийн механизмыг шинэчлэх 4. МБС-ын удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэх, боловсронгуй болгох 5. БУМС-Мэргэжлийн боловсрол сургалтын мэдээллийн нэгдсэн систем-Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг уялдуулж, ашиглалтыг сайжруулах 6. ХЗЗ-ийн мэдээллийн ашиглалтыг сайжруулж, мэдээллийн систем, статистик мэдээллийг ашиглах чиглэлээр оролцогч талуудад сургалт зохион байгуулах
--	---

Хөтөлбөр 4.3.2: МБС-ын чанарын баталгаажуулалтыг бэхжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. МБС-ын салбарын чанарын удирдлага, ЧСС-ын үнэлгээ, гэрчилгээжүүлэх тогтолцоог сайжруулах 2. Сургалтын байгууллагын дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг хөгжүүлэх 3. МБСБ-ын удирдлага, багш, ажилтнуудад чанарын дотоод баталгаажуулалтын чиглэлээр сургалт зохион байгуулах 4. МБСБ-ын чанарын дотоод баталгаажуулалтын чанарын стандарт, холбогдох аргачлал, дижитал хэрэгслийг боловсруулах, түгээн дэлгэрүүлэх 5. МБСБ-ын хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тайлагналтыг МБС-ын мэдээллийн нэгдсэн системтэй уялдуулах
---	--

4.2.4 Дээд боловсрол

Зорилго: Шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, олон улсын түвшинд нийцсэн, чанартай, тэгш боломжийг олгосон мэдлэг, технологийг тасралтгүй үйлдвэрлэх, хүний нөөцийг бэлтгэх, уян хатан сургалттай, ахисан түвшний судалгаа бүхий дээд боловсролыг хөгжүүлнэ.

Нийгмийн бүх талын оролцоог хангасан, үндэсний болон байгууллагын түвшний бие даасан засаглалыг бэхжүүлнэ. Дээд боловсролын сургалтын байгууллагыг сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд үндэслэн “нийтийн” гэсэн ангиллыг хуульд оруулснаар улс төрөөс хараат бус, хамтын засаглал бүрдэх бөгөөд эрдмийн хамт олны академик эрх чөлөө хамгаалагдах, сургалтын байгууллагын бие

даан шийдвэр гаргах, хариуцлага хүлээх эрх зүйн хувьд баталгаажна.

Дээд боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED) ба Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, ирээдүйн эрэлт хэрэгцээтэй уялдуулан мэргэжлийн чиглэл буюу хөтөлбөрийн нэрийг оновчтой, уян хатан тогтоох, үндэсний онцлогтой хөтөлбөрүүдийг судлан, үндэсний мэргэшлийн хүрээ (national qualification framework)-г боловсруулан баталснаар сургалтын хөтөлбөрийн хөгжил бүрэн хангагдаж, шинэ ажлын байранд ажиллах боломжтой шинэ мэргэшлийн хөтөлбөрийн дагуу хөрвөх болон насан турш суралцах ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд анхаарна.

ДБ-ын сургалтын байгууллагын судалгааны чадавхыг хөгжүүлэхдээ сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн түншлэлийг идэвхжүүлэх тэтгэлэгт төслүүдийг нэмэгдүүлэн, төсөлд суурилсан, бодит асуудалд чиглэсэн суралцахуйг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн ирээдүйн хэтийн төлөв, өгөгдөлд дүн шинжилгээ хийх ур чадваруудыг нэмэгдүүлэхэд анхаарснаар баялаг бүтээгчдийн үйл ажиллагааг дэмждэг суралцахуйг сургалтад нэвтрүүлнэ.

Их, дээд сургуулиудын хувьд эрдэм шинжилгээний ажилд магистрант, докторант оюутныг оролцуулан, тэдний мэдлэг чадварыг гүнзгийрүүлж, сургалт-эрдэм шинжилгээний ажлын уялдаа холбоог бататгахын дээр ахисан түвшний оюутнуудад сурсан мэдсэнээ амьдрал дээр хэрэглэх боломжоор хангадаг болно.

Гадаадын эрдэмтдийг татах нөхцөлийг бүрдүүлэх, зөвхөн тухайн хүний авьяас чадвар, туршлага, мэдлэгийг үндэслэн ажилд авах, албан тушаалд дэвшүүлэх, шагнал урамшил олгох, профессор багш нар болон оюутан сурагчдад авлига, аливаа дарамт шахалт үзүүлэхээс ангид байж, шударга өрсөлдөөн, оюун ухааны уралдааныг хөхиүлэн дэмждэг орчин, соёлыг бий болгох үүргээ биелүүлж байгаа үзүүлэлтүүдийг нь дүгнэдэг дотоодын чансаа тогтоодог системийг бүрдүүлнэ.

1. Зорилтууд

Зорилт 5.1 (Чанар): Суралцагчийн хэрэгцээ, шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, олон улсын түвшинд нийцүүлэн чанарыг сайжруулах

Хүрэх үр дүн: Дээд боловсролын төгсөгчдийн мэргэшил олон улсын стандарт, Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн шаардлага хангасан байна. Хөдөө орон нутгийн дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарыг эрдэмжүүлж, докторын зэрэгтэй багшийн эзлэх хувийг 50-д хүргэсэн байна.

ДБ-ын сургалтын байгууллагын судалгаа, хөгжүүлэлт (Research & Development/ R&D),

судалгаанд суурилсан уламжлал байхгүйгээс их, дээд сургуульд багшлах, зааж сургах чиг үүрэг нь хадгалагдаж, судалгаа, шинжилгээ орхигдож байна¹⁴⁴. Үүнтэй холбогдуулан АХБ-ны санхүүжилтээр судалгааны их сургуулийг хөгжүүлэх техникийн туслалцааны төсөл¹⁴⁵ хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус төслөөс боловсруулсан концепц, бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Судалгааны их сургуулийн хөгжлийн үзэл баримтлалыг шинээр баталж, үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай болно.

Их сургуульд суурилсан судалгаа, инновацийн тогтолцоог талуудтай хамтран хөгжүүлэх нь зөвхөн дээд боловсролын хөгжилд төдийгүй улс, эх орны хөгжлийн тулгуур болно. Их сургуулийн шинжлэх ухаан, үндэсний хүрээний судалгааны чиглэлийг зохистой тогтоох, инновацийн судалгаанд эцсийн хэрэглэгчийн захиалга, хөрөнгийн хариуцлага, эрсдэлийн санхүүжилтийн харилцан хяналт, оролцоог тодорхойлон журамлана. Судалгааны эх үүсвэрийн төрлийг олшруулах, эндаументийн төрөл хэлбэрийг (endowment fund, endowed professorship/ chair гм) дэмжсэн эрх зүйн зохицуулалт, менежментийг бүрдүүлсэн байна.

Боловсролд хөрөнгө оруулалт хийж буй байгууллагыг санхүүгийн болон бусад дэмжлэг (татварын хөнгөлөлт, нийгмийн хариуцлагын урамшуулал гэх мэт) үзүүлдэг тогтолцоог бэхжүүлнэ. Нийгмийн болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн суралцахуйн үр дүнд хүргэх зорилгоор сургалтын орчныг сайжруулах, төр, үйлдвэрлэл, бизнесийн байгууллага, мэргэжлийн олон нийтийн төлөөлөл, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, сургалтын байгууллагуудад судалгаа хөгжүүлэлтийн нээлттэй лабораториудыг байгуулна.

Дээд боловсролын “дадлага сургалт”-ын шинэ загварыг хэрэгжүүлэх шаардлагатай. Сургалтын байгууллага-үйлдвэрлэлийн салбарын түншлэл, хамтын ажиллагааг сайжруулах хөтөлбөрийг “ажлын байранд

¹⁴⁴ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

¹⁴⁵ <https://www.adb.org/projects/documents/mon-52013-001-tar>

дадлагажих сургалт"-ын хэлбэрээр хэрэгжүүлснээр оюутныг төгсөөд ажлын байрандаа шууд дасан зохицох, практик ур чадваруудаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. ДБСБ-н болон салбар дундын, нээлттэй лабораторийг үйлдвэрийн газарт байгуулахдаа хамтын үр ашигтай ажиллагааг бэхжүүлэх байдлаар татан оролцуулна.¹⁴⁶

Үндэсний шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт болон Үндэсний мэргэшлийн хүрээтэй нийцсэн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг эрчимжүүлэх шаардлагатай. Шинэ ажлын байранд ажиллах боломжтой мэргэжлийн нэрийг заасан, шинээр тодорхойлолтыг дипломын нэмэлт хавсралтаар өгдөг Европын жишээг (ISC) ашиглан хөтөлбөрийн болон төгсөгчийн чанар, нийцийг сайжруулах нь сургалтын нийцтэй байдалд эерэг үр дүн авчирна.

Мэргэжлийн стандартыг боловсруулж, хөтөлбөр, сургалтад мөрдөх шаардлагатай. Дээд боловсролын салбарт гарч буй шинэ эрэлт хэрэгцээг нийгмийн бүхий л салбар дахь өөрчлөлтүүдтэй уялдуулан дээд боловсролын тухай хууль, эрх зүйн баримт бичиг, дүрэм журмуудад холбогдох заалтуудыг тусгаж, эрх зүйн орчны шинэчлэлийг тогтолцооны шинэчлэлтэй уялдуулан хийнэ. Ажил олгогчийн эрэлт хэрэгцээ, тэднээс авсан судалгаанд тулгуурлан суралцахуйн үр дүн, сургалтын арга зүй, орчноо сайжруулдаг, үнэлгээний аргачлалыг өөрчлөн, үр дүнгээ тасралтгүй хянаж чанарын баталгаажуулалтыг хийдэг цогц үзэл баримтлал, тогтолцоог үр дүнд суурилсан боловсролын бодлогын дагуу хэрэгжүүлнэ.

Их, дээд сургуулийн элсэлтийг бүрэн дунд боловсролын төгсөлтийн үнэлгээтэй уялдуулах шаардлагатай. Элсэгчийн чанарыг сайжруулах, ахлах ангийн суралцагчдын сонгон судалсан хөтөлбөртэй нийцүүлэх, кредит дүйцүүлэх шаардлагатай. ПТК, коллежоос мэргэжлийн чиглэлийн дагуу

бакалаврын сургалтад элсэн суралцахыг нь дэмжсэн тогтолцоо бүрдүүлж, кредит дүйцүүлнэ.

ДБ-ын сургалтын байгууллагын чансаа тогтоож, их, дээд сургуулиудыг эрэмбэлнэ. Сургалтын байгууллагын чансааг тэнхим, профессорын үйл ажиллагаанд үндэслэн тодорхойлдог болно. Шилдэг сургууль, багш нарт дэмжлэг үзүүлэх дээд боловсролын өрсөлдөөнт тогтолцоо бий болсноор оюутнууд чанартай сургалтаас сонгон суралцах боломжтой болох бөгөөд сургалтын байгууллагын хувьд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу сургалт судалгаагаараа эрэмбэлэгдэх суурь бэлтгэлээ хангах болно.

Сургалтын байгууллагын профессор багшийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. Профессор багшийн хөгжлийн бодлогыг шинэчлэн, багшлахуйн чадавхыг тасралтгүй хөгжүүлснээр¹⁴⁷ профессор багшид тавигдах шалгуур шаардлагыг дээшлүүлж, өндөр ёс зүйтэй, хариуцлагатай, манлайлагч, мэргэшсэн, бүтээлч санаачилгатай хүмүүсээс сонгож ажиллуулах боломжтой болно.

Шинэ багшийг бэлтгэх, хөгжүүлэх, нийт багш нарын мэргэжлийн болон сургалтын арга зүйг дээшлүүлэх бодлого хэрэгжүүлж, урт богино хугацаагаар гадаад дотоодын сургалтад хамрагдах, судалгааны ур чадвараа нэмэгдүүлэх, харилцан туршлага судлах, ажлын байрандаа хөгжих нөхцөлийг сайжруулна. Багшийн ажлын гүйцэтгэлийг сургалт-судалгаа-инновац-нийгмийн үйлчилгээ - мэргэжлийн ур чадвар гэсэн цогц үр дүнгээр нь үнэлж, кредит системийн үнэлгээ шинэчлэгдэн мерит зарчим хэрэгжинэ.

Хөдөө орон нутгийн ДБ-ын сургалтын байгууллагын багшлах хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ. Бүсчилсэн хөгжлийн бодлого¹⁴⁸ хэрэгжсэнээр үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэхэд орон нутгийн дээд боловсролын оролцоо нэмэгдэнэ. Бүс нутгийн хөгжлийн бодлогод тухайн бүсийн

¹⁴⁶ Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, 2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн, Зорилт 5.

¹⁴⁷ "Үр дүнд суурилсан боловсрол" үндэсний хөтөлбөр 2019, ДБ-ын салбарын багш нарын мэргэжлийн болон заах зүйн чадамжийг дээшлүүлэх зорилт.

¹⁴⁸ Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, 2001.

их, дээд сургуулийн оролцоо, манлайлал, үүрэг хариуцлагыг баталгаажуулан, насан туршийн нээлттэй боловсролыг дэмжсэн төвүүдээр дамжуулан цахим, онлайн, зайн сургалтын хэлбэрээр бүх нийтэд хэрэгжүүлнэ.

Багшийн хөгжлийг тасралтгүй хангах нээлттэй, цахим онлайн, зайн сургалтыг нэвтрүүлэх, үр дүнг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах шаардлагатай. ДБСБ-ын багш - профессор багшийн хөгжлийн бодлогыг шинэчлэн, багшлахуйн чадавхыг тасралтгүй хөгжүүлэх бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх¹⁴⁹ нь багшаар дамжуулан сургалтын чанарыг сайжруулах боломж олгоно.

Зорилт 5.2 (Хүртээмж): Нээлттэй, уян хатан боловсролыг хөгжүүлэх замаар тэгш боломжийг нэмэгдүүлэх

Хүрэх үр дүн: Нээлттэй, цахим, онлайн, зайн сургалтын хэлбэрүүдийг өргөжүүлсэн байна. Хөдөө орон нутгийн авьяаслаг суралцагчдыг төрөөс дэмжсэн байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бүтцийг сайжруулах шаардлагатай. Оюутан төвтэй сургалтын үйл ажиллагааг дэмжсэн сургалтын орчинд тавих шаардлага боловсруулж, стандартад нийцсэн дэд бүтцийг бий болгоно.

Их сургуулиудыг бүсчилж хотхоноор хөгжүүлэх бодлого, төслийг дэмжиж хэрэгжүүлнэ. Одоогоор Монгол-Германы Ашигт малтмалын технологийн их сургуулийн хотхон, АШУУИС-ийн Эмнэлэг, сургалтын цогцолбор байгуулагдаад байна.

Нээлттэй, хамтарсан дадлагын лаборатори, бүрэлдэхүүн эмнэлэг, судалгааны орчныг бизнесийн байгууллагатай хамтран байгуулах бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.

Суралцахуйн орчин, технологийн нөхцөлийг сайжруулах шаардлагатай. Сургалтын байгууллагын байршлаас үл хамааран чанартай дээд боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

Оюутанд чиглэсэн, тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн, суралцах, ажил хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэх шаардлагатай. Их, дээд сургуулийн тусгай хэрэгцээт суралцагчийн сурах орчин, хэрэглэгдэхүүн, сургалтын арга зүй тэдний онцлог хэрэгцээнд нийцэхгүй байна. Үүнээс шалтгаалан тэд сургуулиа орхиход хүрч байна.

Оюутны үйлчилгээг эрүүл мэндийн тусламж, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх, хөдөлмөрийн туршлагыг сайн дурын ажлын үндсэн дээр хуримтлуулах үйл ажиллагаагаар өргөжүүлнэ. Тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг (ахисан түвшний судлаач оюутан, тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн оюутан, тусгай хэрэгцээт, эмзэг бүлгийн суралцагч) үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлнэ..

Насан туршдаа суралцахуйг дэмжих санаачилга, манлайллыг их, дээд сургуулиуд үзүүлэх шаардлагатай. Дээд боловсрол эзэмших сургалтын уян хатан хэлбэрийг дэмжин, сургалтын нээлттэй эх үүсвэр, онлайн сургалтын хүрээг өргөтгөн суралцагч, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэхэд шаардагдах ур чадвар, хөрвөх чадвар, насан туршдаа суралцах боломж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэх шийдэл юм¹⁵⁰.

Их, дээд сургуульд түшиглэсэн нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлэх, их, дээд сургуулийн нээлттэй боловсролын төвийн орчныг сайжруулснаар насанд хүрэгчдийн ажил хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх, амьдрах чадварыг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадвараа ахиулахад дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 5.3 (Менежмент): Дээд боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох

Хүрэх дүн: Төрийн өмчийн их сургуулиуд бие даасан засаглалтай болж, сургалтын байгууллагуудыг эрэмбэлж, чансаа тогтоосон байна. Их сургуулийг бүсчлэн хөгжүүлж, судалгааны их сургууль байгуулж төрөөс дэмжсэн байна.

¹⁴⁹ “Үр дүнд суурилсан боловсрол”-ыг хөгжүүлэх бодлого, 2018, Зорилт 3: Дээд боловсролын салбарын профессор, багш нарын мэргэжлийн болон заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх;

¹⁵⁰ ЮНЕСКО, БХ. (2019). Боловсролын суурь мэдээллийн тайлан

ДБ-ын удирдлага, зохион байгуулалттай холбоотой асуудал нь чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо сургалтын байгууллагуудад харилцан адилгүй байгаа явдал¹⁵¹. Дээд боловсролын чанарын удирдлагын тогтолцоог салбарын хөгжилд мэдэгдэхүйц үр нөлөөтэй байхаар хөгжүүлэхийн тулд хөтөлбөр, сургууль, салбарын түвшинд гүйцэтгэлийн болон чанарын шалгуур үзүүлэлтэд суурилсан удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх шаардлагатай юм¹⁵².

Ахисан түвшний судалгааны ажлууд, түүний оюуны өмчийг шийдвэрлэхэд үндэсний хэмжээний хуулбарлалт, оюуны өмчийн нэгдсэн санг бий болгох хэрэгтэй. Түүнийг судалгааны их сургуулийн санхүүжилтийн эх үүсвэрийн нэг хэлбэр болгон хэрэгжүүлж Оюуны өмчийн тухай хуультай нийцүүлсэн бодлого, программ хангамжийг боловсруулах болно.

ДБСБ-ын үндэсний болон олон улсад эзлэх байр суурийг дээшлүүлэх зорилгоор бенчмарк, эрэмбэ, чансаа тогтоох зэргээр өрсөлдөх чадварыг дэмжинэ¹⁵³.

2. Зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа

Хөтөлбөрүүд	Үйл ажиллагаа
Зорилго 5.1 Суралцагчийн хэрэгцээ, шинжлэх ухаан, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, олон улсын түвшинд нийцүүлэн чанарыг сайжруулах	
Хөтөлбөр 5.1.1 : Дээд боловсролын хөтөлбөр, судалгааны чанар, нийцийг сайжруулах	<ol style="list-style-type: none"> Их, дээд сургуулийн хөтөлбөрийг дэлхийд өрсөлдөх монгол хүнийг хөгжүүлэх чиглэлээр шинэчлэх, бүс нутгийн хөгжлийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан сайжруулах Ахисан түвшний сургалт, судалгааг олон улсын жишигт хүргэх Их сургуулийн судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг дэмжих тогтолцоог бий болгох Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх механизмыг боловсронгуй болгож, үр дүнг шинээр төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагааны гол шалгуур болгох замаар төслийн санхүүжилтийн уян хатан, өрсөлдөөнт тогтолцоог бий болгох Судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент венч сан) эх үүсвэрийг бий болгох¹⁵⁴ Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд чиглэсэн аж үйлдвэртэй түншлэгч судалгааны их сургууль байгуулах бодлогыг боловсруулах, батлуулах Кредит /багц цаг/ цагийн тогтолцоо бүхий их сургуулийн үйлдвэрлэлийн дадлагын өнөөгийн тогтолцоог нэгдмэл болгон, турших, хэрэгжүүлэх Үндэсний мэргэшлийн хүрээ ба зах зээлийн шаардлагатай уялдуулан их сургуулиудын хөтөлбөрийг сайжруулах Багш мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн элсэлтийн шаардлагыг шинэчлэх Хөгжлийн бэрхшээлтэй сурагчидтай ажиллах тусгайлсан арга зүйг эзэмшүүлэх чиглэлээр багшийн мэргэжлийн стандарттай уялдуулан багш бэлтгэх их, дээд сургуулийн хөтөлбөрийг сайжруулах Дээд боловсролын элсэлтийн тогтолцоог ахлах сургуулийн заавал эзэмших ба сонгон суралцах хичээлүүдтэй уялдуулах Хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа, мэдээлэлд үндэслэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог сайжруулж, их, дээд сургуулийн ангиллын шалгуур үзүүлэлтийг чанаржуулж, мөрдүүлэх

¹⁵¹ АХБ, БШУЯ. (2019). Дээд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

¹⁵² АХБ, БШУЯ. (2019). Дээд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

¹⁵³ АХБ, БШУЯ. (2019). Дээд боловсролын дэд салбарын шинжилгээний тайлан

¹⁵⁴ ADB TA: 52013-001 Project

Хөтөлбөр 5.1.2 : Их сургуулийн профессорын хөтөлбөр хэрэгжүүлэх	<ol style="list-style-type: none"> 1. Их, дээд сургуулийн багшид тавигдах шаардлага, стандартыг боловсруулж баталгаажуулах 2. Орон нутгийн ИДС-ийн багш нарын чадавхыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах 3. Дээд боловсролын багш нарт зориулсан нээлттэй, уян хатан бөгөөд зайн сургалтын хэлбэрийг нэвтрүүлж, тэдний тасралтгүй боловсролыг дэмжих, чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах
--	--

Зорилт 5.2 (Хүртээмж) : 5.2 Нээлттэй, уян хатан боловсролыг хөгжүүлэх замаар тэгш боломжийг нэмэгдүүлэх

Хөтөлбөр 5.2.1 : Дээд боловсролын сургалтын орчин, дэд бүтцийг сайжруулах	<ol style="list-style-type: none"> 1. Ногоон үнэлгээ, ухаалаг технологитой уялдуулан дээд боловсролын сургалтын орчны стандартыг сайжруулан баталгаажуулах 2. Бүсийн төв, орон нутагт их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хийх (Дорнод, Ховд, Дархан, Багануур)¹⁵⁵ 3. Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулан сургуулийн бүх үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх сургалтын орчныг бий болгох 4. Багш бэлтгэх их, дээд сургуулийн багшлах дадлагын хугацаанд зохицуулалт хийж хөдөлмөр эрхлэлтийн урамшууллыг бий болгох 5. Оюутныг дэмжсэн үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх 6. Засгийн газрын тэтгэлгээр дотоод, гадаадад дээд боловсрол эзэмшигчдийг мэргэжлээр нь хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан томилон ажиллах зохицуулалт хийх
Хөтөлбөр 5.2.2: Нээлттэй боловсролын төв байгуулах	<ol style="list-style-type: none"> 1. Хот, хөдөөд их сургууль түшиглэсэн нээлттэй боловсролын төвүүдийг байгуулах 2. Төвүүдээр дамжуулан (Massive Online Open Courses-MOOC) хэлбэрүүдийг ашиглан, аж үйлдвэрийн удирдлага, экспертүүд, багш, энтерпренерүүдэд зориулсан нээлттэй, зайн сургалтыг явуулах 3. Нээлттэй боловсролын төвийг түшиглэн өмнө эзэмшсэн ур чадварыг (ӨУЧ) хүлээн зөвшөөрөх, баталгаажуулан магадлах тогтолцоог бий болгох 4. Их сургууль, ахлах сургууль, мэргэжлийн боловсролын сургууль хооронд кредит шилжүүлэхийг хүлээн зөвшөөрөх тогтолцоо бий болгох

Зорилт 5.3 Дээд боловсролын засаглал, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох

Хөтөлбөр 5.3.1 Дээд боловсролын байгууллагын засаглалын бие даасан, хараат бус байдлыг дэмжих	<ol style="list-style-type: none"> 1. Их, дээд сургуулийн засаглал, удирдлагын тогтолцооны хараат бус, бие даасан байдлыг хангах
	5. Шаардлагатай тоног төхөөрөмж, барилга байгууламж, тавилга, эд хогшил, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
4.2.3	1. Иргэдэд МБС-д хамрагдах, өөрийгөө бие даан хөгжүүлэх боломжийг олгох, нээлттэй, онлайн, зайн сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, чанарыг баталгаажуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв
	2. Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах тогтолцоог бий болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв
	3. Өмнөх мэдлэг, ур чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв
	4. Иргэдэд ажил хөдөлмөр эрхлэх ур чадварыг эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвараа ахиулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, үр дүн баталгаажуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, МБСБ, Чадамжийн төв
4.3.1	1. Салбар дундын зохицуулалттай төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан бие даасан удирдлагын тогтолцоог бүрдүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	МУЗГ, ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
	2. МБСБ-ыг төрөлжүүлэх, хотхон хэлбэрээр хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	МУЗГ, ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
	3. Салбарын санхүүжилтийн механизмыг шинэчлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	МУЗГ, ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
	4. МБС-ын удирдлага мэдээллийн системийг хөгжүүлэх, боловсронгуй болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв

Хөтөлбөрийн үйл ажиллагаа		2021	2022	2023	2024	2025	Хариуцах эзэн
4.3.2	5. БУМС-Мэргэжлийн боловсрол сургалтын мэдээллийн нэгдсэн систем-Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг уялдуулж, ашиглалтыг сайжруулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв
	6. ХЗЗ-ийн мэдээллийн ашиглалтыг сайжруулж, мэдээллийн систем, статистик мэдээллийг ашиглах чиглэлээр оролцогч талуудад сургалт зохион байгуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв
4.3.2	1. МБС-ын салбарын чанарын удирдлага, ЧСС-ын үнэлгээ, гэрчилгээжүүлэлтийн тогтолцоог сайжруулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв
	2. Сургалтын байгууллагын дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтыг хөгжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		ХНХЯ-ны МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв, МБСБ, Чадамжийн төв
	3. МБСБ-ын удирдлага, багш, ажилтнуудад чанарын дотоод баталгаажуулалтын чиглэлээр сургалт зохион байгуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв, Чадамжийн төв
	4. МБСБ-ын чанарын дотоод баталгаажуулалтын чанарын стандарт, холбогдох аргачлал, дижитал хэрэгслийг боловсруулах, түгээн дэлгэрүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв, Чадамжийн төв
	5. МБСБ-ын хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тайлагналтыг МБС-ын мэдээллийн нэгдсэн системтэй уялдуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	МБС-ын Үнэлгээ, арга зүй, мэдээллийн төв
5. ДЭЭД БОЛОВСРОЛ							
5.1.1	1. Их, дээд сургуулийн хөтөлбөрийг дэлхийд өрсөлдөх монгол хүнийг хөгжүүлэх чиглэлээр шинэчлэх, бүс нутгийн хөгжлийн эдийн засгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан сайжруулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ
	2. Ахисан түвшний сургалт, судалгааг олон улсын жишигт хүргэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ
	3. Их сургуулийн судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг дэмжих тогтолцоог бий болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ
	4. Шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ
	5. Судалгааны ажлын явц, үр дүнг хянах, хүлээж авах, үнэлэх механизмыг боловсронгуй болгож, үр дүнг шинээр төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх үйл ажиллагааны гол шалгуур болгох замаар төслийн санхүүжилтийн уян хатан, өрсөлдөөнт тогтолцоог бий болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ

Хөтөлбөрийн код	Үйл ажиллагаа	2021	2022	2023	2024	2025	Хариуцах эзэн
6.	Судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент, вент сан) эх үүсвэрийг бий болгох ¹⁶⁴	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>				БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ
7.	Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд чиглэсэн аж үйлдвэртэй түншлэгч судалгааны их сургууль байгуулах бодлогыг боловсруулах, батлуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>				БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ
8.	Кредит /багц цаг/ цагийн тогтолцоо бүхий их сургуулийн үйлдвэрлэлийн дадлагын өнөөгийн тогтолцоог нэгдмэл болгон, турших, хэрэгжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>				БШУЯ-ны БТГ, ДБГ, СЭЗГ
9.	Үндэсний мэргэшлийн хүрээ ба зах зээлийн шаардлагатай уялдуулан их сургуулиудын хөтөлбөрийг сайжруулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>				БШУЯ-ны БТГ, ДБГ, ШУТГ, Их дээд сургуулиуд, ААНБ-ууд
10.	Багш мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн элсэлтийн шаардлагыг өөрчлөх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		Их дээд сургуулиуд
11.	Хөгжлийн бэрхшээлтэй сурагчидтай ажиллах тусгайлан арга зүйг эзэмшүүлэх чиглэлээр багшийн мэргэжлийн стандарттай уялдуулан багш бэлтгэх их, дээд сургуулийн хөтөлбөрийг сайжруулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		БШУЯ-ны Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс, СӨБ-ын багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд
12.	Дээд боловсролын элсэлтийн тогтолцоог ахлах сургуулийн заавал эзэмших ба сонгон суралцах хичээлүүдтэй уялдуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>		БШУЯ-ны БТГ, ДБГ
13.	Хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа, мэдээлэлд үндэслэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх тогтолцоог сайжруулж, их, дээд сургуулийн ангиллын шалгуур үзүүлэлтийг чанаржуулж, мөрдүүлэх	<input checked="" type="checkbox"/>					БШУЯ-ны ДБГ, ИДСК
5.1.2	1. Их, дээд сургуулийн багшид тавигдах шаардлага, стандартыг боловсруулж баталгаажуулах	<input checked="" type="checkbox"/>					БШУЯ-ны ДБГ, СХЗГ, ИДСК,
	2. Орон нутгийн ИДС-ийн багш нарын чадавхыг дээшлүүлэх сурталт зохион байгуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, Их дээд сургуулиуд
	3. Дээд боловсролын багш нарт зориулсан нээлттэй, уян хатан бөгөөд зайн сургалтын хэлбэрийг нэвтрүүлж, тэдний тасралтгүй боловсролыг дэмжих, чадварыг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, БМИУЗ-ийн Ажлын алба, Их дээд сургуулиуд,
5.2.1	1. Ногоон үнэлгээ, ухаалаг технологитой уялдуулан дээд боловсролын сургалтын орчны стандартыг сайжруулан баталгаажуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>			БШУЯ-ны ДБГ, СХЗГ, ИДСК
	2. Бүсийн төв, орон нутагт их сургуулийн хотхоны бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хийх (Дорнод, Ховд, Дархан, Багануур) ¹⁶⁵	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	

¹⁶⁴ ADB TA: 52013-001 Project

¹⁶⁵ The project has designed and estimated all related costs.

Хөтөлбөрийн үйл ажиллагаа		2021	2022	2023	2024	2025	Хариуцах эзэн
Код							
3.	Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулан сургуулийн бүх үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх сургалтын орчныг бий болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, Кампус төсөл
4.	Багш бэлтгэх их дээд сургуулийн багшлах дадлагын хугацаанд зохицуулалт хийж хөдөлмөр эрхлэлтийн урамшууллыг бий болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Их дээд сургуулиуд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо
5.	Оюутныг дэмжсэн үндэсний тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Их дээд сургуулиуд, Оюутны холбоод, ААНБ-ууд
6.	Засгийн газрын тэтгэлгээр дотоод, гадаадад дээд боловсрол эзэмшигчдийг мэргэжлээр нь хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан томилон ажиллах зохицуулалт хийх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ТХАГ, ДБГ
5.2.2	1. Хот, хөдөөд их сургууль түшиглэсэн нээлттэй боловсролын төвүүдийг байгуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны БТГ, ДБГ, ХОУГ, НТБТ, Их дээд сургуулиуд
	2. Төвүүдээр дамжуулан (Massive Online Open Courses- MOOC) хэлбэрүүдийг ашиглан, аж үйлдвэрийн удирдлага, экспертүүд, багш, энтерпренерүүдэд зориулсан нээлттэй, зайн сургалтыг явуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Их дээд сургуулиуд, ААНБ-ууд
3.	Нээлттэй боловсролын төвийг түшиглэн өмнө эзэмшсэн ур чадварыг (ӨУЧ) хүлээн зөвшөөрөх, баталгаажуулан магадлах тогтолцоог бий болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, БМИУЗ-ийн Ажлын алба, Их дээд сургуулиуд
4.	Их сургууль, ахлах сургууль, мэргэжлийн боловсролын сургууль хооронд кредит шилжүүлэхийг хүлээн зөвшөөрөх тогтолцоо бий болгох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, Их дээд сургуулиуд
5.3.1	1. Их, дээд сургуулийн засаглал, удирдлагын тогтолцооны хараат бус, бие даасан байдлыг хангах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны БТГ, ДБГ
5.3.2	1. Судалгаа шинжилгээний ажлын санхүүжилтийг ДБ-ын удирдлага, мэдээллийн системийг бэхжүүлэн, судалгаа, инновац, төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөгчийг мөшгөх судалгаа зэрэг модулийг хөгжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, Мэдээллийн технологи статистикийн хэлтэс
	2. Удирдлага, мэдээллийн системийн платформ, сервер, ба программыг боловсруулан, өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэс
5.3.3	1. Үр дүнд суурилсан чанарын стандарт, шаардлагуудыг боловсруулж, баталгаажуулах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, БМИУЗ-ийн Ажлын алба
	2. Их сургуулийн удирдлага, менежер, холбогдох албан тушаалтнууд болоод аж үйлдвэрийн төлөөллийн чадавгыг бэхжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	БШУЯ-ны ДБГ, БМИУЗ-ийн Ажлын алба



ЗУРГАА. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ЗАРДЛЫН ХҮРЭЭ

- Боловсролын хэрэгцээний тооцоо
- Шаардагдах санхүүжилтийн тооцоо
- Улсын төсөв ба боловсролын зардал, дутагдах нөөцийн тооцоо
- Санхүүжилтийн стратеги

ЗУРГАА. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ЗАРДЛЫН ХҮРЭЭ

Боловсролын салбарын санхүүжилт нь Үндсэн хууль, Боловсролын тухай багц хуулийн холбогдох заалт, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид үндэслэсэн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт суурилсан төсвийн харилцаагаар зохицуулагдаж байна.

Боловсролын тухай хуулийн¹⁶⁶ төсөв, санхүүгийн холбогдох заалтад үндэслэн боловсролын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлж байна. Энэхүү тогтмол болон нормативт зардал нь хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал гэсэн үндсэн төрлүүдэд, эдийн засгийн ангилал нь хувьсах зардал, тогтмол зардал, сургалтын төлбөрийн зээл, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, хөрөнгө оруулалтын зардал гэсэн үндсэн бүлгүүдэд хуваагддаг.

Төсвийн тухай хууль 2013 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд орон нутгийн боловсролын байгууллагын төсөв нь салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн төсвийн нэг хэсэг болж орон нутгийн өөрөө удирдах байгууллагаар батлагдаж байна. Ингэхдээ Төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгуулан хэрэгжүүлдэг.

Дээд боловсролын хувьд “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль”-ийг тус тус үндэслэн санхүүжилт, хөрөнгө оруулалт хийгддэг. Үндсэн санхүүжилт нь “Оюутны зээл, буцалтгүй

тусламж, багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөрийн зээл, дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл” болно.

Өнөөгийн шатанд салбарын хөрөнгө оруулалтын гол бодлого нь сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжийг арилгахад чиглэж барилга, их засвар, тоног төхөөрөмжийн төсвийг батлан хэрэгжүүлж байна.

Засгийн газраас 2016 онд “хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” 242 дугаар¹⁶⁷ тогтоолыг батлан төрийн болон төрийн бус өмчийн хүүхдийн цэцэрлэг, ЕБС, МСҮТ-ийн нормативт зардлыг олгож байна.

Тус тогтоолоор нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжих аргачлал, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн, төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг тусад нь баталж өгснөөрөө хувьсах зардлын санхүүжилтийг улам нарийвчлан хуваарилах боломжийг олгосноороо онцлогтой байна.

Хувьсах зардлын бүрэлдэхүүнд дараах эдийн засгийн ангилалд хамаарах зардал багтсан байна.

Тус тогтоолоор хувьсах зардлын санхүүжилтийг нарийвчлан хуваарилах боломжийг олгосон.

¹⁶⁶ Боловсролын тухай хуулийн 40, 41 дүгээр заалт

¹⁶⁷ <https://www.legalinfo.mn/law/details/11937?lawid=11937>

Хүснэгт 6.1 Хувьсах зардлын бүрэлдэхүүн

№	ҮЗҮҮЛЭЛТ	
1	Багшийн албан тушаалын цалин болон нэмэгдэл цалин, хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны багш, ажилтны албан тушаалын цалин болон зарим нэмэгдэл /Зарим нэмэгдэл гэдэгт: цалин, хөдөө орон нутагт ажилласан, ур чадварын, анги кабинет болон заах аргын нэгдэл хариуцсан нэмэгдлийг ойлгоно/	
2	Багшийн үндсэн болон нэмэгдэл цалинд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл	
3	Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал	
		1. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх
		2. Бичиг хэрэг
		3. Ном хэвлэл
		4. Шуудан холбоо, интернэтийн төлбөр
		5. Дотоод албан томилолт
		6. Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс
		7. Нормын хувцас, зөөлөн эдлэл
		8. Эм, бэлдмэл
		9. Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал
		10. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
11. Бараа үйлчилгээний бусад зардал		

Эх үүсвэр: БШУЯ

2019 оны төсвийн жилийн байдлаар хувьсах болон бусад зардлыг санхүүжүүлж дараах нормативыг баримтлан орон нутгийн байна. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн

Хүснэгт 6.2 Хувьсах зардлын норматив, төг, 2019 он

Зардлын зүйл	Цэцэрлэг	ЕБС	Шийдвэр
Хувьсах зардал/нэг хүүхдэд жилд дунджаар мян.төг/			
Сум, аймгийн төв	905.3	437.9	Засгийн газрын 2016 оны 242 тоот тогтоол
Нийслэл	807.8	374.0	
Дотуур байр		387.5	
Хоол /өдөрт/	1.650		Засгийн газрын 2012 оны 106 тоот тогтоол
Дотуур байрны хүүхдийн хоол /өдөрт/		2.315	
Үдийн цай /өдөрт/ 1-5 анги		0.600	
Тусгай сургуулийн үдийн хоол /өдөрт/		2.400	Засгийн газрын 2017 оны 162 тоот тогтоол

Эх сурвалж: БШУЯ

6.1 БОЛОВСРОЛЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ТООЦОО

6.1.1 Сургуулийн өмнөх боловсрол

2021 оноос 2030 онд СӨБ-д хамрагдах насны хүн амын тоог ҮСХ-оос хийсэн Монгол Улсын харьяат хүн амын хувьд тооцсон хүн

амын тоо, хүйс, насны бүлэг, дунд хувилбар 2Б, 2015-2045 он тооцоонд суурилан Хүснэгт 6.3-д харуулж байна.

Хүснэгт 6.3 СӨБ-д хамрагдах хүн амын тоо, 2021-2030

Нас	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
2	82,580	82,409	82,088	81,639	80,193	79,679	79,303	79,111	82,893	79,769
3	82,471	82,466	82,299	81,984	80,650	80,121	79,608	79,233	83,126	79,554
4	81,754	82,385	82,382	82,220	81,055	80,599	80,070	79,556	83,439	79,591
5	80,966	81,692	82,325	82,324	81,375	81,022	80,565	80,035	83,787	79,849
Нийт	327,771	328,952	329,094	328,167	323,273	321,421	319,546	317,935	333,245	318,763

Эх сурвалж: ҮСХ

2018 оны жилийн эцэст 2-5 настай хүн амын тоо 318,422 байсантай харьцуулахад 2021 онд суурь он буюу 2018 оноос 3 орчим хувиар нэмэгдэж, 2022-2023 онд 0.4 хувиар өсөх хандлагатай байна. 2024 оноос (2029 оныг эс тооцвол, тус оны тоо алдаатай байж болзошгүй) дээрх бүлгийн хүн амын тоо буурч 2030 онд 2018 оны түвшинд очих

төлөвтэй байна.

СӨБ-д хамрагдалтын хувийг насны бүлгээс хамааруулан ялгаатай байхаар төлөвлөсөн. Тухайлбал 2 настай бүлэгт хамран сургалтын хувийг 70 хувьд хүргэж 5 настай хүүхдүүдийг 100 хувь хамруулна хэмээн үзэж жилийн өсөлтийн хурдыг тооцоолсон.

Хүснэгт 6.4. СӨБ-ын хамран сургалтын хувь

Нас	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
2	62.5	63.3%	64.0%	64.8%	65.5%	66.3%	67.0%	67.8%	68.5%	69.3%	70.0%
3	80.8	81.7%	82.6%	83.6%	84.5%	85.4%	86.3%	87.2%	88.2%	89.1%	90.5%
4	85.0	86.0%	87.0%	88.0%	89.0%	90.0%	91.0%	92.0%	93.0%	94.0%	97%
5	90.8	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
Дундаж	79.8%	82.7%	83.4%	84.1%	84.8%	85.4%	86.1%	86.8%	87.4%	88.1%	89.4%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх хамран сургалтын хувийг ашиглан тооцоход СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо дараах байдалтай гарсан.

Хүснэгт 6.5. СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо

Нас	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
2	57,766*	52,232	52,742	53,152	53,474	53,128	53,385	53,728	54,191	57,403	55,838
3	63,175	67,388	68,143	68,763	69,255	68,871	69,157	69,448	69,850	74,048	71,996
4	69,209	70,323	71,688	72,508	73,186	72,958	73,352	73,669	73,990	78,434	77,203
5	73,183**	80,966	81,692	82,325	82,324	81,375	81,022	80,565	80,035	83,787	79,849
Нийт	263,333	270,909	274,265	276,748	278,238	276,332	276,916	277,410	278,067	293,673	289,887
Жилийн өсөлт	-	2.9%	1.2%	0.9%	0.5%	-0.7%	0.2%	0.2%	0.2%	5.6%	-3.7%

*, **-харгалзан 2 хүртэлх, 5 настай хүүхдүүдийг нэмсэн тоо

СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо 2021-2023 онд хамгийн их 3 хүртэл хувийн өсөлттэй, бусад хугацаанд буурахаар байна.

2030 онд дээрх хүүхдүүдийн 80 хувь

нь төрийн өмчийн цэцэрлэгт, 20 хувь нь хувийн хэвшлийн цэцэрлэгт хамрагдахаар үзвэл хамрагдалтын хувь дараах байдлаар өөрчлөгдөх тооцоо гарсан.

Хүснэгт 6.6 СӨБ-д хамрагдах хүүхдийн эзлэх хувь, өмчийн хэлбэрээр

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн СӨБ	85.4%	84.9%	84.3%	83.8%	83.2%	82.7%	82.2%	81.6%	81.1%	80.5%	80.0%
Хувийн хэвшлийн СӨБ	14.6%	15.1%	15.7%	16.2%	16.8%	17.3%	17.8%	18.4%	18.9%	19.5%	20.0%

Эх сурвалж: EPSSim программ

Төрийн өмчийн СӨБ-д хамрагдах хүүхдүүдийн хувьд 90 хувь нь үндсэн, 10 хувь нь хувилбарт сургалтад хамрагдана

гэж тооцоход уг харьцаа суурь оноос дараах байдлаар өөрчлөгдөхөөр байна.

Хүснэгт 6.7 Төрийн өмчийн СӨБ-д хамрагдах хүүхдийн эзлэх хувь, үйлчилгээний төрлөөр

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Цэцэрлэгт хамрагдах хувь	90.8%	90.7%	90.6%	90.6%	90.5%	90.4%	90.3%	90.2%	90.2%	90.1%	90.0%
Хувилбарт үйлчилгээнд хамрагдах хувь	9.2%	9.3%	9.4%	9.4%	9.5%	9.6%	9.7%	9.8%	9.8%	9.9%	10.0%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх тооцооллууд дээр суурилан СӨБ-д хамрагдах хүүхдийн тоог өмчийн хэлбэр, үйлчилгээний төрлөөр дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6.8 СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн цэцэрлэгийн үндсэн сургалт	204,265	208,559	209,614	209,972	209,557	206,588	205,491	204,323	203,271	213,061	203,686
Төрийн өмчийн цэцэрлэгийн хувилбарт сургалтад хамрагдах хүүхэд	20,710	21,334	21,646	21,888	22,049	21,939	22,023	22,099	22,185	23,463	22,632
Хувийн хэвшлийн цэцэрлэгт хамрагдах хүүхэд	38,358	41,016	43,005	44,889	46,633	47,805	49,402	50,988	52,610	57,149	56,579
Төрийн өмчийн цэцэрлэгт хамрагдах хүүхэд	224,975	229,893	231,260	231,859	231,606	228,526	227,514	226,422	225,456	236,524	226,318
Нэмэгдэх хүүхэд (СӨБ)	-	4,918	1,367	599	(254)	(3,079)	(1,012)	(1,092)	(965)	11,068	(10,206)
Нэмэгдэх хүүхэд (төрийн өмчийн цэцэрлэг)	-	4,294	1,055	357	(415)	(2,969)	(1,097)	(1,168)	(1,052)	9,789	(9,375)
Нэмж барих цэцэрлэгийн тоо (75 хүүхдийн цэцэрлэг)	-	57	14	5	-	-	-	-	-	131	-

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Дээрх тооцооноос үзэхэд СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо 2023 онд хамгийн их болж цаашид буурах төлөвтэй байна. 2021-2023 онтой харьцуулахад харгалзан 75 хүүхдийн хүчин чадалтай 57, 14, 5 цэцэрлэг барихад СӨБ-ын байгууллагад хамрагдах хүүхдийг бүрэн хүлээн авах боломжтой гэсэн тооцоо гарсан. Уг тооцоонд өнөөгийн бүлэг дүүргэлт хэвээр хадгалагдана хэмээн үзсэн болно.

Хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан төрийн өмчийн СӨБ-д ажиллах хүний нөөцийн тооцоог хийхдээ бүлгийн болон туслах 1 багшид 30 хүүхэд ногдох ба бусад багшийн бүлгийн багш болон туслах багштай харьцах харьцааг өнөөгийн түвшинд, багш бус ажиллагчдын нийт багшид эзлэх хувийг 92.4 гэсэн суурь төвшнөөс 80 хувьд хүргэнэ гэж үзсэн.

Хүснэгт 6.9 Төрийн өмчийн СӨБ-ын байгууллагад ажиллагчдын тооцоо

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Нийт багш	6,560	8,764	8,816	8,839	8,829	8,711	8,673	8,631	8,594	9,016	8,627
Бүлгийн багш	5,745	7,663	7,709	7,729	7,720	7,618	7,584	7,547	7,515	7,884	7,544
Бусад багш	825	1,100	1,107	1,110	1,109	1,094	1,089	1,084	1,079	1,132	1,083
Туслах багш	5,623	6,952	6,987	6,999	6,985	6,886	6,850	6,811	6,776	7,102	6,790
Багш бус ажиллагчид	11,269	14,326	14,210	14,045	13,828	13,445	13,188	12,928	12,677	13,095	12,333
Нийт ажиллагчид	23,462	30,042	30,013	29,882	29,642	29,043	28,710	28,370	28,047	29,213	27,750

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хүүхдийн тооны өсөлттэй уялдан 2021-2023 онд багш нарын хэрэгцээ нэмэгдэх бол нийт ажиллагчдын тоо буурах хандлагатай байна.

6.1.2 БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

2021 оноос 2030 онд БДБ-д хамрагдах насны хүн амын тоог ҮСХ-оос хийсэн Монгол Улсын харьяат хүн амын хувьд тооцсон хүн амын тоо, хүйс, насны бүлэг, дунд хувилбар

2Б, 2015-2045 он тооцоонд суурилан Хүснэгт 6.10-т харуулсан.

Хүснэгт 6.10 БДБ-д хамрагдах хүн амын тоо, 2021-2030

Нас	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
6	81,345	80,906	81,633	82,267	81,553	81,342	80,989	80,530	84,109	80,275
7	76,389	81,292	80,854	81,583	81,584	81,527	81,314	80,959	84,312	80,815
8	72,105	76,343	81,245	80,810	81,283	81,562	81,503	81,288	84,084	81,288
9	68,542	72,065	76,302	81,203	80,572	81,264	81,540	81,480	83,738	81,686
10	65,495	68,506	72,029	76,265	79,449	80,554	81,244	81,519	84,940	81,957
11	62,711	65,460	68,472	71,994	77,971	79,432	80,535	81,224	82,368	82,077
12	59,970	62,679	65,428	68,439	73,517	77,954	79,413	80,514	79,779	82,036
13	57,067	59,939	62,647	65,394	69,649	73,501	77,936	79,393	77,518	81,363
14	53,869	57,033	59,905	62,613	66,376	69,630	73,480	77,911	75,166	80,592
15	50,456	53,833	56,996	59,867	63,481	66,354	69,605	73,451	71,101	80,975
16	47,128	50,418	53,793	56,956	60,726	63,454	66,324	69,573	67,505	76,036
17	44,380	47,089	50,376	53,750	57,905	60,694	63,420	66,288	64,194	71,757
Нийт	739,457	775,563	809,680	841,141	874,066	897,268	917,303	934,130	938,814	960,857

Эх сурвалж: ҮСХ

2018 оны жилийн эцэст 6-17 настай хүн ам 662,795 байсантай харьцуулахад 2021 онд суурь он буюу 2018 оноос 12 орчим хувиар нэмэгдэж, 2022-2025 онд 4-5 хувиар өсөх хандлагатай байна. 2026-2030 онд дээрх бүлгийн хүн амын тоо жилд дунджаар 2 орчим хувийн өсөлттэй байх төлөвтэй байна. Үүнээс харахад 2030 он хүртэл боловсролын салбарын онцлох дэд салбар БДБ байхаар

байна.

БДБ-д хамрагдалтын хувийг насны бүлгээс хамааруулан ялгаатай байхаар төлөвлөсөн. Тухайлбал суурь боловсролыг заавал эзэмшинэ хэмээн үзэж 2019-2020 оны хичээлийн жилийн байдлаар 77.6, 80.9, 62.8 хувьтай байгаа ахлах ангийн хамран сургалтыг харгалзан 85, 85, 70 хувьд хүргэхээр тооцсон.

Хүснэгт 6.11. БДБ-ын хамран сургалтын хувь

Нас	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
6	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
7	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
8	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
9	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
10	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
11	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
12	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
13	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
14	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%
15	78.3%	79.1%	79.8%	80.6%	81.3%	82.0%	82.8%	83.5%	84.3%	85.0%
16	81.3%	81.7%	82.1%	82.5%	83.0%	83.4%	83.8%	84.2%	84.6%	85.0%
17	63.5%	64.2%	65.0%	65.7%	66.4%	67.1%	67.8%	68.6%	69.3%	70.0%
Дундаж	94%	94%	94%	94%	94%	94%	95%	95%	95%	95%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх хамран сургалтын хувийг ашиглан тооцоход БДБ-д хамрагдах хүүхдийн тоо дараах байдалтай гарсан.

Хүснэгт 6.12 БДБ-д хамрагдах хүүхдийн тоо

Нас	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
6	77,101	81,345	80,906	81,633	82,267	81,553	81,342	80,989	80,530	84,109	80,275
7	72,347	76,389	81,292	80,854	81,583	81,584	81,527	81,314	80,959	84,312	80,815
8	67,633	72,105	76,343	81,245	80,810	81,283	81,562	81,503	81,288	84,084	81,288
9	61,202	68,542	72,065	76,302	81,203	80,572	81,264	81,540	81,480	83,738	81,686
10	64,351	65,495	68,506	72,029	76,265	79,449	80,554	81,244	81,519	84,940	81,957
11	60,291	62,711	65,460	68,472	71,994	77,971	79,432	80,535	81,224	82,368	82,077
12	53,188	59,970	62,679	65,428	68,439	73,517	77,954	79,413	80,514	79,779	82,036
13	44,764	57,067	59,939	62,647	65,394	69,649	73,501	77,936	79,393	77,518	81,363
14	42,563	53,869	57,033	59,905	62,613	66,376	69,630	73,480	77,911	75,166	80,592
15	33,291	39,527	42,571	45,494	48,229	51,610	54,437	57,619	61,346	59,910	68,829
16	35,151	38,320	41,202	44,180	47,011	50,372	52,895	55,560	58,567	57,102	64,631
17	28,567	28,190	30,250	32,724	35,303	38,449	40,738	43,024	45,447	44,474	50,230
Нийт	640,449	703,530	738,246	770,914	801,111	832,385	854,836	874,157	890,178	897,500	915,778
Жилийн өсөлт	-	9.8%	4.9%	4.4%	3.9%	3.9%	2.7%	2.3%	1.8%	0.8%	2.0%

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

БДБ-д хамрагдах хүүхдийн тоо 2021-2025 онд хамгийн их 10 хүртэл хувийн өсөлттэй, бусад хугацаанд 2 хувийн өсөлттэй байхаар байна.

2030 онд дээрх хүүхдүүдийн 90 хувь нь төрийн өмчийн сургуульд, 10 хувь нь хувийн хэвшлийн сургуульд хамрагдана гэж үзэхэд хамрагдалтын хувь дараах байдлаар өөрчлөгдөх тооцоо гарсан.

Хүснэгт 6.13 ЕБС-д суралцагчдын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн ЕБС	92.7%	92.4%	92.2%	91.9%	91.6%	91.4%	91.1%	90.8%	90.5%	90.3%	90.0%
Хувийн хэвшлийн ЕБС	7.3%	7.6%	7.8%	8.1%	8.4%	8.7%	8.9%	9.2%	9.5%	9.7%	10.0%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх тооцоололд суурилан ЕБС-д хамрагдах хүүхдийн тоог өмчийн хэлбэрээр дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6.14. ЕБС-д суралцах хүүхдийн тоо

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн ЕБС-д хамрагдах хүүхэд	593,438	650,273	680,367	708,393	733,978	760,384	778,585	793,822	805,967	810,173	824,200
Хувийн хэвшлийн ЕБС-д хамрагдах хүүхэд	47,011	53,257	57,878	62,521	67,133	72,001	76,251	80,335	84,211	87,327	91,578
Нэмэгдэх хүүхэд (төрийн өмчийн ЕБС)	-	56,835	30,094	28,025	25,586	26,406	18,201	15,237	12,145	4,206	14,027
Нэмж барих сургуулийн тоо (640 хүүхдийн сургууль)	-	89	47	44	40	41	28	24	19	7	22

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

2021-2030 онд манай улс 640 хүүхдийн суудалтай 361 сургууль барихад төрийн өмчийн ЕБС-д хамрагдах хүүхдүүдийг хүлээн авах боломжтой гэсэн тооцоо гарсан. Уг тооцоонд өнөөгийн бүлэг дүүргэлт хэвээр хадгалагдана хэмээн үзсэн.

Хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан төрийн өмчийн ЕБС-д ажиллах хүний нөөцийн тооцоог хийсэн бөгөөд бага ангийн 1 багшид 30 хүүхэд ногдоно, дунд болон ахлах ангийн багш, багш бус ажиллагчдын бага ангийн багштай харьцах харьцааг өнөөгийн түвшинд хадгалагдана гэж үзсэн.

Хүснэгт 6.15 Төрийн өмчийн ЕБС-д ажиллагчдын тооцоо

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Бага ангийн багш	9,853	11,211	11,646	12,009	12,281	12,315	12,334	12,307	12,246	12,673	12,181
Дунд ангийн багш	12,386	14,093	14,640	15,096	15,438	15,481	15,504	15,471	15,395	15,931	15,312
Ахлах ангийн багш	6,528	7,428	7,716	7,956	8,137	8,159	8,172	8,154	8,114	8,397	8,070
Багш бус ажиллагчид	17,521	19,936	20,710	21,355	21,839	21,899	21,932	21,886	21,777	22,536	21,660
Нийт ажиллагчид	46,288	52,668	54,713	56,416	57,694	57,855	57,942	57,819	57,531	59,538	57,223

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хүүхдийн тооны өсөлттэй уялдан 2021-2026 онд хүний нөөцийн хэрэгцээ нэмэгдэх бол 2027 оноос эхлэн шаардагдах багш,

багш бус ажиллагчдын тоо бага зэрэг буурах төлөвтэй байна.

6.1.3 Мэргэжлийн боловсрол, сургалт

2021 оноос 2030 онд МБС-д хамрагдах үндсэн насны хүн амын тоог ҮСХ-оос хийсэн Монгол Улсын харьяат хүн амын хувьд

тооцсон хүн амын тоо, хүйс, насны бүлэг, дунд хувилбар 2Б, 2015-2045 он тооцоонд суурилан Хүснэгт 6.16-д харуулж байна.

Хүснэгт 6.16 МБС-д хамрагдах насны хүн амын тоо, 2021-2030 он

Нас	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
15	50,456	53,833	56,996	59,867	63,481	66,354	69,605	73,451	71,101	80,975
16	47,128	50,418	53,793	56,956	60,726	63,454	66,324	69,573	67,505	76,036
17	44,380	47,089	50,376	53,750	57,905	60,694	63,420	66,288	64,194	71,757
18	42,785	44,337	47,044	50,331	54,856	57,870	60,657	63,380	60,987	68,187
Нийт	184,749	195,677	208,209	220,904	236,968	248,372	260,006	272,692	263,787	296,955

Эх сурвалж: ҮСХ

2018 оны жилийн эцэст 15-18 настай хүн ам 180,086 байсантай харьцуулахад 2021 онд суурь он буюу 2018 оноос 3 орчим хувиар нэмэгдэж, 2022-2025 онд 6-7 хувиар өсөх хандлагатай байна. 2026-2030 онд (2029 оныг эс тооцвол, тус оны тоо алдаатай байж болзошгүй) дээрх бүлгийн хүн амын тоо жилд дунджаар 4 орчим хувийн өсөлттэй байх төлөвтэй байна.

МБС-д хамрагдалтын хувийг насны бүлгээс хамааруулан ялгаатай байхаар төлөвлөсөн.

Тухайлбал 15 настай хүүхдүүдийн хувьд 10-р ангид суралцахгүй байгаа хэсгийг МБС-д хамрагдана гэж үзсэн бол бусад насны бүлгийн хувьд 15 хувь нь хамрагдана гэж тооцсон (одоогоор харгалзан 12.8, 11.2, 8 хувьтай байгаа). Мөн бусад насны бүлгийн хувьд суралцагчдын тоог дээрх үндсэн бүлгийн суралцагчдын тоотой харьцах харьцааг 100 болно хэмээн үзсэн (одоогоор 96.3 хувь байна).

Хүснэгт 6.17 МБС-ын хамран сургалтын хувь

Нас	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
15	11.5%	21.7%	20.9%	20.2%	19.4%	18.7%	18.0%	17.2%	16.5%	15.7%	15.0%
16	12.8%	13.0%	13.2%	13.5%	13.7%	13.9%	14.1%	14.3%	14.6%	14.8%	15.0%
17	11.2%	11.6%	12.0%	12.3%	12.7%	13.1%	13.5%	13.9%	14.2%	14.6%	15.0%
18	8%	8.7%	9.4%	10.1%	10.8%	11.5%	12.2%	12.9%	13.6%	14.3%	15.0%
Бусад насны бүлэг	96.3%	96.4%	96.8%	97.2%	97.6%	98.0%	98.4%	98.8%	99.2%	99.6%	100.0%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх хамран сургалтын хувийг ашиглан тооцоход МБС-д хамрагдах иргэдийн тоо дараах байдалтай гарсан.

Хүснэгт 6.18 МБС-д хамрагдах хүүхдийн тоо

Нас	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
15	4,932	10,929	11,262	11,502	11,638	11,871	11,917	11,986	12,105	11,191	12,146
16	5,578	6,136	6,675	7,241	7,792	8,441	8,960	9,511	10,130	9,977	11,405
17	5,115	5,139	5,632	6,216	6,837	7,586	8,182	8,790	9,439	9,385	10,764
18	4,004	3,722	4,168	4,751	5,436	6,308	7,060	7,825	8,620	8,721	10,228
Бусад насны бүлэг	18,897	24,993	26,849	28,878	30,942	33,522	35,541	37,654	39,971	39,118	44,543
Нийт	38,526	50,919	54,586	58,588	62,644	67,728	71,659	75,766	80,265	78,393	89,087

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

МБС-д хамрагдах иргэдийн тоо 2021 онд огцом нэмэгдэхээр байгаа бол бусад хугацаанд 6-8 хувийн өсөлттэй байхаар байна.

2030 онд дээрх хүүхдүүдийн 65 хувь нь төрийн өмчийн МБС-ын байгууллагад, 35 хувь нь хувийн хэвшлийн сургуульд хамрагдана гэж үзэхэд хамрагдалтын хувь дараах байдлаар өөрчлөгдөх тооцоо гарсан.

Хүснэгт 6.19. МБС-ын байгууллагад суралцагчдын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн МБС-ын байгууллага	71.9%	71.2%	70.5%	69.8%	69.1%	68.5%	67.8%	67.1%	66.4%	65.7%	65.0%
Хувийн хэвшлийн МБС-ын байгууллага	28.1%	28.8%	29.5%	30.2%	30.9%	31.6%	32.2%	32.9%	33.6%	34.3%	35.0%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх тооцоололд суурилан МБС-д хамрагдах хүүхдийн тоог өмчийн хэлбэрээр дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6.20 МБС-ын байгууллагад суралцах хүүхдийн тоо

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн МБС-ын байгууллагад хамрагдах хүүхэд	27,712	36,260	38,494	40,912	43,312	46,360	48,556	50,816	53,280	51,496	57,906
Хувийн хэвшлийн МБС-ын байгууллагад хамрагдах хүүхэд	10,814	14,660	16,092	17,676	19,332	21,368	23,103	24,950	26,985	26,896	31,180
Нэмэгдэх хүүхэд (төрийн өмчийн МБС)	-	8,548	2,234	2,418	2,400	3,047	2,197	2,260	2,464	(1,784)	6,410
Жилийн өсөлт	-	30.8%	6.2%	6.3%	5.9%	7.0%	4.7%	4.7%	4.8%	-3.3%	12.4%

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Дээрх тооцооллоос МБС-ын байгууллагад хамрагдах иргэдийн тоо 2025 он хүртэл эрчимтэй буюу жилд ойролцоогоор 6-7 хувь нэмэгдэх бол (2021 онд 30.8 хувийн өсөлттэй байна) цаашид жилийн 4 хувийн өсөлттэй байхаар байна. 2011-2012 оны хичээлийн жилд манай улсын МБС-ын байгууллагад 37,227 суралцагч суралцаж байсан. Тиймээс

2021-2030 онд гарах суралцагчдын тооны өсөлтийг одоогийн тогтолцоо шингээн хэмээн үзлээ. Тус тооцоонд МБС-ын байгууллагад суралцагчдын тоог зориудаар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд бодит байдал дээр хүүхдүүдийн мэргэжил сонголт сонирхол, уг салбарын нэр хүндээс хамааран буурахыг үгүйсгэхгүй юм.

6.1.4 Дээд боловсрол

2021 оноос 2030 онд дээд боловсролд хамрагдах үндсэн насны хүн амын тоог ҮСХ-оос хийсэн Монгол Улсын харьяат хүн амын хувьд тооцсон хүн амын тоо, хүйс,

насны бүлэг, дунд хувилбар 2Б, 2015-2045 он тооцоонд суурилан Хүснэгт 6.21-д харуулж байна.

Хүснэгт 6.21 Дээд боловсролд хамрагдах хүн амын тоо, 2021-2030

Нас	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
18	42,785	44,337	47,044	50,331	54,856	57,870	60,657	63,380	60,987	68,187
19	42,686	42,740	44,291	46,996	51,558	54,818	57,829	60,611	57,805	65,125
20	43,727	42,635	42,692	44,242	48,201	51,517	54,774	57,781	54,683	62,322
21	45,301	43,672	42,584	42,642	45,182	48,159	51,473	54,726	51,782	59,560
Нийт	174,499	173,384	176,611	184,211	199,797	212,364	224,733	236,498	225,257	255,194

Эх сурвалж: ҮСХ

2018 оны жилийн эцэст 18-21 настай хүн ам 190,539 байсантай харьцуулахад 2025 он хүртэл 2018 оны суурь түвшинд хүрэхгүй, 2026 оноос нэмэгдэх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл 2026 оноос хойш жилд 5-6 хувийн өсөлттэй байхаар байна.

Дээд боловсролд хамрагдалтын хувийг 18-21 насны залуучуудын хувьд 45 хувь байхаар

төлөвлөсөн. Одоогоор 63 хувь байгаа бөгөөд дээд боловсролын байгууллагын тоог нэгтгэх, элсэх босгыг өндөрсгөх зэрэг шалтгаанаар тус хувийг бууруулж төлөвлөсөн. Мөн ахисан түвшний сургалтад хамрагсдын тоог бакалаврын сургалтад суралцагчдын тоотой харьцах харьцааг нь тогтмол байна гэж үзэн тодорхойлсон болно.

Хүснэгт 6.22 Дээд боловсролд хамран сургалтын хувь

Нас	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
18-21	63%	61%	59%	58%	56%	54%	52%	50%	49%	47%	45%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх хамран сургалтын хувийг ашиглан тооцоход дээд боловсролд хамрагдах иргэдийн тоо дараах байдалтай гарсан.

Хүснэгт 6.23 Дээд боловсролд хамрагдах суралцагчдын тоо

Нас	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Бакалаврын сургалт	119,301	106,793	102,990	101,728	102,790	107,890	110,854	113,265	114,938	105,420	114,837
Ахисан түвшний сургалт	29,145	26,089	25,160	24,852	25,111	26,357	27,081	27,671	28,079	25,754	28,055
Нийт	148,446	132,883	128,150	126,580	127,901	134,248	137,935	140,936	143,017	131,174	142,892

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

2021-2030 онд дээд боловсролд хамрагдах иргэдийн тоо 2018 оны суурь түвшинд хүрэхгүй байх тооцоотой байна.

2030 онд дээрх иргэдийн 70 хувь нь төрийн өмчийн дээд боловсролын

байгууллагад, 30 хувь нь хувийн хэвшлийн дээд боловсролын байгууллагад хамрагдана гэж үзэхэд хамрагдалтын хувь дараах байдлаар өөрчлөгдөх тооцоо гарсан.

Хүснэгт 6.24 Дээд боловсролын байгууллагад суралцагчдын эзлэх хувь, өмчийн хэлбэрээр

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн дээд боловсролын байгууллага	55.8%	57.2%	58.6%	60.1%	61.5%	62.9%	64.3%	65.7%	67.2%	68.6%	70.0%
Хувийн өмчийн дээд боловсролын байгууллага	44.2%	42.8%	41.4%	39.9%	38.5%	37.1%	35.7%	34.3%	32.8%	31.4%	30.0%

Эх сурвалж: EPSSim программ

Дээрх тооцоололд суурилан дээд боловсролын байгууллагад хамрагдах хүүхдийн тоог өмчийн хэлбэрээр дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 6.25 Дээд боловсролын байгууллагад суралцах хүний тоо

	Суурь 2019/20	2021	2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030
Төрийн өмчийн дээд боловсролын байгууллага	87,992	76,036	75,147	76,024	78,634	84,442	88,720	92,651	96,050	89,959	100,024
Хувийн өмчийн дээд боловсролын байгууллага	69,633	56,847	53,003	50,556	49,267	49,806	49,215	48,285	46,967	41,215	42,868
Нэмэгдэх хүүхэд (төрийн өмчийн дээд боловсролын байгууллага)	-	(11,956)	(888)	876	2,610	5,808	4,278	3,931	3,399	(6,091)	10,065

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Дээрх тооцооноос үзэхэд дээд боловсролын байгууллагад хамрагдах иргэдийн тоо 2026 он хүртэл 2018 он буюу суурь оны түвшинд хүрэхгүй байна. Тиймээс 2021-2030 онд гарах суралцагчдын тооны өсөлтийг одоогийн тогтолцоо шингээнэ

хэмээн үзлээ. Тус тооцоонд дээд боловсролын байгууллагад суралцагчдын тоог зориудаар бууруулахаар төлөвлөсөн бөгөөд бодит байдал дээр хүүхдүүдийн мэргэжил сонголт, сонирхлоос хамааран өсөхийг ч үгүйсгэхгүй.

6.1.5 Насан туршийн суралцахуй

2013 оны байдлаар манай улсын 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь эрэгтэй 95.2, эмэгтэй 97.5 хувьтай

байсан. Дээрх хувиудыг 99 хувьд хүргэхээр тооцоход 2021-2025 онд дараах тооны залуус бичиг үсгийн сургалтад хамрагдахаар байна.

Хүснэгт 6.26 Бичиг үсгийн сургалтад хамрагдах иргэдийн тоо, 15-24 нас

	Суурь 2018/2019	2021	2022	2023	2024	2025
Эрэгтэй	-	10,290	9,492	8,758	8,064	7,580
Эмэгтэй	-	5,365	5,061	4,797	4,562	4,347
Нийт	2,855	15,655	14,554	13,556	12,627	11,927

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Дүйцүүлэх хөтөлбөрт суралцагчдын тоо жилээс жилд буурч байгаа нь хүн амын боловсрол сайжирч байгаатай шууд холбоотой. 2018-2019 оны хичээлийн жилд 7,296 суралцагч дүйцүүлэх хөтөлбөрт

суралцсан бөгөөд энэ тоо жил тутам 8 хувиар буурч байна. Эдгээр үзүүлэлт дээр суурилан 2021-2025 онд дүйцүүлэх хөтөлбөрт хамрагдах суралцагчдын тоог тооцоолов.

Хүснэгт 6.27 Дүйцүүлэх хөтөлбөрт хамрагдах иргэдийн тоо

	Суурь 2018/2019	2021	2022	2023	2024	2025
Нийт	7,296	6,712	6,175	5,681	5,227	4,809

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Бичиг үсгийн сургалтад хамрагдах иргэдийг 30 суралцагчтай бүлгээр сургах тохиолдолд хамгийн ихдээ 522 багш хэрэгцээтэй байна. Тиймээс одоогийн тогтолцоонд ажиллаж байгаа 630 багш, ажилтнууд насан туршийн боловсролын өнөөгийн үйлчилгээ буюу бичиг үсгийн болон дүйцүүлэх хөтөлбөрийн сургалтыг үргэлжлүүлэн хүргэхэд хүрэлцэнэ гэж тооцлоо.

Цаашид хүн амын боловсрол сайжирч байгаа нөхцөлд насан туршийн өнөөгийн тогтолцоо энэ байдлаараа үргэлжлэх нь цаг үеийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүйг анхаарч хүн амын насан туршдаа суралцахуйг дэмжсэн шинэ тогтолцоонд шилжих нь чухал байна.

6.2 ШААРДАГДАХ САНХҮҮЖИЛТИЙН ТООЦОО

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг 2021-2025 онд нарийвчлан тооцсонтой холбоотойгоор боловсролын салбарт шаардагдах санхүүжилтийн тооцоог

өмнөх дэд хэсэгт хийсэн боловсролын хэрэгцээний тооцооны 2021-2025 оны тоонд суурилан гаргасан.

Хүснэгт 6.28 СӨБ-д шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг

Зардлын анги	2021	2022	2023	2024	2025
Багшийн цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	129.45	140.43	153.34	163.75	173.51
Туслах багшийн цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	80.37	87.11	95.03	101.40	107.34
Багш бус ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	184.34	197.18	212.24	223.41	233.27
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	53.21	57.34	62.18	65.95	69.41
Хоол, хүнс	98.61	107.82	117.50	127.58	136.84
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1.66	1.80	1.95	2.10	2.24
Бусад хувьсах зардал	8.98	9.75	10.55	11.37	12.10
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35.53	38.94	42.27	45.65	49.30
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	36.30	41.10	46.34	51.99	57.56
Урсгал шилжүүлэг	16.54	17.89	19.42	20.71	21.90
Нийт урсгал зардал	645.00	699.36	760.80	813.90	863.47
Барилга, байгууламж	61.84	16.41	6.00	-	-
Их засвар	15.40	16.88	18.32	19.79	21.37
Тоног төхөөрөмж	11.32	7.27	6.71	6.60	7.12
Хөрөнгийн зардал	88.56	40.56	31.03	26.38	28.50
Нийт зарлага	733.55	739.93	791.84	840.28	891.96
Урсгал зардлын эзлэх хувь	87.93%	94.52%	96.08%	96.86%	96.81%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	12.07%	5.48%	3.92%	3.14%	3.19%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

- Ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлыг тооцохдоо ЮНЕСКО-ийн EPSSim загварын дагуу нэг хүнд ногдох ДНБ-ээс хамаарсан үржүүлэгч тооцож ашигласан бөгөөд тухайн албан тушаалтны жилийн үндсэн цалинг 30 хувиар нэмэгдүүлж (нэмэгдэл урамшлыг тооцох зорилгоор) тухайн жилийн ДНБ-д хуваан гарч ирсэн индексийг үржүүлэгч болгосон. Ингэж тооцоход багшийн цалингийн индекс 1.18, туслах багшийн цалингийн индекс 0.93, багш бус ажилтны цалингийн индекс 1.03 гарсан.
- Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэлийг нийт ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлаас 13.5 хувиар тооцсон.
- Хоол хүнс, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, бусад хувьсах зардлыг тооцохдоо нэг хүүхэд ногдох хэмжээг тооцоолж жил тус бүрд хүүхдийн тоогоор үржүүлж гаргасан. Мөн инфляц жил бүр 8 хувьтай байна хэмээн төсөөлж дээрх зардлуудыг инфляцын түвшинтэй уялдуулан индексжүүлсэн.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг тооцохдоо нэг цэцэрлэгт ногдох дундаж зардлыг тооцоолж тухайн онд байх цэцэрлэгийн тоогоор үржүүлсэн.
- Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг тооцохдоо хувийн хэвшлийн цэцэрлэгийн нэг хүүхэд ногдох хэмжээг хувийн хэвшлийн цэцэрлэгт хамрагдах

- хүүхдийн тоогоор үржүүлсэн.
- Урсгал шилжүүлгийн бараа, үйлчилгээний зардалд эзлэх хувийг 2020 оны түвшинд байна хэмээн тооцоолж (2.79%) 2021-2025 оны хэмжээг ойролцоогоор тооцоолсон.
- 75 ортой цэцэрлэг барих жишиг өртгийг (1 тэрбум төгрөг) инфляцын түвшинтэй индексжүүлж барилга байгууламжийн зардлыг тооцоолсон.
- Их засварын хувьд жил бүр нийт цэцэрлэгийн 5 хувьд их засвар хийхээр, тус бүрийн өртөг 0.3 тэрбум төгрөг хэмээн тооцоолсон.
- Тоног төхөөрөмжийн зардлыг тооцохдоо шинээр баригдсан цэцэрлэг бүрд, жил бүр нийт цэцэрлэгийн 5 хувьд 0.1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлнэ гэж тооцсон.

Хүснэгт 6.29 БДБ-д шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг

Зардлын анги	2021	2022	2023	2024	2025
Багшийн цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	483.50	541.66	608.26	665.03	716.14
Багш бус ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	256.52	287.38	322.71	352.83	379.94
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	99.90	111.92	125.68	137.41	147.97
Хоол, хүнс	34.36	38.67	43.19	47.84	51.96
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4.66	5.27	5.92	6.63	7.42
Бусад хувьсах зардал	32.79	37.05	41.66	46.62	52.16
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127.56	146.40	166.79	188.69	213.32
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	25.58	30.03	35.03	40.62	47.05
Урсгал шилжүүлэг	105.84	118.98	133.83	147.16	159.77
Нийт урсгал зардал	1,170.72	1,317.34	1,483.08	1,632.82	1,775.73
Барилга, байгууламж	498.73	285.20	286.84	282.82	315.24
Их засвар	20.27	23.26	26.50	29.98	33.90
Тоног төхөөрөмж	136.45	101.38	108.17	114.36	128.42
Хөрөнгийн зардал	655.45	409.84	421.52	427.17	477.56
Нийт зарлага	1,826.17	1,727.19	1,904.60	2,059.99	2,253.29
Урсгал зардлын эзлэх хувь	64.11%	76.27%	77.87%	79.26%	78.81%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	35.89%	23.73%	22.13%	20.74%	21.19%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

- Ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлыг тооцохдоо ЮНЕСКО-ын EPSSim загварын дагуу нэг хүнд ногдох ДНБ-ээс хамаарсан үржүүлэгч тооцож ашигласан бөгөөд тухайн албан тушаалтны жилийн үндсэн цалинг 30 хувиар нэмэгдүүлж (нэмэгдэл урамшлыг тооцох зорилгоор) тухайн жилийн ДНБ-д хуваан гарч ирсэн индексийг үржүүлэгч болгосон. Дээрх тооцооллоос багшийн цалингийн индекс 1.18, багш бус ажилтны цалингийн индекс 1.03 гарсан.
- Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэлийг нийт ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлаас 13.5 хувиар тооцсон.
- Хоол хүнс, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, бусад хувьсах зардлыг тооцохдоо нэг хүүхэд ногдох хэмжээг тооцоолж жил тус бүрд хүүхдийн тоогоор үржүүлж гаргасан. Мөн инфляцыг жил бүр 8 хувьтай байна хэмээн төсөөлж дээрх зардлуудыг инфляцын түвшинтэй уялдуулан индексжүүлсэн.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг тооцохдоо нэг сургуульд ногдох дундаж зардлыг тооцоолж тухайн онд байх сургуулийн тоогоор үржүүлсэн.
- Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг тооцохдоо хувийн хэвшлийн сургуулийн нэг хүүхэд ногдох хэмжээг

- хувийн хэвшлийн сургуульд хамрагдах хүүхдийн тоогоор үржүүлсэн.
- Урсгал шилжүүлгийн бараа, үйлчилгээний зардалд эзлэх хувийг 2020 оны түвшинд байна хэмээн тооцоолж (10.18%) 2021-2025 оны хэмжээг ойролцоогоор тооцоолсон.
- 640 суудалтай сургууль барих жишиг өртгийг (5.2 тэрбум төгрөг) инфляцын түвшинтэй индексжүүлж барилга байгууламжийн зардлыг тооцоолсон.
- Их засварын хувьд жил бүр нийт сургуулийн 5 хувьд их засвар хийнэ, тус бүрийн өртөг 0.5 тэрбум төгрөг хэмээн тооцоолсон.
- Тоног төхөөрөмжийн зардлыг тооцохдоо шинээр баригдсан сургууль бүрд, жил бүр нийт сургуулийн 5 хувьд 1 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлнэ гэж тооцсон.

Хүснэгт 6.30 МБС-д шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг

Зардлын анги	2021	2022	2023	2024	2025
Багшийн цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	31.03	33.46	36.44	38.96	41.83
Захиргааны ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	7.04	7.60	8.27	8.84	9.50
Үйлчилгээний ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	17.72	19.11	20.81	22.25	23.89
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	7.53	8.12	8.85	9.46	10.15
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18.59	21.38	24.47	27.96	32.34
Бусад хувьсах зардал	8.88	10.21	11.68	13.35	15.45
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11.18	12.11	13.04	14.08	15.22
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	0.86	1.03	1.22	1.44	1.72
Урсгал шилжүүлэг	5.20	5.71	6.30	6.88	7.57
Суралцагчдад олгох тэтгэлэг	101.84	109.17	117.18	125.29	135.46
Нийт урсгал зардал	209.86	227.89	248.25	268.49	293.12
Хөрөнгийн зардал (нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү)	41.97	45.58	49.65	53.70	58.62
Нийт зарлага	251.84	273.47	297.90	322.19	351.74
Урсгал зардлын эзлэх хувь	83.33%	83.33%	83.33%	83.33%	83.33%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	16.67%	16.67%	16.67%	16.67%	16.67%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

- Ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлыг тооцохдоо ЮНЕСКО-ын EPSSim загварын дагуу нэг хүнд ногдох ДНБ-ээс хамаарсан үржүүлэгч тооцож ашигласан бөгөөд тухайн албан тушаалтны жилийн үндсэн цалинг 30 хувиар нэмэгдүүлж (нэмэгдэл урамшлыг тооцох зорилгоор) тухайн жилийн ДНБ-д хуваан гарч ирсэн индексийг үржүүлэгч болгосон. Ингэж тооцоход багшийн цалингийн индекс 1.24, захиргааны ажилтны цалингийн индекс 1.43, үйлчилгээний ажилтны цалингийн индекс 1.03 гарсан.
- Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэлийг нийт ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлаас 13.5 хувиар тооцсон.
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, бусад хувьсах зардлыг тооцохдоо нэг хүүхэд ногдох хэмжээг тооцоолж жил тус бүрт суралцагчийн тоогоор үржүүлж гаргасан. Мөн инфляц жил бүр 8 хувьтай байна хэмээн төсөөлж дээрх зардлуудыг инфляцын түвшинтэй уялдуулан индексжүүлсэн.
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг шинээр барилга барина гэж тооцоогүй тул инфляцын түвшинтэй уялдуулан өснө гэж үзсэн.

- Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг тооцохдоо хувийн хэвшлийн сургуулийн нэг суралцагчид ногдох хэмжээг хувийн хэвшлийн сургуульд хамрагдах хүүхдийн тоогоор үржүүлсэн.
- Урсгал шилжүүлгийн бараа, үйлчилгээний зардалд эзлэх хувийг 2020 оны түвшинд байна хэмээн тооцоолж (5.1%) 2021-2025 оны хэмжээг ойролцоогоор тооцоолсон.
- МБС-ын байгууллагад суралцагчдад өгч буй тэтгэлгийн хэмжээг тооцохдоо нэг суралцагчид ногдох хэмжээг өнөөгийн түвшинд байна гэж тооцож 2021-2025 оны хүүхдийн тоогоор үржүүлж тооцсон.
- Хөрөнгийн зардлын хувьд нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү байна гэж төсөөлсөн. Уг зардлаар шаардлагатай их засвар хийгдэж тоног төхөөрөмж худалдаж авна.

Хүснэгт 6.31 Дээд боловсролд шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг

Зардлын анги	2021	2022	2023	2024	2025
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21.11	21.98	23.30	25.33	28.63
Эргэж төлөгдөх зээл	50.96	55.43	61.29	69.38	81.59
Бусад урсгал зардал	9.54	10.25	11.20	12.54	14.59
Нийт урсгал зардал	81.61	87.66	95.79	107.24	124.82
Хөрөнгийн зардал (нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү)	16.32	17.53	19.16	21.45	24.96
Нийт зарлага	97.93	105.19	114.94	128.69	149.78
Урсгал зардлын эзлэх хувь	83.33%	83.33%	83.33%	83.33%	83.33%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	16.67%	16.67%	16.67%	16.67%	16.67%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

- Дээд боловсролын санхүүжилтийн хувьд суралцагчдын тэтгэлэг, төлбөрийн хөнгөлөлт болон зээл урсгал зардлын дийлэнх хувийг бүрдүүлдэг.
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын дүнг тооцохдоо бакалаврын түвшинд суралцах оюутны 4.07-4.13 хувь нь тэтгэлэг, төлбөрийн хөнгөлөлт эдэлнэ гэж тооцсон. Уг үзүүлэлт 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар 4.14 хувь байсан бөгөөд 2030 онд 4 хувьтай тэнцэхээр төсөөлсөн. Улмаар нэг суралцагчид ногдох хэмжээг тооцож бакалаврын түвшинд суралцах нийт хүүхдийн тоогоор үржүүлэн жил бүрийн 8 хувийн инфляцын түвшингээр индексжүүлсэн.
- Эргэж төлөгдөх зээлийн хувьд мөн суралцагчдын 3.7-4.3 хувь нь зээлээр суралцана гэсэн төсөөлөл дээр суурилж тооцсон. 2018-2019 оны хичээлийн жилийн мэдээгээр уг үзүүлэлт 3.5 хувьтай байсныг 2030 онд 5 хувьд хүргэнэ гэж үзсэн. Улмаар нэг суралцагчид ногдох хэмжээг тооцож бакалаврын түвшинд суралцах нийт хүүхдийн тоогоор үржүүлэн жил бүрийн 8 хувийн инфляцын түвшингээр индексжүүлсэн.
- Бусад урсгал зардлын хувьд дээрх 2 зардлын ангийн дүнд эзлэх хувийг 13.2 хувь хэвээр хадгалагдана гэж тооцсон.
- Хөрөнгийн зардлын хувьд нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү байна гэж төсөөлсөн.

Хүснэгт 6.32 Насан туршийн боловсролд шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг

Зардлын анги	2021	2022	2023	2024	2025
Багшийн цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	7.71	7.73	7.84	7.81	7.92
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	1.04	1.04	1.06	1.05	1.07
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.28	0.29	0.29	0.29	0.29
Бусад хувьсах зардал	0.31	0.31	0.31	0.31	0.32
Нийт урсгал зардал	9.34	9.37	9.49	9.46	9.59
Хөрөнгийн зардал (нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү)	1.87	1.87	1.90	1.89	1.92
Нийт зарлага	11.21	11.24	11.39	11.35	11.51
Урсгал зардлын эзлэх хувь	83.33%	83.33%	83.33%	83.33%	83.33%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	16.67%	16.67%	16.67%	16.67%	16.67%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

- Ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлыг тооцохдоо ЮНЕСКО-ын EPSSim загварын дагуу нэг хүнд ногдох ДНБ-ээс хамаарсан үржүүлэгч тооцож ашигласан бөгөөд тухайн албан тушаалтны жилийн үндсэн цалинг 30 хувиар нэмэгдүүлж (нэмэгдэл урамшлыг тооцох зорилгоор) тухайн жилийн ДНБ-д хуваан гарч ирсэн индексийг үржүүлэгч болгосон. Насан туршийн багш, ажилтны цалинг ЕБС-ийн багштай ижил байхаар тооцоход багш, ажилтны цалингийн индекс 1.18 гарсан.
- Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэлийг нийт ажилтны цалин, хөлс болон нэмэгдэл урамшлаас 13.5 хувиар тооцсон.
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх, бусад хувьсах зардлыг тооцохдоо нэг хүүхэд ногдох хэмжээг тооцоолж жил тус бүрт хүүхдийн тоогоор үржүүлж гаргасан. Мөн инфляцыг жил бүр 8 хувьтай байна хэмээн төсөөлж дээрх зардлуудыг инфляцын түвшинтэй уялдуулан индексжүүлсэн.
- Хөрөнгийн зардлын хувьд нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү байна гэж төсөөлсөн.

Хүснэгт 6.33 Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлагад шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг

Зардлын анги	2021	2022	2023	2024	2025
Нийт урсгал зардал	18.84	20.41	21.98	23.73	25.65
Хөрөнгийн зардал (нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү)	3.77	4.08	4.40	4.75	5.13
Нийт зарлага	22.61	24.50	26.38	28.47	30.78
Урсгал зардлын эзлэх хувь	83.33%	83.33%	83.33%	83.33%	83.33%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	16.67%	16.67%	16.67%	16.67%	16.67%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

- 2020 онд урсгал зардлын төсөв 17.45 тэрбум төгрөг байсан. Үүнийг жил тутмын 8 хувийн инфляцын түшингээр индексжүүлэн 2021-2025 оны урсгал зардлыг тооцсон.
- Хөрөнгийн зардлын хувьд нийт урсгал зардлын 20 хувьтай тэнцүү байна гэж төсөөлсөн.
Дээрх бүх дэд салбаруудад шаардагдах санхүүжилтийг нэгтгэн дараах хүснэгтэд харуулж байна.

Хүснэгт 6.34 Боловсролын салбарт шаардагдах санхүүгийн тооцоо, тэрбум төгрөг

Дэд салбар	2021	2022	2023	2024	2025
СӨБ	733.55	739.93	791.84	840.28	891.96
Урсгал зардал	645.00	699.36	760.80	813.90	863.47
Хөрөнгийн зардал	88.56	40.56	31.03	26.38	28.50
БДБ	1,826.17	1,727.19	1,904.60	2,059.99	2,253.29
Урсгал зардал	1,170.72	1,317.34	1,483.08	1,632.82	1,775.73
Хөрөнгийн зардал	655.45	409.84	421.52	427.17	477.56
МБС	251.84	273.47	297.90	322.19	351.74
Урсгал зардал	209.86	227.89	248.25	268.49	293.12
Хөрөнгийн зардал	41.97	45.58	49.65	53.70	58.62
Дээд боловсрол	97.93	105.19	114.94	128.69	149.78
Урсгал зардал	81.61	87.66	95.79	107.24	124.82
Хөрөнгийн зардал	16.32	17.53	19.16	21.45	24.96
Насан туршийн боловсрол	11.21	11.24	11.39	11.35	11.51
Урсгал зардал	9.34	9.37	9.49	9.46	9.59
Хөрөнгийн зардал	1.87	1.87	1.90	1.89	1.92
Боловсрол, шинжлэх ухааны бодлого, удирдлага	22.61	24.50	26.38	28.47	30.78
Урсгал зардал	18.84	20.41	21.98	23.73	25.65
Хөрөнгийн зардал	3.77	4.08	4.40	4.75	5.13
НИЙТ	2,943.32	2,881.51	3,147.06	3,390.98	3,689.07
Урсгал зардал	2,135.38	2,362.04	2,619.40	2,855.64	3,092.38
Хөрөнгийн зардал	807.94	519.47	527.66	535.34	596.69
Урсгал зардлын эзлэх хувь	72.55%	81.97%	83.23%	84.21%	83.83%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	27.45%	18.03%	16.77%	15.79%	16.17%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

6.3 УЛСЫН ТӨСӨВ БА БОЛОВСРОЛЫН ЗАРДАЛ, ДУТАГДАХ НӨӨЦИЙН ТООЦОО

Боловсролын салбарын төсвийг тооцохдоо Үндэсний хөгжлийн газрын Дунд хугацааны хөгжлийн хүрээний IV тайлангийн тоон мэдээллийг ашиглав. Тус байгууллагаас ДНБ-ий хэмжээг 2020-2025 онд дээд /их буюу

өөдрөг/, дунд, доод /бага буюу өөдрөг биш/ гэсэн гурван хувилбараар тооцсон байдаг. Хүснэгт 6.35-д хэтийн тооцоололд ашигласан зарим үзүүлэлтүүдийг харуулж байна.

Хүснэгт 6.35 ДНБ, улсын төсвийн ДНБ-д эзлэх хувь болон боловсролын салбарын төсвийн улсын төсөвт эзлэх хувийн таамаглал

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025
ДНБ*, тэрбум төгрөг	42660.9	46851.9	51931.3	56472	61647.1
Нэгдсэн төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь	30.6%	30.9%	31.1%	31.2%	31.4%
Нэгдсэн төсвийн зарлага, тэрбум төгрөг	13,054.24	14,477.24	16,150.63	17,619.26	19,357.19
Боловсролын салбарын зардлын төсвийн нэгдсэн төсвийн зарлагад эзлэх хувь**	15.44%	15.89%	16.35%	16.83%	17.32%
Боловсролын салбарын зардал, тэрбум төгрөг	2,015.29	2,300.20	2,640.96	2,965.20	3,352.76
ДНБ-д боловсролын салбарт улсын төсвөөс зарцуулах зардлын эзлэх хувь	4.7	4.9	5.1	5.3	5.4

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газрын Дунд хугацааны хөгжлийн хүрээний IV тайланд суурилсан судлаачийн тооцоо

Жич: * дунд хувилбарын ДНБ-ийг ашигласан.

** Уг хувийг 2030 онд олон улсын байгууллагуудын зөвлөмжийн дагуу 20 хувьд хүрнэ хэмээн тооцсон. Жилд 2.9 хувиар өсөхөөр байна.

Өмнөх хэсэгт тооцоолсон боловсролын салбарын төсөв ихээхэн дутах төлөвтэй салбарт шаардагдах санхүүгийн тооцоотой байна. харьцуулахад манай улсын боловсролын

Хүснэгт 6.36 Боловсролын салбарт дутагдах нөөц, эзлэх хувь ба тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025
Шаардагдах санхүүжилтэд улсын төсвийн эзлэх хувь	68.5%	79.8%	83.9%	87.4%	90.9%
Дутагдах санхүүжилт, хувь	31.5%	20.2%	16.1%	12.6%	9.1%
Дутагдах санхүүжилт, тэрбум төгрөг	928.04	581.31	506.09	425.78	336.30

Эх сурвалж: судлаачийн тооцоо

Хүүхдийн тооны өсөлтөөс шалтгаалсан барилга байгууламж, урсгал зардал тэрдундаа багш, ажилтнуудын цалингийн нэмэгдлээс

шалтгаалан манай улсын боловсролын салбарт 2021-2025 онд ихээхэн хэмжээний нэмэлт санхүүжилт шаардагдахаар байна.

6.4 САНХҮҮЖИЛТИЙН СТРАТЕГИ

Санхүүжилт дутах нөхцөлд багш, ажилтнуудын цалинг инфляцын түвшнийг харгалзан нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлттэй уялдуулан жил бүр 7-9 хувиар нэмэх боломжгүй байдалд хүрч мэдэхээр байна.

2021-2025 онд боловсролын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг үндсэндээ гадаад эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжтой гэж тооцсон.

Мөн бүх шатны хувийн хэвшлийн сургалтын байгууллагуудад олгодог татаасыг зогсоож, МБС-ын байгууллагад суралцагчдын тэтгэлгийг зогсоох зэрэг зохицуулалтыг хийж урсгал зардлыг бууруулах шаардлагатай байна.

Хөгжлийн түншүүд Монгол Улсын боловсролын салбарт зээл, тусламжийн төслөөр дамжуулан мэдэгдэхүйц хөрөнгө оруулалт хийж байна. Дараах хүснэгтэд хөгжлийн түншүүдийн одоо хэрэгжүүлж байгаа болон ойрын үед хэрэгжүүлэх төслүүдийн санхүүжилтийн дүнг үзүүлэв.¹⁶⁸

Иймд боловсролын салбарын урсгал зардлыг улсын нэгдсэн төсвөөс санхүүжүүлж,

¹⁶⁸ Монгол дахь төлөөлөгчийн газрын албаны хүмүүстэй уулзаж тодруулсан тоо

Хүснэгт 6.37 Хөгжлийн түншүүдийн хөрөнгө оруулалт

Хөгжлийн түнш	Төслийн нэр	Үргэлжлэх хугацаа	Санхүүжилтийн дүн, америк доллароор	
			Тусламж (техникийн туслалцаа)	Зээл (төлөвлөж буй)
АХБ	Судалгааны их сургуулийн төсөл	2018-2022	800,000	30,000,000
	Шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог сайжруулах төсөл	2017-2020	600,000	
	Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх төсөл	2017-2020	600,000	
	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах төсөл	2018-2021		50,000,000
	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл	2015-2021		25,000,000
	Дээд боловсролын шинэчлэлийн төсөл	2012-2020		20,000,000
	Хүртээмжтэй боловсролд дэмжлэг үзүүлэх төсөл (төлөвлөж буй)		2,000,000	
Дэлхийн банк	Монгол Улсын хөдөө орон нутгийн эмзэг бүлгийн залуусыг дэмжих "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох" төсөл	2019-2023	2,750,000	
	Боловсролын чанарын шинэчлэлийн төсөл	2014-2020		30,000,000
НҮБ-ын Хүн амын сан	Өсвөр насныхан ба залуус	2017-2021	9,300,000	
НҮБ-ын Хүүхдийн сан	Хүүхдийн эрүүл мэнд, хөгжил	2017-2021	8,702,000	
	Хүртээмжтэй, эрүүл, чанартай сургалтын орчин	2017-2021	9,720,000	
ГОУХАН (ГИЗ)	Түншлэлд суурилсан МБС-ын төсөл	2019-2022	6,000,000	
	Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх гагнуурын хөтөлбөр бий болгох стратегийн түншлэл (ХНХЯ)	2019-2021	1,200,000	
	Барилгын салбарын чадавхыг сайжруулах стратегийн түншлэл (ХНХЯ; БХБЯ)	2019-2022	2,180,000	
	Ур чадвар хөгжүүлэх глобал төсөл (МБС-ын дэд бүтэц TVET)	2018-2020	4,350,000	
ЕХ	Хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжих олон жилийн хөтөлбөр	2014-2020	33,215,482	
ЖАЙКА	Инженерийн боловсролыг хөгжүүлэх төсөл	2018-2020		69.370,000
	Улаанбаатар хотын бага, дунд боловсролыг сайжруулах төсөл		Тусламж	
ШХА	Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн багш сургах материалыг хөгжүүлэх хөдөөгийн боловсролыг дэмжих төсөл		Хамтын ажиллагааны хөтөлбөр	
	Тогтвортой хөгжлийн боловсрол 2 дахь үе шат	2019-2022	1,055,525	
ШХА	МБС-ын төслийн III үе шат (VET III) "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь"	2019-2020	2,052,000	
КОЙКО	Боловсролын хөтөлбөр (2020 оноос эхлэн боловсролын салбарт төсөл хэрэгжүүлэхгүй)	2016-2020	3,780,000	
Австрали	(Түншлэлд суурилсан МБС-ын төсөл) – хамтарсан санхүүжилт	2019-2022	905,000	
ЮНЕСКО				
	Нийт дүн		89,210,007	224,370,000

БСХДХТ-ний тэргүүлэх зорилго, хөтөлбөрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаануудыг улсын төсвөөр санхүүжүүлж зарим үйл ажиллагааг олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл хэлбэртэйгээр зохион

байгуулах нь оновчтой юм.

V бүлэгт дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Хүснэгт 6.38 БСХДХТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, сая төгрөг

№	Дэд салбар	2021	2022	2023	2024	2025	Бүгд
1	Салбар дамнансан	9,929.29	12,045.23	13,160.85	13,344.09	13,052.37	61,531.82
1.1	Урсгал зардал	4,154.29	6,270.23	6,835.85	6,457.89	6,744.24	30,462.49
1.2	Хөрөнгийн зардал	5,775.00	5,775.00	6,325.00	6,886.20	6,308.13	31,069.33
2	СӨБ	12,453.56	12,454.73	11,919.27	11,826.27	11,800.12	60,453.95
2.1	Урсгал зардал	2,453.56	2,454.73	1,919.27	1,826.27	1,800.12	10,453.95
2.2	Хөрөнгийн зардал	10,000.00	10,000.00	10,000.00	10,000.00	10,000.00	50,000.00
3	БДБ	22,810.36	22,401.19	25,947.51	32,017.42	40,701.05	143,877.53
3.1	Урсгал зардал	2,810.36	2,401.19	5,947.51	12,017.42	20,701.05	43,877.53
3.2	Хөрөнгийн зардал	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00	100,000.00
4	МБС	6,033	8,384	8,709	8,761	11,978	43,865
4.1	Урсгал зардал	3,283	2,718	2,810	3,011	3,228	15,050
4.2	Хөрөнгийн зардал	2,750	5,666	5,899	5,750	8,750	28,815
5	Дээд боловсрол	3,320	4,063	11,381	12,150	13,099	44,013
5.1	Урсгал зардал	3,320	4,063	3,067	3,171	3,401	17,022
5.2	Хөрөнгийн зардал	0	0	8,314	8,979	9,698	26,991
	НИЙТ	54,545.9	59,348.0	71,118.4	78,099.2	90,630.4	353,741.9
	Урсгал зардал	16,020.85	17,907.03	20,580.02	26,483.79	35,874.67	116,866.4
	Хөрөнгийн зардал	38,525.00	41,441.00	50,538.38	51,615.43	54,755.70	236,875.5

Эх сурвалж: судлаачийн тооцоо

БСХДХТ-г 2021-2025 онд хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал 353.7 тэрбум төгрөг

болж нэмэгдэх тул өмнөх хэсэгт тооцоолсон санхүүжилт дараах байдлаар өөрчлөгдөнө.

Хүснэгт 6.39 Монгол Улсын боловсролын салбарт шаардагдах санхүүжилт, тэрбум төгрөг

Зардал	2021	2022	2023	2024	2025
Боловсролын салбарт шаардагдах санхүүжилт (БСХДХТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардал ороогүй)	2,943.32	2,881.51	3,147.06	3,390.98	3,689.07
Урсгал зардал	2,135.38	2,362.04	2,619.40	2,855.64	3,092.38
Хөрөнгийн зардал	807.94	519.47	527.66	535.34	596.69
Урсгал зардлын эзлэх хувь	72.55%	81.97%	83.23%	84.21%	83.83%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	27.45%	18.03%	16.77%	15.79%	16.17%
БСХДХТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардал	54.6	59.4	71.2	78.1	90.6
Урсгал зардал	16.0	17.9	20.6	26.5	35.9
Хөрөнгийн зардал	38.6	41.5	50.6	51.6	54.7
Урсгал зардлын эзлэх хувь	29.4%	30.2%	28.9%	33.9%	39.6%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	70.6%	69.8%	71.1%	66.1%	60.4%
Боловсролын салбарт шаардагдах НИЙТ санхүүжилт	2,997.92	2,940.91	3,218.26	3,469.08	3,779.67
Урсгал зардал	2,151.38	2,379.94	2,640.00	2,882.14	3,128.28
Хөрөнгийн зардал	846.54	560.97	578.26	586.94	651.39
Урсгал зардлын эзлэх хувь	71.8%	80.9%	82.0%	83.1%	82.8%
Хөрөнгийн зардлын эзлэх хувь	28.2%	19.1%	18.0%	16.9%	17.2%

Эх сурвалж: судлаачийн тооцоо

Боловсролын салбарт дутагдах нөөцийн тооцоог дараах хүснэгтүүдэд харуулж байна.

Хүснэгт 6.40 Боловсролын салбарын урсгал болон хөрөнгийн зардал, эзлэх хувь ба тэрбум төгрөгөөр


Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025
Боловсролын салбарын зардал, тэрбум төгрөг	2,015.29	2,300.20	2,640.96	2,965.20	3,352.76
Боловсролын салбарт шаардагдах НИЙТ санхүүжилт, тэрбум төгрөг	2,997.92	2,940.91	3,218.26	3,469.08	3,779.67
Шаардагдах санхүүжилтэд улсын төсвийн эзлэх хувь	67.22	78.21	82.06	85.48	88.71
Дутагдах санхүүжилт, хувь	32.78	21.79	17.94	14.52	11.29
Дутагдах санхүүжилт, тэрбум төгрөг	982.63	640.71	577.3	503.88	426.91

Эх сурвалж: судлаачийн тооцоо

БСХДХТ-г хэрэгжүүлэх нэмэгдэл зардлыг тооцоолоход манай улсын боловсролын салбарт 11.29-32.78 хувийн санхүүжилтийн дутагдал үүсэхээр байна. Үүнийг олон улсын төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлж шийдвэрлэхээс өөр боломжгүй юм.

БСХДХТ-д тусгагдсан дараах хөтөлбөр, үйл ажиллагаануудыг олон улсын байгууллагуудын төслөөр хэрэгжүүлэх нь илүү үр дүнд хүрч болно. Үүнд:

1. Орон нутгийн бүх шатны сургалтын байгууллагын хүний нөөц тэр дундаа багш нарын чадавх бэхжүүлэх, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах төсөл
2. Боловсролын бүх түвшний багш, суралцагч нарт зориулсан уян хатан онлайн, зайн, холимог гэх мэт дэвшилтэт хэлбэрийн сургалтын агуулгыг боловсруулах, түгээх, хэрэгжүүлэх төсөл
3. Бүх нийтийн насан туршдаа суралцахуйг дэмжсэн цогц төсөл



**ДОЛОО. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021-2025
ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ**

ДОЛОО. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН 2021–2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭ

7.1. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1.1. Хяналт шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчин

БСХДХТ-ний хэрэгжилтэд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн тавдугаар бүлгийн 21 дүгээр зүйлд заасны дагуу БСХДХТ-ний хэрэгжилтэд дараах үе шатаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Үүнд:

1. Мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;
2. Зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;
3. Биелэлтийн үр нөлөөг үнэлэх;
4. Гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;
5. Төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;
6. Биелэлтийн түвшинг үнэлэх;
7. Бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах.

БСХДХТ-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр үйлийн 21.4-д зааснаар Засгийн газраас баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах журмыг баримтлах ба Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд, захиргааны байгууллагын үйл

ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын зургаадугаар зүйлд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний төрөл арга зүйг ашиглана.

Засгийн газрын 2020 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхой заасан.

БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь салбарын хөгжлийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, төсөв, төсөл, хөтөлбөрийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, салбарын үйл ажиллагааг эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар бүх талын мэргэжлийн дэмжлэгийг үзүүлэх чиг үүргийн хүрээнд 3 мэргэжилтэн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт болон байгууллагуудын хяналт шинжилгээ, үнэлгээг хариуцан ажиллаж байна.

Хүснэгт 7.1 Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын бүтэц, орон тоо

Албан тушаал	Тоо	Ажлын чиг үүрэг
1 Дарга	1	Салбарын ХШҮДА-ыг ерөнхий удирдлагаар хангах
2 Ахлах мэргэжилтэн	1	Бага, дунд боловсролын салбарын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан
3 Мэргэжилтэн	1	Сургуулийн өмнөх боловсролын салбарын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан
3 Мэргэжилтэн	1	Дээд боловсрол, шинжлэх ухаан, инноваци, технологийн салбарын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан
4 Дотоод аудитор	1	Салбарын хэмжээнд төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, арга хэмжээ, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр арга хэмжээний зарцуулалт
5 Дотоод аудитор	1	Салбарын санхүү, хөрөнгө оруулалтын дотоод аудит

Энэ нэгж нь салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, салбарын болон яамны санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх, дотоод аудит хийх, салбарын бодлогыг үр дүнтэй болгох чиглэлээр зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, салбарын байгууллага, аж ахуйн нэгж байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь яамд, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яамд, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд байна¹⁶⁹.

ХНХЯ нь өөрт хамаарах чиг үүргийн хүрээнд МБС-ын салбарын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг дүгнэж тайлагнана. ХНХЯ-ны хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэх нэгж нь бүтэц зохион байгуулалтын хувьд БШУЯ-тай ижил ХШУДАГ нь хэрэгжүүлнэ. ХНХЯ-ны ХШУДАГазар нь МБС-ын бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг дүгнэж тайлагнадаг. МБС-ын Үндэсний зөвлөл нь салбарын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж, холбогдох санал зөвлөмжийг хүргүүлдэг байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу яам тус бүр салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг тогтоосон хугацаанд Засгийн газарт хүргүүлнэ.

Хүснэгт 7.2 БШУЯ болон яамны харьяа байгууллагуудын ХШҮ-ний чадавх

Байгууллага	Нэгж	Ажилтан	Ажлын чиг үүрэг
БШУЯ	ХШУДАГ	Боловсролын салбар хариуцсан 3 мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> Бага, дунд боловсролын салбарын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан Сургуулийн өмнөх боловсролын салбарын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан Дээд боловсрол, шинжлэх ухаан, инноваци, технологийн салбарын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан
БХ	Захиргаа, удирдлагын нэгж	1 ажилтан	<ul style="list-style-type: none"> Байгууллагын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ
БМДИ	Бүртгэл, төлөвлөлт, мэдээллийн алба (БТМА)	2 ажилтан	<ul style="list-style-type: none"> Сургалт, мэдээллийн бүртгэл, төлөвлөлт Байгууллагын үйл ажиллагааны ХШҮ
БҮТ	Шалгалт, судалгаа хариуцсан хэлтэс (ШСХХ)	1 ажилтан	<ul style="list-style-type: none"> Элсэлтийн шалгалт хөгжүүлэлт, судалгаа Дээд боловсролын шалгалт хөгжүүлэлт, судалгаа Чанарын баталгаажуулалт ба ХШҮ
БМИҮЗ	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
БСУГ	Захиргаа	1 ажилтан	<ul style="list-style-type: none"> Дотоод үйл ажиллагаа, захиргааны чиг үүрэг Байгууллагын үйл ажиллагааны ХШҮ
ДБСБ	ХШҮ нэгж	2-3 ажилтан	<ul style="list-style-type: none"> Байгууллагын үйл ажиллагааны ХШҮ
ЕБС, цэцэрлэг	Дотоод хяналтын ажлын хэсэг	3 хүртэл багш нар	<ul style="list-style-type: none"> Байгууллагын үйл ажиллагааны ХШҮ

¹⁶⁹ Засгийн газрын 267 дугаар тогтоол 2017 онд батлагдсан

МБС-ын үйл ажиллагаанд:

Хүснэгт 7.3 МБС-ын байгууллагуудын ХШҮ-ний чадавх

Байгууллага	Нэгж	Ажилтан	Ажлын чиг үүрэг
ХНХЯ	ХШҮДАГ	1 мэргэжилтэн	• Хөдөлмөрийн харилцаа болон МБС-ын бодлогын хэрэгжилтийн хяналт, шинжилгээ, үнэлгээ
МБС-ын ҮАМТ	Захиргаа	1 ажилтан	• Байгууллагын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ
ПТК, МСҮТ	Захиргаа, удирдлага	1 ажилтан	• Байгууллагын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит

БСХДХТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд дээрх эрх зүйн орчин болон ХШҮ-ний одоогийн бүтэц зохион байгуулалт нь хангалтгүй тул холбогдох яамд, салбарын донор байгууллага, иргэний нийгмийн байгууллагын гишүүнчлэл

бүхий Орон нутгийн боловсролын бүлэг¹⁷⁰ (Local Education Group), мэргэжлийн холбоод, сургалтын байгууллага болон мэргэжлийн судлаач, шинжээчдийн төлөөллийн оролцоотойгоор хөндлөнгийн хяналт, үнэлгээг хэрэгжүүлнэ.

7.1.2. ХШҮ-ний үйл ажиллагаа

БСХДХТ-ний хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээг БШУЯ-ны болон ХНХЯ-ны ХШҮДАГ хариуцна. Байгууллагын захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргах бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж эхний хагас жилд явцын хяналт-шинжилгээ, жилийн эцэст хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бөгөөд хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох газар, хэлтэс, албан хаагчид хүргүүлж, биелэлтийг хангуулах ба дараагийн улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

Жилийн үнэлгээг тухайн жилд хэрэгжилтэд тулгарсан хүндрэлүүдийг тодорхойлох, төлөвлөгөөний зорилгуудын хэрэгжилтэд гарсан ахицыг системтэйгээр үнэлэхийн тулд хийнэ. Хөтөлбөр тус бүрийн хүрсэн үр дүнг жилийн болон дунд хугацааны хүлээгдэж буй үр дүн, зорилтуудтай харьцуулна. БШУЯ-ны

Бодлого төлөвлөлтийн газар тухайн жилийн үнэлгээг хариуцна.

Дунд хугацааны үнэлгээг хүрсэн үр дүн, тулгарсан бэрхшээлийг нарийвчлан авч үзэж төлөвлөгөөний 2 дахь үе шат буюу 2026-2030 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах, шаардлагатай бол хөтөлбөр, зорилтуудад өөрчлөлт оруулах зорилгоор 2025 онд хийнэ. Үнэлгээ хийж, тайлан бэлтгэх ажлыг БШУЯ, ХНХЯ хариуцах ч нэмэлтээр хөндлөнгийн үнэлгээний баг, яамны мэргэжилтнүүд болон гаднын үнэлгээний мэргэжилтнүүдээс бүрдсэн багаар үнэлгээ хийлгэх хэрэгтэй.

Эцсийн үнэлгээний бодитой байдлыг нэмэгдүүлэхийн тулд гаднын экспертүүдээр хийлгэх хэрэгтэй бөгөөд хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөллөөс гадна хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагуудыг оролцоог хангавал зохино.

Боловсролын дэд салбар тус бүрийн ХШҮ-ний мэдээллийг цуглуулахдаа дараах түүвэр судалгаа нэмж хийх шаардлагатай байна. Үүнд:

¹⁷⁰ Энэхүү бүлэг нь БСХДХТ-ний боловсруулалтын явцад байгуулагдсан.

Хүснэгт 7.4 Түүвэр судалгаа ба үнэлгээ, СӨБ

№	Судалгааны нэр	Давтамж	Хариуцах эзэн
1	5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаа	Жил бүр	БХ-ийн БХСС
2	Эцэг, эхийн ур чадварыг үнэлэх суурь үнэлгээ	3 жил тутам	БХ-ийн ХХСС
3	Эцэг, эх нь боловсролын хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн хөгжилд гарсан ахицыг үнэлэх судалгаа	Жил бүр	БХ-ийн ХХСС
4	0-5 настай хүүхдийн цогц хөгжлийн судалгаа	3 жил тутам	БХ-ийн ХХСС
5	Хувилбарт сургалтын хэрэгжилтийн судалгаа	3 жил тутам	БХ-ийн БХСС

Хүснэгт 7.5 Түүвэр судалгаа ба үнэлгээ, БДБ

№	Судалгааны нэр	Хугацаа	Хариуцах эзэн
2	6-18 настай хүүхдийн цогц хөгжлийн судалгаа	3 жил тутам	БХ-ийн ХХСС
3	Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэгцээний үнэлгээ	Жил бүр	БСУГ/БХ
4	Сургуулийн хоол хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрт хамрагдсан эцэг, эхийн судалгаа	Жил бүр	Сургуулиуд
5	Сурах бичгийн хэрэглээний судалгаа	2 жил тутам	БХ-ийн СБСОСС
6	Төрөлжсөн ахлах сургуулийн хэрэгцээний үнэлгээ	2021	БХ-ийн БХСС, СБСОСС
7	Сургуулийн байршил, бүтэц, төрлийг тодорхойлох зураглалын судалгаа	2022	БШУЯ-ны БТГ, ЕБГ, БХ-ийн БХСС, СБСОСС

Хүснэгт 7.6 Түүвэр судалгаа ба үнэлгээ, МБС, ДБ

№	Судалгааны нэр	Хугацаа	Хариуцах эзэн
1	Төгсөгчдийн мөшгөх судалгаа	Жил бүр	ХЭБСС, ХНХСИ
2	Хөдөлмөр эрхлэх ур чадварын судалгаа	2 жил тутам	ХЭБСС, ХНХСИ
3	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа	Жил бүр	ХЭБСС, ХНХСИ

Дараах хүснэгтэд ХШҮ-ний үйл ажиллагааг нэгтгэн харуулав.

Хүснэгт 7.7. ХШҮ-ний үйл ажиллагаа

	Давтамж	Зорилго	Агуулга/ хамрах хүрээ	Хариуцах эзэн	Хэнд тайлагнах
Явцын ахицын тайлан/хөтөлбөр, үйл ажиллагааны явцын дотоод хяналт-шинжилгээ	Улирал тутам	Газруудын төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэх	Нөөц, үйл ажиллагаа	БШУЯ, ХНХЯ-ны ХШҮДАГ	БШУЯ-ны СӨБГ, ЕБГ, ДБГ, ХНХЯ-ны МБСБХЗГ
Жилийн гүйцэтгэлийн тайлан/жилийн үнэлгээ	Жил бүр	Жилийн үнэлгээг төлөвлөгөө хэрэгжсэн тухайн жилд хэрэгжилтэд тулгарсан хүндрэлүүдийг тодорхойлох, төлөвлөгөөний зорилгуудад хүрэх чиглэлд гарсан ахицыг системтэйгээр үнэлэх	Жилийн үйл ажиллагаа, зорилт	БШУЯ-ны БТГ	Сайд, дэд сайд, ТНБД, хөгжлийн түншүүд, ИНБ-ууд

Дунд хугацааны үнэлгээ/үнэлгээний тайлан	2025	Хүрсэн үр дүн, тулгарсан бэрхшээлийг нарийвчлан авч үзэж төлөвлөгөөний 2 дахь үе шат буюу 2026-2030 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах, шаардлагатай бол хөтөлбөр, зорилтуудад өөрчлөлт оруулах	Үр дүн, зорилт	БШУЯ, ХНХЯ, хөндлөнгийн үнэлгээний мэргэжилтнүүд	Сайд, дэд сайд, ТНБД, хөгжлийн түншүүд, ИНБ-ууд
Эцсийн үнэлгээ/тайлан	2030 оноос хойш	Эцсийн үр дүн, нөлөө, тэдгээрийн ач холбогдол, үр дүнтэй байдал, үр ашиг болон тогтвортой байдлыг авч үзэх төдийгүй яагаад зарим үр дүнгүүдэд амжилттай хүрсэн байхад заримд нь хүрч чадаагүйг шинжилж бодлогын шинэчлэл, дараагийн төлөвлөлтийн мөчлөгт зориулсан сургамжийг тодорхойлох	Үр дүн, нөлөө, ГШҮ	Гаднын экспертүүд, БШУЯ, ХНХЯ, хөгжлийн түншүүд, ИНБ-ууд	Сайд, дэд сайд, ТНБД, Орон нутгийн боловсролын бүлэг

7.2. ТУЛГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах эрсдэлүүдтэй тулгарч болохыг анхаарч түүнийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

1. Эдийн засгийн гүйцэтгэл муу, тогтворгүй байхаас шалтгаалан боловсролын салбарт хийх төсвийн санхүүжилт хангалтгүй байх
2. Улсын төсөвт боловсролын төсвийн эзлэх хувь 20-д хүрэхгүй байх
3. Улс төрийн нөхцөл байдал ойр ойрхон өөрчлөгдөх, засаглалын тогтворгүй байдал
4. Байгалийн гамшиг
5. Улс төрийн тогтворгүй байдал болон санхүүжилтийн нөөцийн хомсдолоос шалтгаалан тэргүүлэх зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг хойшлуулах
6. Нийгмийн онцгой нөхцөл байдал, гамшиг, КОВИД-19 гэх мэт цар тахал.
Дээрх нөхцөл байдал БСХДХТ-ний хэрэгжилтийг удаашруулах эсвэл зогсоож, хүссэн үр дүндээ хүрэхгүй байх эрсдэлийг бий болгоно. Үүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай.

Хүснэгт 7.8 Хэрэгжилтийн явцад тулгарч болох эрсдэл, түүнийг бууруулах арга зам

Эрсдэл	Бууруулах арга зам	Хариуцан эзэн
1. Эдийн засгийн гүйцэтгэл муу, тогтворгүй байхаас шалтгаалан боловсролын салбарт хийх төсвийн санхүүжилт хангалтгүй байх	<ul style="list-style-type: none"> Хэрэгцээнд суурилсан санхүүжилтийн хатуу зарчмыг хэрэглэх Боловсролын салбарын донор байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, төсвийн бус зардлыг багасгаж, төсвийн зардалд донор байгууллагын дэмжлэгийг нэмэгдүүлэх Санхүүгийн сахилга батыг нэмэгдүүлэх чиглэлээр засаглал, хариуцлагыг чангатгах Хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хэрэгжүүлнэ 	БТГ, СЭЗГ, БШУЯ МБСБХЗГ, ХНХЯ
2. Улсын төсөвт боловсролын төсвийн эзлэх хувь 20-д хүрэхгүй байх	<ul style="list-style-type: none"> Донор байгууллагын дэмжлэгийг төлөвлөгөөний санхүүжилт, хөрөнгө оруулалтад түлхүү авах Салбарын хөрөнгө оруулалтын төсвийг багасгах 	БТГ, СЭЗГ, БШУЯ
3. Улс төрийн нөхцөл байдал ойр ойрхон өөрчлөгдөх, засаглалын тогтворгүй байдал	<ul style="list-style-type: none"> Холбогдох хуулийг хэрэгжүүлэх 	БТГ, БШУЯ МБСБХЗГ, ХНХЯ
4. Байгалийн гамшиг	<ul style="list-style-type: none"> Боловсролын салбарын онцгой байдлын үеийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх Боловсролын мэргэжлийн болон сургалтын байгууллагын эрсдэл болон гамшгийн зураглал хийх Байгууллагын удирдлага, ажилтан албан хаагч болон багшийн чадавхыг эрсдэл, гамшгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хариу үзүүлэхэд бэлэн байх чиглэлээр чадавхыг бэхжүүлэх Нээлттэй, онлайн сургалтын нөөц, эх үүсвэртэй болох 	МУЗГ; БТГ, БШУЯ МБСБХЗГ, ХНХЯ БМДИ
5. Улс төрийн тогтворгүй байдал болон санхүүжилтийн нөөцийн хомсдолоос шалтгаалан тэргүүлэх зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийг хойшлуулах	<ul style="list-style-type: none"> Төлөвлөгөөний тэргүүлэх зорилтыг салбарын аливаа шинэчлэлийн байр суурьтай авч үзэх Салбарын түвшний харилцааны стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилттэй байх 	БТГ, СЭЗГ, БШУЯ; МБСБХЗГ, ХНХЯ;
6. Нийгмийн онцгой нөхцөл байдал, гамшиг, КОВИД-19 гэх мэт цар тахал	<ul style="list-style-type: none"> Төлөвлөгөөнд аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлтэй холбоотой стратегийг нэмж тусгах Нээлттэй, онлайн сургалтын нөөц, эх үүсвэртэй болох 	БТГ, СЭЗГ, БШУЯ; МБСБХЗГ, ХНХЯ;

7.3 ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

Дараах хүснэгтэд БСХДХТ-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг хийхэд ашиглагдана. Төлөвлөгөөний 2025, харуулсан бөгөөд эдгээр нь төлөвлөгөөний 2030 онд хүрэх үр дүнг дэд салбар бүрээр зорилго, дэд салбаруудын зорилтуудын Хавсралт 2-т үзүүлэв.

Хүснэгт 7.9 Салбар дамнасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Чиглэл	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2025)	Зорилтот түвшин (2030)	Эх сурвалж	Давтамж	Хариуцах эзэн
Чанар	Эрүүл мэнд, суралцахуй, сэтгэл зүй-нийгмийн хөгжлөөр хэвийн байгаа 5 хүртэлх настай хүүхдийн эзлэх жин, хүйсээр	Бэлэн бус	80%, хүйс, байршлаар	100%, хүйс, байршлаар	Хүүхэд хөгжлийн судалгааны тайлан	3 жил тутам	БХ-ийн ХХСС
	Тоо, унших чадварын наад захын түвшнийг хангаж бага боловсрол эзэмшсэн хүүхэд, залуучуудын эзлэх жин, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай	80%, хүйс, байршлаар	100%, хүйс, байршлаар	5-р ангийн математик, унших чадварын үнэлгээний тайлан	Жил бүр	БҮТ-ийн ШСХХ
	Тоо, унших чадварын наад захын түвшнийг хангаж суурь боловсрол эзэмшсэн хүүхэд, залуучуудын эзлэх жин, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай	80%, хүйс ба байршлаар	100%, хүйс ба байршлаар	9-р ангийн математик, унших чадварын үнэлгээний тайлан	Жил бүр	БҮТ-ийн ШСХХ
	Ур чадвар нь ажил олгогчдын шаардлагад нийцсэн МБС-ын төгсөгчдийн эзлэх жин	Тодорхойлох шаардлагатай	50%	80%	Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан	Жил бүр	ХНХСИ-ийн ХЭБСС
	Ур чадвар нь ажил олгогчдын шаардлагад нийцсэн ДБ-ын төгсөгчдийн эзлэх жин	Тодорхойлох шаардлагатай	50%	80%	Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан	Жил бүр	ХНХСИ-ийн ХЭБСС
	Боловсролын удирдлагын чадавх бэхжүүлэхэд сургалтад хамрагдсан сургуулийн захирлуудын эзлэх жин, хүйс, байршлаар	Тодорхойлох шаардлагатай	80%	100%	БМДИ-ийн тайлан, их дээд сургуулиудын тайлан	Жил бүр	БМДИ-ий ХШҮ-ний ажилтнууд
	Сургуулийн удирдлагын тогтвортой байдал, хүйс, байршлаар	Тодорхойлох шаардлагатай	80%	100%	БМДИ-ийн тайлан, их дээд сургуулиудын тайлан	Жил бүр	БМДИ-ий ХШҮ-ний ажилтнууд
Хүртээмж	Албан ба албан бус боловсролд хамрагдсан хувь (танхим, онлайн, нээлттэй, зайн)	Бэлэн бус	65%	100%	БУМС-ын тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ
	Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшингээр)	Цэцэрлэг – 33 ЕБС хот – 35 хөдөө - 28	25-30	20-25	БУМС тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ
	Тэгш байдлын индекс, хүйс ба түвшингээр	Бэлэн бус	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай	БУМС-ын тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ
	Хамран сургалтын бохир жин, түвшин, хүйс, байршлаар	Бэлэн бус	100%	100%	БУМС-ын тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ

	Анги дэвшилтийн хувь, хүйс, түвшингээр	Бэлэн бус	100%	100%	БУМС-ын тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШУДАГ
	Шилжилтийн хувь, хүйс ба түвшингээр	Бэлэн бус	100%	100%	БУМС-ын тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШУДАГ
Удирдлага, зохион байгуулалт	Мэргэжлийн байгууллагуудын бүтцийг өөрчлөх сайдын тушаал	Бэлэн бус	Журам батлагдсан байна	-	БШУЯ-ны тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШУДАГ
	Мэргэжлийн байгууллагын сургалтад хамрагдсан ажилтнуудын эзлэх жин	13%	60%	100%	БШУЯ-ны тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШУДАГ

Хүснэгт 7.10 СӨБ-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Чиглэл	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2025)	Зорилтот түвшин (2030)	Эх сурвалж	Давтамж	Хариуцах эзэн
Чанар	Бага сургуульд бэлтгэгдсэн 5 настай хүүхдийн эзлэх жин, хүйс, байршлаар	Тодорхойлох шаардлагатай, хүйс, байршлаар	80%, хүйс, байршлаар	100%, хүйс, байршлаар	Судалгаа/ СӨБ-ын байгууллагууд	Жил бүр	БҮТ-ийн ҮХХ
	СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин (хүйс, хот, хөдөөгөөр)	81.5	89.4		Судалгаа/ СӨБ-ын байгууллагууд	Жил бүр	БШУЯ-ны СӨБГ, МТСХ ҮСХ
Хүртээмж	5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт	90.1	100	100	Судалгаа/ СӨБ-ын байгууллагууд		СӨБГ, МТСХ
	Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	34.1	25	20	Судалгаа/ СӨБ-ын байгууллагууд		СӨБГ, МТСХ
	Бага орлоготой өрхийн хүүхдүүдийн хамран сургалтын бохир жин, хүйсээр	34%, хүйсээр задлах шаардлагатай	50%, хүйсээр задлах шаардлагатай	60%, хүйсээр задлах шаардлагатай	Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа		БШУЯ-ны СБГ, МТСХ
	Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн хамран сургалтын бохир жин, хүйсээр	Бэлэн бус	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр	Өрхийн нийгэм-эдийн засгийн судалгаа		БШУЯ-ны ТХБХ
Удирдлага, зохион байгуулалт	Бодлогын судалгааны сантай эсэх	Бэлэн бус	Сантай болсон байна	-	БШУЯ-ны тайлан	Нэг удаа	БШУЯ-ны СӨБГ, МТСХ
	Дотоод үнэлгээ хийсэн цэцэрлэгийн эзлэх жин	Бэлэн бус	50%	100%	Цэцэрлэгүүдийн тайлан	Жил бүр	

Хүснэгт 7.3.1. БДБ-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Чиглэл	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2025)	Зорилтот түвшин (2030)	Эх сурвалж	Давтамж	Хариуцах эзэн
Чанар	Олон улсын суралцагчийн үнэлгээний хөтөлбөр буюу PISA-ийн үр дүн, хүйс, байршил, сургуулийн хэв шинжээр	Бэлэн бус, PISA 2022-д үнэлэгдэнэ.	Тодорхойгүй	Тодорхойгүй	PISA 2023, 2026 үнэлгээний тайлан	3 жил тутам	Шалгалт судалгааны нэгж, БҮТ
	7-14 настай хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох)	61.6 51.5	70	80	БҮТ-ийн тайлан	5 жилд нэг удаа	ШСН, БҮТ
	Казак, тува суралцагчийн 12 дугаар ангийн төгсөлтийн монгол хэлний шалгалтын үндэсний дундаж, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр	Үндэсний дундаж 70%-аас доошгүй	Үндэсний дундаж 70%-аас доошгүй	БҮТ-ийн Монгол хэлний төгсөлтийн шалгалтын тайлан	Жил бүр	ШСН, БҮТ

	5 дугаар ангийн хот, хөдөөгийн суралцагчийн математик хичээлийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа, байршил, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр	5 дугаар ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа 15%-иас ихгүй	5 дугаар ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа 5%-иас ихгүй	БҮТ-ийн 5 дугаар ангийн тайлан	Жил бүр	ШСН, БҮТ
	9 дүгээр ангийн хот, хөдөөгийн суралцагчийн математик хичээлийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа, байршил, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр	9 дугаар ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа 10%-иас ихгүй	9 дугаар ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа 5%-иас ихгүй	БҮТ-ийн 9 дугаар ангийн тайлан	Жил бүр	ШСН, БҮТ
	12 дугаар ангийн хот, хөдөөгийн суралцагчийн математик хичээлийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа, байршил, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр	12 дугаар ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа 15%-иас ихгүй	12 дугаар ангийн суралцагчийн гүйцэтгэлийн дунджийн ялгаа 10%-иас ихгүй	БҮТ-ийн 12 дугаар ангийн тайлан	Жил бүр	ШСН, БҮТ
Хүртээмж	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, хүйсээр	90.44	100%	100%	БУМС-ийн тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин, хүйсээр, хот хөдөөгөөр	94.9	95.9	100%	БУМС-ийн тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	31.1 34.4 – хот 28.5 - хөдөөд	25 Хот – 30 Хөдөө - 25	20 Хот – 25 Хөдөө - 20	БУМС-ийн тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
	Бага ангид элссэн тусгай хэрэгцээт суралцагчийн хамран сургалтын цэвэр жин, хүйс, байршлаар	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр, байршлаар	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр, байршлаар	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр, байршлаар	БУМС-ийн тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
	Дунд ангид элссэн тусгай хэрэгцээт суралцагчийн хамран сургалтын цэвэр жин, хүйс, байршлаар	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр, байршлаар	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр, байршлаар	Тодорхойлох шаардлагатай, хүйсээр, байршлаар	БУМС-ийн тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
	Түрээсийн төлбөрийн сангийн санхүүжилтээр нөхөн хэвлэсэн сурах бичгийн эзлэх жин	0%	60%	100%	БШУЯ-ны тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
Удирдлага, зохион байгуулалт	Бага боловсролын дотоод үр ашгийн коэффициент	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай	БУМС-ийн тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
	Дунд боловсролын дотоод үр ашгийн коэффициент	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай	БУМС-ийн тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ
	Төрөлжсөн ахлах сургуулийн тоо	Бэлэн бус	УБ хотод 3, бүсүүдэд 2	УБ хотод 9, бүсүүдэд 10	БШУЯ-ны тайлан/БСУГ-ын тайлан	Жил бүр	ХШҮДАГ, БШУЯ


Хүснэгт 7. 11. МБС-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Чиглэл	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2025)	Зорилтот түвшин (2030)	Эх сурвалж	Давтамж	Хариуцах эзэн
Чанар	Суур боловсрол төгсөгчдөөс МБС-ын хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдын эзлэх хувь	20%	25%	30%	МБС-ын статистик тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	Техникийн боловсрол сургалтаар мэргэшлийн 5-6 дугаар түвшин эзэмшсэн (ISCED 4 ба 5 түвшин) 25-64 насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь	МБС-ын нийт төгсөгчдийн мэргэжлээр хөдөлмөр эрхлэлт 44%	50%	70%	ХНХСИ, Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааны тайлан	Жил бүр	ХНХСИ, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор
	Богино хугацааны сургалтаар мэргэжлийн ур чадвар эзэмшсэн, мэргэшил дээшлүүлсэн 15-аас дээш насны иргэдийн ажилгүйдлийн түвшин	15-аас дээш насны иргэдийн ажилгүйдлийн түвшин 10% (улсын дүнгээр)	9%	8%	2020 оны ҮСХ-ны мэдээлэл	Жил бүр	ҮСХ
	Шинээр бэлтгэгдсэн багшийн тоо	Шинээр шаардлагатай багш 194	1082	2352	МБС-ын статистик	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	Давтан сургалтад хамрагдаж, мэргэшил дээшлүүлсэн багшийн нийт багшид эзлэх хувь	66%	80%	90%	МБСҮМАЗТ, Багшийн хөгжлийн алба	Жил бүр	ХШҮ-ний ажилтан, МБСҮМАЗТ
Хүртээмж	МБС-ын хөтөлбөрөөр суралцсан хүний эзлэх хувь (100 мянган хүнд)	1.2% орчим	2.2%	2.4%	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	Өмнөх мэдлэг ур чадварын үнэлгээний дүнд олгосон чадамжийн гэрчилгээний тоо	3200	6000	9000	МБСҮМАЗТ-ийн тайлан	Жил бүр	ХШҮ-ний ажилтан, МБСҮМАЗТ
	Тохируулгат сургалтын хөтөлбөрөөр, тохируулгат орчинд суралцсан тусгай хэрэгцээт иргэдийн нийт суралцагчдад эзлэх хувь	2% орчим	3%	4%	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	Салбар дундын дадлагын газар байгуулагдсан	Бэлэн бус	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр 3	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлээр 6	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	ХЗЗ, ажил олгогчийн эрэлтийн дагуу сургалтын тоног төхөөрөмж, бааз суурийг бэхжүүлсэн сургалтын байгууллагын тоо	6 жишиг сургууль, 7 чадамжийн төв,	10 чадамжийн төв (+АХБ-ны Гэрчилгээжүүлэлтийн төв 3)	10 чадамжийн төвийн үйл ажиллагаа тогтворжсон	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
МБС-ын хотхон сургууль төгсөгчдийн мэргэжлээр хөдөлмөр эрхлэлтийн хувь	Бэлэн бус	Тодорхойлох шаардлагатай	50%	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ	

	Нээлтэй, зайн сургалтын хөтөлбөрөөр суралцаж буй 24-64 насны суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувь	Бэлэн бус	5%	10%	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	Салбар дундын зохицуулалт бүхий МБС-ын агентлаг байгуулагдсан эсэх	Бэлэн бус	20 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдана	Үйл ажиллагаа нь тогтворжиж, чадавх бэхэжсэн	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
Удирдлага	МБС-ын салбарын мэргэжлийн байгууллагуудын мэргэшсэн мэргэжилтнүүдийн тоо	Бэлэн бус	70 хүн	Үйл ажиллагаа нь тогтворжиж, чадавх бэхэжсэн	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	БУМС-МБС-ын мэдээллийн нэгдсэн сан – ХЗЗ-ийн уялдаа холбоо бий болсон	Бэлэн бус	Механизм бүрдсэн	Мэдээллийн тасралтгүй урсгал, ашиглалт сайжирсан	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ
	Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын тоо	8	15	30	МБСБХЗГ тайлан	Жил бүр	ХШҮДАГ, ХНХЯ

Хүснэгт 7.12 ДБ-ын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Чиглэл	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин (2025)	Зорилтот түвшин (2030)	Эх сурвалж	Давтамж	Хариуцах эзэн
Чанар	Дээд боловсролын нийт багшид эзлэх докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь	30.5	45	50	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ, МТСХ
	I-III түвшнийг амжилттай төгссөн оюутнуудын эзлэх жин, хүйсээр	Бэлэн бус	80%	100%	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ, МТСХ
	Багш-оюутны харьцаа	1:23	1:19	1:15	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ, МТСХ
	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хүйсээр, мэргэжлийн чиглэлээр	Тодорхойлох шаардлагатай (Эр/Эм)	Тодорхойлох шаардлагатай (Эр/Эм)	Тодорхойлох шаардлагатай (Эр/Эм)	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ, МТСХ
Хүртээмж	10,000 хүн амд ногдох дээд боловсролтой хүн амын тоо, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай (Эр/Эм)	Тодорхойлох шаардлагатай (Эр/Эм)	Тодорхойлох шаардлагатай (Эр/Эм)	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	ҮСХ
	Хөдөө орон нутгийн оюутны эзлэх хувь, хүйсээр	Бэлэн бус	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ, МТСХ
	Цахим, онлайн, зайн сургалтын хөтөлбөрөөр суралцаж буй оюутны эзлэх жин, хүйсээр	Бэлэн бус	Тодорхойлох шаардлагатай	Тодорхойлох шаардлагатай	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ, МТСХ
Удирдлага, зохион байгуулалт	ДБҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн ДБ-ын байгууллагын эзлэх жин	Бэлэн бус	50%	95%	Дээд боловсролын удирдлага, мэдээллийн системийн тайлан	Жил бүр	БШУЯ-ны ХШҮДАГ, МТСХ



ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1

Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд зохион байгуулсан нэгдсэн болон хэсэгчилсэн уулзалт, хэлэлцүүлэгт оролцогчдын жагсаалт

